



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

# БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

---

**(2018 оны жилийн эцэс)**

2018.12.27  
Улаанбаатар хот

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ – ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

**(2018 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар)**

2018.12.27

Улаанбаатар хот

Хөтөлбөр, хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт		Хариуцах нэгж, албан тушаалтны нэр	Биелэлт, Хүрсэн түвшин (Шалгуур үзүүлэлтээр), Хэрэгжилтийн хувь
	Арга хэмжээний шалгуур үзүүлэлт (тоо, чанар хугацаа)-ийн хүрэх түвшин	Хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин		
1	2	3	4	5
<b>Нэг. “Төрийн өмчийн талаар хууль тогтоомж, бодлого, чиглэл, баримт бичгийн төсөл боловсруулах, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн засаглалыг сайжруулах удирдлага, зохион байгуулалтаар хангах” гэсэн стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:</b>				
<b>ХӨТӨЛБӨР I</b>				
<b>“Төрийн болон орон нутгийн өмчийн талаарх хууль, эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгож, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах” хөтөлбөрийн хүрээнд:</b>				
<b>Арга хэмжээ 1.1.1.</b> Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн төсөл (шинэчилсэн найруулга)-ийг батлуулах арга хэмжээ авах	<ul style="list-style-type: none"> <li>- Хуулийн төслийн боловсруулалтыг сайжруулах;</li> <li>- Нэмэлт судалгаа хийх;</li> <li>- Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэх;</li> <li>- Хуулийн төслийг ЗГХЭГ-т хүргүүлж, УИХ-ын Тамгын газар, Байнгын хороодод уламжлуулах арга хэмжээ авах;</li> <li>- I-III улиралд.</li> </ul>	Хууль эрх зүйн орчин боловсронгуй болно.	Захиргаа, хууль зүйн хэлтэс (цаашид “ЗХЗХ” гэх), Ажлын хэсэг	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг боловсруулж, батлуулахаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.  Уг хуулийн төслийг батлуулах зайлшгүй шаардлага болон хуулийн төсөлтэй холбоотой нийт 24 албан бичгийг ЗГХЭГ болон дээд шатны байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн.  (Хэрэгжих шатанд - 70%)
<b>Арга хэмжээ 1.2.2.</b> Төрийн болон орон нутгийн өмчийн хууль тогтоомж, бодлого, баримт бичгийн төсөл боловсруулах, батлуулах	<ul style="list-style-type: none"> <li>- Өөрчлөлт оруулах, шинээр боловсруулах эрх зүйн актын жагсаалт гаргах;</li> <li>- Хууль тогтоомж, эрх зүйн актын төсөл боловсруулах;</li> <li>- Төсөлд холбогдох байгууллагаас санал</li> </ul>	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, эрх зүйн орчин боловсронгуй болсон байна.	ЗХЗХ, Холбогдох хэлтэс, Ажлын хэсэг	Төрийн болон орон нутгийн өмчийн талаарх хууль тогтоомж, бодлого, шийдвэр, баримт бичгийн төсөл боловсруулах, батлуулах ажлын хүрээнд дараах төслийг боловсруулан Улсын Их Хурал, Засгийн газар, бусад дээд шатны холбогдох байгууллагад хүргүүлсэн:  - “Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн талаарх Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын протокол, хэлэлцээрийг соёрхон батлах

	<p>авах;</p> <ul style="list-style-type: none"> <li>- Төслийг байгууллагын цахим хуудас <a href="http://pcsp.gov.mn">http://pcsp.gov.mn</a>, дотоод сүлжээ <a href="https://www.able.mn">https://www.able.mn</a> -нд байршуулж, олон нийт болон албан хаагчдаас санал авах;</li> <li>- Холбогдох байгууллага, албан хаагч, олон нийтээс ирүүлсэн саналыг нэгтгэн судалж, үндэслэл бүхий саналыг төсөлд тусгах,</li> <li>- Төслийг газрын Даргын зөвлөлийн хурал, газрын хуралдаанаар хэлэлцүүлэх;</li> <li>- Төслийг ЗГХЭГ-т хүргүүлэх;</li> <li>- Жилдээ.</li> </ul>		<p>хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл;</p> <ul style="list-style-type: none"> <li>- Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас санаачилсан Казиногийн тухай хуулийн төсөлд тусгах санал;</li> <li>- Хууль зүй, дотоод хэргийн яамнаас боловсруулсан Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн төсөлд тусгах санал;</li> <li>- Төрийн албан хаагчийн хариуцлагын тухай хуулийн төсөлд тусгах санал;</li> <li>- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгах санал;</li> <li>- Улсын Их Хурлын “Төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” тогтоолын төсөл;</li> <li>- “Төрийн өмчийг 2018-2020 онд хувьчлах үндсэн чиглэл”-ийн төсөл;</li> <li>- “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам”-ын шинэчилсэн найруулгын төсөл;</li> <li>- Улсын Их Хурлын 2017 оны 23 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах санал.</li> </ul> <p>Дампуурлын тухай хуулийн төсөл, Шилэн дансны тухай хууль болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлын хэсэгт ТӨБЗГ-ын төлөөлөл тус тус ажилласан.</p> <p>“Паспортжуулалтын зөвлөлийн дүрэм”-ийн төслийг нийт албан хаагчдад танилцуулан, саналыг нэгтгэж, Нийслэлийн Засаг даргад, “Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн эрхийг эрхийн улсын бүртгэлд бүртгэх журам”-ын төсөлд тусгах санал боловсруулж, Улсын бүртгэлийн ерөнхий газарт тус тус хүргүүлэв.</p> <p>“Онцгой нөхцөл байдал үүссэн үед төрийн болон албаны нууцыг хамгаалах төлөвлөгөө”-ний төслийг ТЕГ-т танилцуулж, ТӨБЗГ-ын даргын А/02 дугаар тушаалаар, Нууц баримт бичгийн хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын төсөлд Тагнуулын байгууллагаас санал авч, ТӨБЗГ-ын даргын А/277 дугаар тушаалаар тус тус батлан мөрдүүлэв.</p> <p>Төрийн өмчийн хороо, “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн хамтран баталсан журмыг цаашид дагаж мөрдөх шаардлагатай эсэх талаар тус компаниас санал авахаар албан бичиг хүргүүлсэн.</p> <p>Монгол бөхийн өргөөний асуудалтай холбогдуулан “Бүрэн эрхт</p>
--	---	--	--

				төлөөлөгч” томилох талаарх хууль, эрх зүйн зохицуулалтыг судалж, үүссэн нөхцөл, зарим асуудлын талаар ТӨБЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж, ЗГХЭГ-т зохих тайлбар, санал хүргүүлэв. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2018 оны 276 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. (Хэрэгжих шатанд -70%)
<b>Арга хэмжээ 1.3.3.</b> Төрийн өмчөөс хувьчилж үл болох эд хөрөнгийн жагсаалтыг батлуулах	<ul style="list-style-type: none"> <li>- Төрийн өмчөөс хувьчилж үл болох эд хөрөнгийн жагсаалтын төслийг боловсруулах;</li> <li>- Холбогдох байгууллагаас санал авах;</li> <li>- Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэх;</li> <li>- Төслийг УИХ, ЗГХЭГ-т хүргүүлж, шийдвэрлүүлэх;</li> <li>- I улиралд.</li> </ul>	Төрийн өмчийг үл хувьчлах бодлого тодорхой болно.	Бодлого, төлөвлөлт, удирдлагын хэлтэс (цаашид “БТУХ” гэх)	<p>Төрийн өмчөөс хувьчилж үл болох аж ахуйн нэгж болон эд хөрөнгийн талаарх танилцуулга, саналын төслийг төрийн байгууллага, дэд бүтцийн салбар, хүнс, хөдөө аж ахуйн салбар, байгаль орчны салбар, боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбар, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбар, төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд ногдох хэсэг гэсэн ангиллаар гарган, УИХ-ын 1999 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өмчөөс хувьчилж үл болох эд хөрөнгийн жагсаалт”, уг жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулах талаар салбарын 12 яамнаас ирүүлсэн болон ТӨБЗГ-ын саналыг харьцуулсан судалгааг нэгтгэн дүгнэв.</p> <p>УИХ-ын “Төрийн өмчөөс хувьчилж үл болох аж ахуйн нэгж болон эд хөрөнгийн жагсаалт батлах тухай” тогтоолын төсөл боловсруулж, холбогдох материалын хамт Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн боловч Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2018 оны ХЭГ/281 дугаар албан бичгээр уг тогтоолын төслийг буцаасан.</p> <p>(Хэрэгжих шатанд – 70%)</p>
<b>Арга хэмжээ 1.4.4.</b> Төрийн өмчийг 2018-2020 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэлийг батлуулах	<ul style="list-style-type: none"> <li>- Хувьчлах, өөрчлөн байгуулах аж ахуйн нэгжийн судалгаа гаргах;</li> <li>- Төслийн танилцуулга бэлтгэж, удирдлага, газрын хуралдаанд танилцуулах;</li> <li>- Үндсэн чиглэлийн төслийг ЗГХЭГ-т хүргүүлж, УИХ-аар батлуулах арга хэмжээ авах;</li> <li>- I-II улиралд.</li> </ul>	2018-2020 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэлийн хэрэгжилтийг хангасан байна.	БТУХ	<p>Улсын Их Хурлын “Төрийн өмчийг 2018-2020 онд хувьчлах үндсэн чиглэл батлах тухай” тогтоолын төслийг холбогдох яам болон Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын саналыг авсны үндсэн дээр боловсруулж, Ерөнхий сайд, Засгийн газарт 03 дугаар сарын 21-нд хүргүүлсэн. Уг төсөлд нийт 18 хуулийн этгээдийг бүрэн хувьчлах, 19 хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувь хэмжээг бууруулах, нийт 37 хуулийн этгээдийг хувьчлах талаар тусгагдсан. Дээрх тогтоолын төсөл бүхий саналыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, 23 хуулийн этгээдийг бүрэн хувьчлах, 4 хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувь хэмжээг бууруулах, нийт 27 хуулийн этгээдийг хувьчлах саналыг 2018 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн ЗГ-1/112 дугаар албан бичгээр Улсын Их Хуралд өргөн барьсан. Улсын Их Хурал тус саналыг хэлэлцээд, Эдийн засгийн байнгын хороонд дэд ажлын хэсэг байгуулан зарим судалгаа тооцоог хийх чиглэл өгсөн. (Хэрэгжих шатанд – 70%)</p>

<p><b>Арга хэмжээ 1.5.5.</b> Төрийн өмчийг 2018 онд хувьчлах, өөрчлөн байгуулах хуулийн этгээдийн жагсаалтыг батлуулах</p>	<ul style="list-style-type: none"> <li>- 2018 онд хувьчлах, өөрчлөн байгуулах аж ахуйн нэгжийн судалгаа хийж, дүгнэлт гаргах;</li> <li>- Танилцуулга, жагсаалт, шийдвэрийн төслийг боловсруулах;</li> <li>- ТӨБЗГ-ын хуралдаанд танилцуулах;</li> <li>- ЗГХЭГ-т хүргүүлэн батлуулж, хэрэгжүүлэх;</li> <li>- II-III улиралд.</li> </ul>	<p>Төрийн өмчийн ашиглалт, төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг нэмэгдэнэ.</p>	<p>БТУХ</p>	<p>Засгийн газрын 2018 оны 08 дугаар тогтоолоор өгсөн үүргийн дагуу Улсын Их Хурлын “Төрийн өмчийг 2018-2020 онд хувьчлах үндсэн чиглэлийг батлах тухай” тогтоолын төслийг боловсруулан Засгийн газарт хүргүүлж, Улсын Их Хуралд өргөн барьсан. Эдийн засгийн байнгын хороонд дэд ажлын хэсэг байгуулагдан зарим судалгаа тооцоог хийж байна. Уг үндсэн чиглэл батлагдах хүртэл хүлээгдэж байна. (Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй – ХБ.)</p>
<p><b>Арга хэмжээ 1.6.6.</b> Төрийн өмчөөс орон нутгийн өмчлөлд эд хөрөнгө шилжүүлэх асуудлаар холбогдох байгууллагаас санал авч нэгтгэн Засгийн газар, УИХ-д танилцуулах</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Холбогдох байгууллагаас санал авч нэгтгэх;</li> <li>- Засгийн газар, УИХ-аар хэлэлцүүлэх арга хэмжээ авах;</li> <li>- Эхний хагас жилд багтаан ЗГХЭГ-т хүргүүлэх;</li> <li>- Гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;</li> <li>- Жилдээ.</li> </ul>	<p>Засгийн газраас өгсөн чиглэлийн дагуу шийдвэрлэсэн байна. Хөрөнгө шилжүүлэх ажлыг төсөвт тусгагдсан 8.5 сая төгрөгт багтаан хэрэгжүүлсэн байна.</p>	<p>Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Цаашид “ТӨБХХ” гэх)</p>	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг тооллогын дүнгийн мөрөөр авах арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд Улсын Их Хурлын “Төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газарт хүргүүлсэн. Уг тогтоолын төслийг Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн барьж, Улсын Их Хурлын Эдийн засгийн Байнгын хороо, нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн. Үр дүн: Улсын Их Хурлын 2018 оны 61 дүгээр тогтоолоор төрийн өмчөөс нийслэл, 21 аймгийн өмчид нийт 28.1 тэрбум төгрөгийн эд хөрөнгийг шилжүүлэхээр шийдвэрлэсэн.</p> <p>Орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэн хүлээлцэх ажлыг 21 аймаг, нийслэлд зохион байгуулсан бөгөөд хэрэгжилт 98.0 хувьтай байна. Хөрөнгө хүлээлцсэн ажлын тайлан дүнг нэгтгэж, Засгийн газарт танилцуулахаар бэлтгэж байна. (Бүрэн хэрэгжсэн – 100%)</p>
<p><b>Арга хэмжээ 1.7.7.</b> Төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн ажиллах жишиг журмыг боловсруулах, батлуулах</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Жишиг журмын төслийг боловсруулах;</li> <li>- Журмын төсөлд санал авах ажлыг зохион байгуулах;</li> <li>- ТӨБЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулах;</li> <li>- Журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;</li> <li>- Олон нийтэд мэдээлэх;</li> <li>- I улиралд.</li> </ul>	<p>Төрийн өмчийн эзэмшилт, ашиглалт сайжирч, өмч эзэмшигчийн хариуцлага дээшилнэ.</p>	<p>ТӨБХХ</p>	<p>Төрийн болон орон нутгийн өмчид хяналт тавьж, өмчийн эзэмшилт, ашиглалтыг сайжруулах зорилгоор ТӨБЗГ-ын 2018 оны 86 дугаар тогтоолоор “Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам”-ыг баталж, төрийн өмчит нийт байгууллагад мөрдүүлэх арга хэмжээ авав. “Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам”-ыг байгууллагын цахим хуудас <a href="http://pcsp.gov.mn">http://pcsp.gov.mn</a>-нд байршуулж, мэдээллийн ил тод байдлыг хангав.</p> <p>(Бүрэн хэрэгжсэн – 100%)</p>
<p><b>Арга хэмжээ 1.8.8.</b> Монгол Улс дахь ОХУ-</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Дэд ажлын хэсэг байгуулах;</li> </ul>	<p>Монгол Улс, ОХУ-ын</p>	<p>ТӨБХХ, ЗХЗХ</p>	<p>Монгол Улс дахь Оросын Холбооны Улсын үл хөдлөх хөрөнгийн маргаантай асуудалтай холбоотой шийдвэрлэх асуудлын төслийг</p>

<p>ын үл хөдлөх хөрөнгийн маргаантай асуудлаарх Ерөнхий сайдын захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийн ажлыг зохион байгуулах</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Ажлын хэсгийн хурал зохион байгуулах;</li> <li>- Холбогдох тооцоо, судалгаа хийж, санал боловсруулах;</li> <li>- Монгол Улс, ОХУ-ын Засгийн газар хоорондын хуралдаанд хэлэлцүүлэх арга хэмжээ авах;</li> <li>- Монгол Улс, ОХУ-ын Засгийн газар хоорондын Монголын хэсгээс өгсөн удирдамжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;</li> <li>- Жилдээ.</li> </ul>	<p>Засгийн газар хоорондын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна.</p>		<p>бэлтгэж, Монгол Улс, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын Комиссын хуралдаанд газрын дарга болон холбогдох албан хаагч оролцсон. Уг хуралдааны үеэр Оросын Холбооны Улсын Ажлын хэсэг болон холбогдох байгууллагын төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж, хэлэлцээр хийв. Монгол Улс, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрт оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд тусгах саналыг боловсруулан Гадаад харилцааны яаманд хүргүүлсэн.</p> <p>Ерөнхий сайдын захирамжаар байгуулсан ажлын хэсгийн ажлыг зохион байгуулах хүрээнд төрийн байгууллага болон иргэдээс ирүүлсэн маргаантай асуудалтай холбоотой албан бичигт хариу өгөх, шаардлагатай судалгаа, танилцуулгыг бэлтгэж хүргүүлэх ажлыг гүйцэтгэв.</p> <p>Мөн ТӨБЗГ-ын даргын 2018 оны 05 дугаар сарын 25–ны өдрийн А/171 дүгээр тушаалаар ОХУ-ын үл хөдлөх хөрөнгийн маргаантай асуудлыг судлах, санал боловсруулах, нэмэлт судалгаа, тооцоо хийх, хөрөнгийн байдалтай газар дээр нь танилцах, дүгнэлт гаргах үүрэг бүхий дэд ажлын хэсгийг байгуулж, Ерөнхий сайдын байгуулсан ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэв. Энэ хүрээнд Монгол Улс дахь ОХУ-ын үл хөдлөх хөрөнгийн маргаантай асуудлыг зохицуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн гүйцэтгэсэн ажлын товч танилцуулгыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатарт 2018 оны А-1/3889 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>Цаашид, Засгийн газар хоорондын хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах талаар хэлэлцээр хийх, ноот бичиг илгээх, хариу өгөх зэрэг асуудлууд байнгын шинжтэй үргэлжлэхээр байгаа, дипломат харилцааны шугамаар асуудлыг шийдвэрлэх шаардлагатай тул ажлын хэсгийг Гадаад харилцааны яам хариуцан ажиллах нь зохистой гэж үзэж, ЗГХЭГ, ГХЯ-нд холбогдох саналыг хүргүүлсэн. Одоогоор ажлын хэсгийн ажлыг ТӨБЗГ-т хариуцан ажилласан хэвээр байгаа бөгөөд ажил байнгын шинжтэй, хэвийн үргэлжилж байна. (Бүрэн хэрэгжсэн – 100%)</p>
<p><b>ХӨТӨЛБӨР II</b>  <b>“Төрийн болон орон нутгийн өмчийн бодлого, удирдлагын оновчтой хэлбэрийг хэрэгжүүлж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг сайжруулж, үр ашгийг дээшлүүлэх, төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх” хөтөлбөрийн хүрээнд:</b></p>				
<p><b>Арга хэмжээ 2.1.9.</b> Төрийн өмчит үйлдвэрийн газар,</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Боловсруулалтыг бүрэн хийж, төслийн танилцуулга бэлтгэх;</li> </ul>	<p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж</p>	<p>БТУХ</p>	<p>Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 76 хуулийн этгээдийн 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг</p>

<p>төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Газрын хуралдаанаар төслийг хэлэлцүүлэн батлуулах;</li> <li>- I сард.</li> </ul>	<p>ахуйн нэгжүүдийн 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангасан байна.</p>		<p>ТӨБЗГ-ын даргын 2017 оны А/181 дүгээр тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлэн дүгнэлт гаргаж, ТӨБЗГ-ын хуралдааны тогтоолоор тус тус баталсан. Тайлант хугацаанд зарим хуулийн этгээдийн 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний тодотголыг ТӨБЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авсан. (Бүрэн хэрэгжсэн – 100%)</p>
<p><b>Арга хэмжээ 2.2.10.</b> Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлт, гүйцэтгэх удирдлагын ажлыг дүгнэх</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Гүйцэтгэх удирдлагын контрактыг зохих журмын дагуу дүгнэх;</li> <li>- Шийдвэрийн төслийг боловсруулан, танилцуулга бэлтгэх;</li> <li>- Урамшуулал олгох асуудлыг газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх;</li> <li>- I улиралд.</li> </ul>	<p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлагын ажлын үр дүн тодорхой болж, хариуцлага сайжирна.</p>	<p>БТУХ</p>	<p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, үйлдвэрийн газрын захиралтай байгуулсан контрактын биелэлт, 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх үүрэг бүхий ажлын хэсгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын тушаалаар байгуулан ажиллуулав. Ажлын хэсэг ТӨБЗГ-ын 2017 оны 90 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ын дагуу захиралтай байгуулсан контракт болон хуулийн этгээдийн 2017 оны зорилтот түвшинг дүгнэн газрын хуралдаанд танилцуулав. ТӨБЗГ-ын хуралдаанаас нийт 53 захирлын ажлыг “Сайн”, 10 захирлын ажлыг “Хангалттай” гэж дүгнэн 59 захирлын контрактыг 1 жилээр, 5 захирлын контрактыг 6 сараар шинэчлэн байгуулах шийдвэр гаргасан. 2018 оны сүүлийн хагас жилд “Булган АЗЗА” ТӨХК, “Орхон АЗЗА” ТӨХК-ийн гүйцэтгэх захирлыг чөлөөлж, шинээр томилсон. Мөн 6 сараар гэрээг байгуулсан гүйцэтгэх захирлуудын гэрээг дахин 6 сараар сунган ажиллуулав.</p> <p>(Бүрэн хэрэгжсэн – 100%)</p>
<p><b>Арга хэмжээ 2.3.11.</b> “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын шийдвэр гаргуулах</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг боловсруулах;</li> <li>- Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх арга хэмжээ авч, батлуулах;</li> <li>- I сард.</li> </ul>	<p>Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг хангасан байна.</p>	<p>БТУХ</p>	<p>Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанд “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай” асуудлыг хэлэлцүүлсний дүнд Засгийн газрын 08 дугаар тогтоолоор авах арга хэмжээг шийдвэрлэсэн. Засгийн газрын энэхүү шийдвэрээр Улсын Их Хурлын “Төрийн өмчийг 2018-2020 онд хувьчлах үндсэн чиглэл батлах тухай” тогтоолын төслийг боловсруулахад баримтлах зарчим, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн үр ашгийг дээшлүүлэх талаар авах арга хэмжээний талаар тодорхой үүрэг даалгавар өгсөн.</p>

				Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, төрийн өмчит хуулийн этгээдийн үр ашгийг сайжруулах зорилгоор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А-1/350 дугаар, 8 дугаар сарын 24-ний өдрийн А-2/3379 дүгээр албан бичгээр 2 удаа албан даалгавар, чиглэл өгөв. Засгийн газрын 2018 оны 08 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллах талаар албан даалгаврыг нийт төрийн өмчит 73 хуулийн этгээдэд хүргүүлсэн. 69 хуулийн этгээдийн ирүүлсэн тайлан мэдээг нэгтгэн, хэрэгжилт, үр дүнг тооцон дүгнэлт хийв. (Бүрэн хэрэгжсэн – 100%)
<b>Арга хэмжээ 2.4.12.</b> “Төрийн өмчит зарим компани, үйлдвэрийн газрыг татан буулгах тухай” Засгийн газрын шийдвэр гаргуулах	<ul style="list-style-type: none"> <li>- Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг боловсруулах;</li> <li>- Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх арга хэмжээ авч, батлуулах;</li> <li>- I сард.</li> </ul>	Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг хангасан байна.	БТУХ	Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, төрийн болон орон нутгийн өмчит компаниудын ашигт ажиллагаа, засаглал, өмч хувьчлалын бодлогыг сайжруулж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг шинэ шатанд гаргана” гэсэн зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 9 хуулийн этгээдийн менежментийг сайжруулах, зардлыг бууруулах, үйл ажиллагааны давхардлыг арилгах, ашигт ажиллагааг сайжруулах арга хэмжээг боловсруулан Засгийн газарт санал хүргүүлсэн. Үүний үр дүнд, Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор алдагдалтай ажиллаж байсан болон үйл ажиллагаа нь зогссон “Авто замын тоног төхөөрөмжийн түрээс” ТӨХК, “Аж үйлдвэрийн цогцолбор” ТӨХК, “Монгол тамга” ТӨҮГ, “Монгол тариалан” ТӨҮГ, “Монгол мах” ТӨҮГ-ыг татан буулгасан. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын тушаалаар Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас тус тус төлөөлөл оролцуулан татан буулгах 4 комиссыг байгуулан ажиллуулав.  (Бүрэн хэрэгжсэн – 100%)
<b>Арга хэмжээ 2.5.13.</b> “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийг нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлэх талаар Засгийн газрын шийдвэр гаргуулах	<ul style="list-style-type: none"> <li>- Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг боловсруулах;</li> <li>- Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх арга хэмжээ</li> </ul>	Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг хангасан байна.	БТУХ	Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 10 дугаар тогтоолоор “Эрдэнэт үйлдвэр” хязгаарлагдмал хариуцлагатай компанийг нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлж, нийт хувьцааны тодорхой хэсгийг иргэдэд эзэмшүүлэх тухай шийдвэрлүүлэв. (Бүрэн хэрэгжсэн – 100%)



	авч, батлуулах; - I сард.			
<b>Арга хэмжээ 2.6.14.</b> Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд ногдох ногдол ашгийг төвлөрүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>- Ногдол ашгийг төвлөрүүлэх тооцоо судалгааг хийж, ашиг, алдагдлыг тодорхойлох;</li> <li>- Газрын хуралдаанд танилцуулж, шийдвэр гаргуулах;</li> <li>- Төрд ногдох ногдол ашгийг төвлөрүүлэх ажлыг зохион байгуулалтаар хангах;</li> <li>- Жилдээ.</li> </ul>	2017 оны жилийн эцэст ашигтай ажилласан компаниудын цэвэр ашгаас 28.0 тэрбум төгрөгийн ногдол ашгийг улсын төсөвт төвлөрүүлнэ. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 70 хүртэл хувь нь ашигтай ажилласан байна.	БТУХ	<p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 70 хуулийн этгээд 2018 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 8,629.9 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олж, 932.2 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь 2017 оны гүйцэтгэлтэй харьцуулахад орлого 1,563.1 тэрбум төгрөгөөр буюу 22.1 хувиар, цэвэр ашиг 73.1 тэрбум төгрөгөөр буюу 8.5 хувиар тус тус нэмэгдсэн. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 71.4%&lt; нь ашигтай ажилласан байна.</p> <p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2017 оны үр дүнгээс 10-30 хувиар тооцож, улсын төсөвт төвлөрүүлэх 2018 оны ногдол ашгийн хувь хэмжээг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 322 дугаар тогтоолоор баталсан. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд 2018 оны ногдол ашгийг улсын төсөвт төвлөрүүлэх тухай албан бичгийг хүргүүлж, зохион байгуулалтаар хангав. 2018 оны жилийн эцсийн дүнгээр төрийн өмчит 53 хуулийн этгээдээс 43.2 тэрбум төгрөгийн ногдол ашгийг улсын төсөвт төвлөрүүлсэн нь 2017 оны гүйцэтгэлтэй харьцуулахад 3.4 дахин өссөн дүнтэй байна. Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулиар батлагдсан төрийн өмчийн ногдол ашгийн төлөвлөгөөтэй харьцуулахад 1.6 дахин давж биелсэн дүнтэй байна. (Бүрэн хэрэгжсэн – 100%)</p>
<b>Арга хэмжээ 2.7.15.</b> Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүү, үйл ажиллагааны мэдээлэл, эдийн засгийн үзүүлэлтийн ил тод байдлыг хангах арга хэмжээ авч, хяналт тавих	<ul style="list-style-type: none"> <li>- Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийг чиглэл, зөвлөмжөөр хангах;</li> <li>- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийж, хяналт тавих;</li> <li>- Дотоод аудитын дүнг нэгтгэж, дүнгийн мөрөөр арга хэмжээ авч хэрэгжүүлэх;</li> <li>- Дотоод аудит, хяналтын мэдээллийг цахим хуудсанд байршуулж,</li> </ul>	Шилэн дансны тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилт хангагдана.	ЗХЗХ, БТУХ	<p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүү, эдийн засгийн үзүүлэлтийг сүүлийн 3 жилийн дүнгээр нэгтгэн товхимол хэвлүүлсэн. Уг товхимлыг албаны хэрэгцээнд болон олон нийтэд тараан сурталчилж, мэдээллийн нээлттэй байдлыг хангав.</p> <p>2018 онд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2 удаа аудит хийсэн:</p> <p>1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн 2017 оны жилийн эцсийн аудитын дүн: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 96 хуулийн этгээдэд дунджаар 86 хувьтай байв. Шилэн дансны нэгдсэн мэдээллийг хуульд заасан хугацаанд 100 хувь оруулсан 70 (77 хувь), 30-50 хувь оруулсан 5 (5 хувь), оруулаагүй 7 (7 хувь) ("Автоимпекс" ХХК, "Эрдэнэс шивээ энерги" ХХК, "Эрдэнэс ассет менежмент" ХХК, "Эрдэнэс Ашид" ХХК, "Эрдэнэс стийл" ХХК, "Гашуун сухайт авто зам" ХХК, "Оюу толгой" ХХК) хуулийн этгээд</p>

	<p>олон нийтэд ил тод мэдээлэх; - Жилдээ.</p>			<p>байв. 2. 2018 оны эхний хагас жилийн аудитын дүн: Аудитад хамрагдсан 94 хуулийн этгээдэд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт дунджаар 88 хувьтай байгаагаас шилэн дансны нэгдсэн цахим системд мэдээ тайлангаа хуулийн хугацаанд 100 хувь оруулсан хуулийн этгээд 79 (84 хувь), 25-88 хувь оруулсан хуулийн этгээд 6 (6 хувь), мэдээ тайлангаа оруулаагүй хуулийн этгээд 8 (10 хувь) байна. “Автоимпекс” ХХК, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК, “Эрдэнэс шивээ энерги” ХХК, “Эрдэнэс ассет менежмент” ХХК, “Эрдэнэс Ашид” ХХК, “Эрдэнэс стийл” ХХК, “Гашуун сухайт авто зам” ХХК, “Оюу толгой” ХХК нь шилэн дансны мэдээлэл оруулаагүй байна.</p> <p>Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй дээрх хуулийн этгээдэд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүртгүүлэх, мэдээ мэдээллийг хуульд заасан хугацаанд бүрэн оруулах, байгууллагын өөрийн цахим хуудас дахь шилэн дансны цэсээ тогтмол шинэчлэн, мэдээ мэдээллийг олон нийтэд нээлттэй болгож, хуулийн хэрэгжилтийг хангах талаар ТӨБЗГ-ын 2018 оны А-1/2135-2141 дүгээр албан бичгийг тус тус хүргүүлсэн. (Бүрэн хэрэгжсэн – 100%)</p>
<p><b>Арга хэмжээ 2.8.16.</b> Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ажилтнуудад хууль, эрх зүйн сургалт зохион байгуулан, чадавхжуулах</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиар сургалт зохион байгуулах;</li> <li>- Сургалтын төлөвлөгөө боловсруулан батлах;</li> <li>- Сургалтын үр дүнг тайлагнах;</li> <li>- Жилдээ.</li> </ul>	<p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ажилтнуудын хууль, эрх зүйн мэдлэг сайжирсан байна.</p>	<p>Бүх хэлтэс, алба</p>	<p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн зарим албан хаагчид зориулсан дараах 4 удаагийн зорилтот сургалт семинарыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулж, нийт 454 албан хаагчийг хамруулав. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. 2018 оны 04 дүгээр сарын 05, 06-ны өдрүүдэд зохион байгуулсан Тэргүүн дэд захирал, ерөнхий инженер, Тамгын газрын дарга, хуулийн мэргэжилтэн, нууцын асуудал хариуцсан албан хаагчийн сургалтад 51 хуулийн этгээдийн 150 албан хаагчийг хамруулав.</li> <li>2. 2018 оны 05 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулсан сургалтад 100 хуулийн этгээдийн санхүүгийн асуудал хариуцсан нэгжийн 112 дарга, ерөнхий нягтлан бодогчийг хамруулав.</li> <li>3. 2018 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн сургалтад 92 хуулийн этгээдийн захирлыг оролцуулав.</li> <li>4. 2018 оны 05 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулсан сургалтад төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 40 компанийн Төлөөлөн удирдах 72 зөвлөлийн 100 гаруй хараат бус гишүүнийг хамруулж чадавхижуулав.</li> </ol> <p>Дээрх 4 удаагийн семинарт оролцогч нараас семинарын зорилго,</p>

				<p>агуулга, зохион байгуулалтын талаар санал асуулга авч, нэгтгэн дүгнэсэн. Мөн семинар тус бүрийн тайланг нэгтгэн боловсруулж, холбогдох мэдээллээр хадгаламжийн нэгж үүсгэн архивлав.</p> <p>Тайлант хугацаанд, худалдан авах ажиллагааны цахим системийн сургалтад төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 90 хуулийн этгээдийн 190 төлөөллийг хамруулж, худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд чиглэсэн сургалт хийж, хуулийн этгээдийг мэдээлэл, арга зүйгээр тогтмол хангаж ажиллав. (Бүрэн хэрэгжсэн – 100%)</p>
<p><b>Арга хэмжээ 2.9.17.</b> Газар, салбарын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах нээлттэй өдөрлөг, арга хэмжээ зохион байгуулах</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Зохион байгуулах ажлын хэсэг байгуулах;</li> <li>- Өдөрлөг, арга хэмжээ зохион байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөө боловсруулан батлах;</li> <li>- Батлагдсан төлөвлөгөөний дагуу бэлтгэл ажлыг хангах;</li> <li>- Өдөрлөг, арга хэмжээний хүрээнд хуулийн хэлэлцүүлгийг зохион байгуулан, үр дүнг тооцох;</li> <li>- Өдөрлөг, арга хэмжээний үйл ажиллагаанд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, холбогдох яам, агентлаг, байгууллагын оролцоог хангах;</li> <li>- II-III улиралд.</li> </ul>	<p>Газар, салбар, байгууллага, тэдгээрийн үйл ажиллагааны талаарх мэдээллийн хүртээмж нэмэгдсэн байна.</p>	<p>Бүх хэлтэс, алба, харьяа хуулийн этгээд</p>	<p>2018 оны 05 дугаар сарын 03-ны өдөр “Төрийн өмчийн менежмент ба нийгмийн хариуцлага - 2018” нээлттэй өдөрлөгийг Сүхбаатарын талбайд зохион байгуулав. Өдөрлөгийн зохион байгуулалтыг хариуцсан ерөнхий болон дэд ажлын хэсгийг байгуулан ажиллуулж, бэлтгэл ажлыг ханган өдөрлөгийг хөтөлбөрийн дагуу зохион байгуулсан.</p> <p>Уг өдөрлөгт төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 75 хуулийн этгээд оролцож, 2017 онд гаргасан эдийн засгийн эерэг үзүүлэлтийг нэмэгдүүлэх, гаргасан ололт амжилтаа бататгах чиглэлээр харилцан туршлага солилцож, үйл ажиллагаагаа олон нийтэд нээлттэй сурталчиллаа. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн дор дурдсан амжилт, ололтыг олон нийтэд танилцуулав:</p> <ul style="list-style-type: none"> <li>- 2017 онд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 72 хувь нь 859.0 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан;</li> <li>- Төрийн өмчит компани, үйлдвэрийн газрууд 2016 онд 4.6 их наяд төгрөгийн орлого олж, 4.9 их наяд төгрөгийн зардал гаргаж, 380.0 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллаж байсан бол 2017 онд 7.0 их наяд төгрөгийн орлого олж, 5.9 их наяд төгрөгийн зардал гаргасан;</li> <li>- 2017 онд 12.6 тэрбум төгрөгийн ногдол ашгийг улсын төсөвт төвлөрүүлсэн нь 2016 оныхоос 3 дахин нэмэгдсэн;</li> <li>- Авлага 2017 онд 11.5 тэрбум төгрөгөөр, өглөг 736.0 тэрбум төгрөгөөр тус тус буурсан.</li> </ul> <p>Өдөрлөгт хамт олноороо идэвх санаачлагатай, үр бүтээлтэй оролцсон “Эрдэнэт үйлдвэр” ХХК, “МИАТ” ТӨХК, “Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэг, “Сэргээгдэх эрчим хүчний</p>

				<p>үндэсний төв” ТӨҮГ-ыг “Шилдэг аж ажуйн нэгж”-ээр өргөмжлөв. Мөн өдөрлөгийн үеэр 2017 оны зорилтот түвшин, эдийн засгийн үзүүлэлтээрээ амжилттай ажилласан төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 11 хуулийн этгээдийн удирдлагыг шагнаж, урамшуулав.</p> <p>Өдөрлөгийн үеэр төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн зарим албан хаагчийг чадавхижуулах 3 төрлийн сургалт-семинарыг тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулж, нийт 100 хуулийн этгээдийн 276 эрх бүхий албан тушаалтныг хамруулав:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Санхүүгийн асуудал хариуцсан нэгжийн дарга, ерөнхий нягтлан бодогч нарын сургалтад 100 хуулийн этгээдийн 112 албан хаагчийг хамруулсан;</li> <li>2. Хуулийн этгээдийн захирлуудад зориулсан сургалтад 92 захирлыг хамруулсан;</li> <li>3. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг чадавхижуулах сургалтад 40 компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус 72 гишүүнийг хамруулсан.</li> </ol> <p>(Бүрэн хэрэгжсэн – 100%)</p>
<p><b>Хоёр. “Төрийн өмчийн эзэмшилт, ашиглалт, хамгаалалттай холбоотой бүртгэл, тооллого явуулах, төрийн өмчийн бүрэн бүтэн байдал, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн байдалд хяналт тавих”</b> гэсэн стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:</p>				
<p><b>ХӨТӨЛБӨР III</b>  <b>“Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгөд бүртгэлээр тавих хяналтыг боловсронгуй болгож, өмчийн улсын бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэн баяжуулж, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хөдөлгөөнийг зохицуулах”</b> хөтөлбөрийн хүрээнд:</p>				
<p><b>Арга хэмжээ 3.1.18.</b>  Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших ашиглах эрхийг үнэлэх, үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлэх, гадаадад байгаа төрийн өмчийн газар, үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлэх ажлыг зохион байгуулах</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Үнэлгээний аргачлал, заавар, журмыг боловсруулах багийг сонгох, эрх бүхий байгууллагаар батлуулах;</li> <li>- Гарын авлага хэвлүүлэх;</li> <li>- Сургалт зохион байгуулах;</li> <li>- Үнэлгээний ажлыг удирдан зохион байгуулж, холбогдох байгууллагатай хамтран</li> </ul>	<p>Үнэлгээний ажлыг цогцоор нь зохион байгуулсан байна. Төсөвт тусгагдсан 400.0 сая төгрөгийн санхүүжилтийг зориулалтаар зарцуулж, тайлагнасан</p>	<p>ТӨБХХ, Ажлын хэсэг</p>	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн газар, үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах бэлтгэл хангах ажлын хэсгийг холбогдох байгууллагын төлөөллийг оролцуулан ТӨБЗГ-ын даргын 2018 оны А/08 дугаар тушаалаар байгуулан ажиллуулав. “Хөрөнгийн үнэлгээний талаар авах зарим арга хэмжээ, бэлтгэл ажлыг хангах тухай зөвлөмж”-ийг боловсруулан төрийн болон орон нутгийн өмчит 6000 гаруй хуулийн этгээдэд хүргүүлэн хэрэгжилтийг хангуулав. Үнэлгээний ажлын чиглэлээр ГЗБГЗЗГ-тай “Хамтын ажиллагааны санамж бичиг” байгуулж, нийслэлийн Газрын алба, 21 аймгийн ОНӨГ, ГХБХБГ-тай хамтран ажиллав.</p> <p>Төрийн өмчийн эд хөрөнгийн бүртгэл, хяналт шалгалт, хөрөнгийн</p>

	<p>ажиллах;</p> <ul style="list-style-type: none"> <li>- Үнэлгээний явцад хяналт тавих, мэргэжил, арга зүйгээр хангах;</li> <li>- Үнэлгээний ажлын дүнг хянан хүлээн авах;</li> <li>- Улсын нэгдсэн дүнг гаргаж, Засгийн газарт танилцуулах;</li> <li>- 2018 онд багтаан үнэлгээг зохион байгуулах.</li> </ul>	<p>байна.</p>	<p>дахин үнэлгээний асуудлаар Нийслэлийн өмчийн харилцааны газар, 21 аймгийн Орон нутгийн өмчийн газар, төрийн өмчит хуулийн этгээдийн холбогдох 221 гаруй ажилтныг хамруулсан 3 удаагийн сургалтыг ТӨБЗГ-т зохион байгуулан мэдээлэл, зөвлөгөө өгч, мэргэжил, арга зүйгээр хангав. Хөрөнгийн дахин үнэлгээний бэлтгэл ажлыг хангахад дэмжлэг үзүүлэх, шалган зааварчлах, зөвлөгөө, арга зүйгээр хангах чиглэлээр нийт 15 аймаг буюу Архангай, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Завхан, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл аймагт ажиллав.</p> <p>ТӨБЗГ-ын 2018 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлийн талаар авах арга хэмжээний тухай” 273 дугаар тогтоолоор үнэлгээнд хамрагдах үл хөдлөх хөрөнгийг хөрөнгийн үнэлгээний болон нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу дансны нэг ангид бүртгэх арга хэмжээ авч, нийт төрийн өмчит хуулийн этгээдийг хамруулан хэрэгжилтийг хангуулав.</p> <p>ТӨБЗГ-ын даргын 2018 оны А/65 тоот тушаалаар Монгол Улсаас гадаад улсад суугаа 23 Дипломат төлөөлөгчийн газрын эзэмшилд байгаа төрийн өмчийн газар, үл хөдлөх хөрөнгийг тоолох, дахин үнэлгээ хийх үүрэг бүхий 10 ажлын хэсгийг байгуулан ажиллуулав. Ажлын хэсгүүд Дипломат төлөөлөгчийн газрын зохих баримт бичигтэй танилцан, газар өмчлөх эрх болон үл хөдлөх хөрөнгийг тоолох, хэмжилт хийх, үнэлбэл зохих хөрөнгийн тоо хэмжээ, чанар байдлыг тодоройлон нягтлан шалгаж жагсаалт бэлтгэх, үнэлгээ хийхэд шаардлагатай мэдээллийг судалгааны маягтын дагуу бэлтгэх, акталж данснаас хасах хөрөнгийн саналыг хянаж, материалын бүрдлийг хангуулж авах зэрэг ажлыг газар дээр нь хийж гүйцэтгэв.</p> <p>Үнэлгээний аргачлал, заавар, журмыг боловсруулах мэргэжлийн үнэлгээчдийн багийг ажиллуулж, үнэлгээний аргачлал, зааврын төслийг боловсруулан Сангийн яаманд хүргүүлэв. Үнэлгээний аргачлал, зааврын төсөл болон үнэлгээний дүнг нягтлан бодох бүртгэлд тусгаснаар гарах үл нөлөөний асуудлаар Сангийн яам, Мэргэшсэн үнэлгээний институтын төлөөлөл, зарим яам, агентлаг, төрийн өмчит хуулийн этгээдийн санхүү хариуцсан ажилтныг оролцуулсан хэлэлцүүлэг зохион байгуулав. Үнэлгээний аргачлалын төслийг СЯ-ны болон ТӨБЗГ-ын цахим хуудсанд 1 сарын хугацаатай байршуулж, холбогдох байгууллага, иргэдээс санал авсан. Үүний үр дүнд, Сангийн сайдын 2018 оны 207 тоот</p>
--	--	---------------	---

				<p>тушаалаар “Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн дансанд тусгах аргачлал” батлагдсан бөгөөд ТӨБЗГ-аас үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний ажлыг улсын хэмжээнд удирдан зохион байгуулав. Энэ хүрээнд үнэлгээний ажлын гарын авлага, дагалдах CD-г бэлтгэн тус бүр 6800 ширхэгийг хэвлүүлж, орон нутаг дахь өмчийн асуудал хариуцсан байгууллагаар дамжуулан нийт төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хүргүүлсэн. ТӨБЗГ-ын бүртгэлийн мэргэжилтнүүд үнэлгээний аргачлал, зааврыг танилцуулах, арга зүйн семинар, зөвлөгөө, зааварчилга өгөх, орон нутаг дахь үнэлгээний ажилд явцын хяналт хийж, үр дүнг 2018 оны санхүүгийн тайланд тусгуулах асуудалд нягтлан шалгалт хийх чиглэлээр нийслэл, 21 аймаг тус бүрт 2 удаа ажиллав. Энэ үеэр зохион байгуулсан сургалт, семинарт төрийн болон орон нутгийн өмчит нийслэл дэх 1128 хуулийн этгээдийн 2500, 21 аймаг дахь 3000 орчим хуулийн этгээдийн 5650 албан хаагчдыг тус тус хамруулсан байна. (Бүрэн хэрэгжсэн – 100%)</p>
<p><b>Арга хэмжээ 3.2.19.</b> Төрийн байгууллагын дотоод албан хэрэгцээнд ашиглах автомашины тоо, төрөл нормативыг шинэчлэн тогтоож, хяналт тавих</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолын хэрэгжилтийг тайлагнах;</li> <li>- Төрийн өмчит хуулийн этгээдийн автомашины ашиглалтын асуудлаар авах арга хэмжээний талаар саналын төслийг боловсруулах;</li> <li>- Автомашины тоо, төрөл, нормативыг шинэчлэн тогтоох, автомашины ашиглалтын талаар авах арга хэмжээний тухай саналын төслийг ТӨБЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэх;</li> <li>- Засгийн газрын шийдвэрийн төсөл боловсруулж, ЗГХЭГ-т хүргүүлэн батлуулах арга хэмжээ авах, эхний хагас жилд;</li> <li>- Хэрэгжилтийг зохион</li> </ul>	<p>Төрийн өмчит хуулийн этгээдийн автомашины талаарх бодлого зохицуулалт оновчтой болж, төсвийн зардал буурна.</p>	<p>ТӨБХХ</p>	<p>Засгийн газрын 2015 оны “Суудлын автомашины ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” 184 дүгээр тогтоолын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, уг тогтоолыг шинэчлэх асуудлаар саналын төсөл боловсруулж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны А-1/156 дугаар албан бичгээр Засгийн газарт хүргүүлсэн. Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас өгсөн чиглэлийн дагуу төрийн өмчит хуулийн этгээдийн автомашины тоо, төрлийг шинэчлэн тогтоох чиглэлээр тээврийн хэрэгслийн нэгтгэлийн судалгааг салбар бүрээр гарган тоо төрөл, норматив, суудлын автомашины зардлын тооцоо, судалгааг хийж, нэгтгэн Засгийн газарт хүргүүлсэн.</p> <p>2017 оны жилийн эцсийн балансын дүнгээр төрийн өмчит хуулийн этгээдэд бүртгэлтэй 6020 автомашины 2177 нь суудлын автомашин байна. Төрийн өмчит хуулийн этгээдүүд автомашины зардалд 2016 онд 51.0 тэрбум төгрөг, 2017 онд 46.0 тэрбум төгрөг зарцуулж, зардал 5.0 тэрбум төгрөгөөр хэмнэгджээ. 2017 онд суудлын автомашины зардалд 31.3 тэрбум төгрөгийг зарцуулсан нь нийт автомашины зардлын 68.0 хувийг эзэлж байгаа бөгөөд жолоочийн цалин, шатахуун, тослох материалын зардалд 27.1 тэрбум төгрөгийг зарцуулсан нь суудлын автомашины зардлын 86.6 хувийг эзэлж байна.</p> <p>Үнэлгээнд өгөх тайлбар: ТӨБЗГ-аас хийх ажлыг гүйцэтгэсэн.</p>

	байгуулж, хяналт тавих, жилдээ.			Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, шийдвэрлэх арга хэмжээ авах шаардлагатай байгаа. (Бүрэн хэрэгжсэн – 100%)
<b>Арга хэмжээ 3.3.20.</b> Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайлан, үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн нэгдсэн дүн мэдээ гаргах	<ul style="list-style-type: none"> <li>- Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайлан, үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн нэгдсэн дүн мэдээ гаргах;</li> <li>- Дүн мэдээг Төсвийн ерөнхийлөн захирагчаар ангилан тулган баталгаажуулалт хийх;</li> <li>- Илэрсэн зөрчил, дутагдал, зөрүүг хянан үзэх;</li> <li>- Засгийн газрын нэгдсэн санхүүгийн тайлантай тулгаж нэгтгэл гаргах;</li> <li>- Зөвлөмж, чиглэл боловсруулж, хуулийн этгээдэд хүргүүлэх;</li> <li>- Эхний хагас жилд.</li> </ul>	Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл болон цахим мэдээллийн санг хянах боломжтой болно.	ТӨБХХ	Нууцын зэрэглэлтэй байгууллагын мэдээллээс бусад төрийн өмчит 1128, орон нутгийн өмчит 4958 хуулийн этгээдийн 2017 оны үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн мэдээ болон бусад судалгааны дүнг Үндэсний статистикийн хорооноос баталсан 17 төрлийн маягтын дагуу өмчийн мэдээ тайланг хянан хүлээн авч, санхүүгийн тайлангийн нэгтгэлийг 2018 оны А-5/739 тоот албан бичгээр Үндэсний статистикийн хороонд хүргүүлсэн.  (Бүрэн хэрэгжсэн – 100%)
<b>Арга хэмжээ 3.4.21.</b> Төрийн өмчийн эзэмшилтийн байдалд бүртгэлээр хяналт тавьж дүгнэлт хийх	<ul style="list-style-type: none"> <li>- Төрийн өмчит хуулийн этгээдийн өмч эзэмшлийн байдалд “Өмч эзэмшүүлэх гэрээ байгуулах, дүгнэх” хэлбэрээр хяналт тавьж, үнэлэлт дүгнэлт өгөх;</li> <li>- Дүнг ТӨБЗГ-ын хуралдаанд танилцуулах;</li> <li>- Холбогдох шийдвэрийг Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлж, хэрэгжилтийг хангах арга хэмжээ авах;</li> <li>- III улиралд.</li> </ul>	Төрийн өмчит хуулийн этгээдийн өмч эзэмшлийн талаар авах арга хэмжээ тодорхой болж, хэрэгжилтийг хангасан байна.	ТӨБХХ	Төрийн өмчит хуулийн этгээдийн 2017 оны “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-г 2018 онд дүгнэхтэй холбоотойгоор 2016 гэрээний биелэлтийн дүгнэлтээр гарсан зөрчил дутагдлыг арилгах, цаашид авах арга хэмжээ, хөрөнгийн дахин үнэлгээний ажлаар хамтран ажиллах асуудлаар ТӨБЗГ-ын 2018 оны А-5/452 тоот зөвлөмжийг бүх төрийн өмчит хуулийн этгээдэд хүргүүлэн зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллав. Төрийн өмчийг эзэмшүүлэх 2017 оны гэрээг дүгнэх, гэрээг сунган баталгаажуулах ажлыг нийслэл, 21 аймгийн төрийн өмчит хуулийн этгээдэд 2018 оны 3 дугаар улиралд хийж гүйцэтгэв. Төрийн өмчийг эзэмшүүлэх 2017 оны гэрээг дүгнүүлбэл зохих 1121 хуулийн этгээдээс 801 буюу 71.5 хувь нь гэрээний биелэлтийг дүгнүүлж, 43 буюу 3.8 хувь нь дүгнүүлээгүй, 277 буюу 25.0 хувь нь бүтцийн өөрчлөлтөөр татан буугдсан, орон нутгийн өмчид шилжсэн, нэгтгэгдсэн, хувьчлагдсан, төрийн өмчийн оролцоотой компани, төсөл, сан, хөтөлбөрийн нэгжүүд зэрэг шалтгаанаар уг гэрээг дүгнүүлэхгүй хасагдсан. Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээг дүгнүүлсэн 801 хуулийн этгээдээс “онц”- 137, “сайн”- 571, “дунд”- 90, “муу”-3 дүгнэгдсэн байна. “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний 2017 оны биелэлтийн дүнгээр нийт 5 багц шалгуур үзүүлэлтийг хангасан байдлын улсын дундаж дүн

				“сайн” буюу 90.8 хувьтай байна. Төрийн өмчит 96 хуулийн этгээдийн өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдал илүү хариуцлагатай, үлгэр жишээч байна. Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон эрх бүхий бусад байгууллагын тогтоол шийдвэр, журам түүний хэрэгжилтийн байдал “хангалтгүй” байгаа нь гэрээний биелэлтээс дүгнэгдэж байна. “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний 2017 оны биелэлтийн дүнг ТӨБЗГ-ын хуралдаанаар хэлэлцэж, цаашид авах арга хэмжээний талаар тогтоол гаргав. (Бүрэн хэрэгжсэн – 100%)
<p><b>Арга хэмжээ 3.5.22.</b> Төрийн өөрийн өмчийн илүүдэлтэй байр талбайг түрээслүүлэх, түрээсийн орлогын 30 хувийг улсын төсөвт төвлөрүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Төрийн өмчийн илүүдэлтэй байр талбайн судалгаа гаргах;</li> <li>- Төрийн өмчит хуулийн этгээдийн түрээслэх байр, тайлбайн түрээслэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаанд хяналт тавих;</li> <li>- Түрээсийн гэрээг хянан баталгаажуулах;</li> <li>- Түрээсийн орлого бүрдүүлэлтэд хяналт тавих;</li> <li>- Жилдээ.</li> </ul>	Төрийн өөрийн өмчийн үр ашгийг дээшлүүлж, 580.0 сая төгрөгийн түрээсийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлнэ.	ТӨБХХ	Төрийн өмчийн илүүдэлтэй байр, талбайг түрээслүүлсний орлогоос 30 хувийг улсын төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулан хяналт тавьж ажиллав. 2018 оны жилийн эцсийн дүнгээр төрийн өмчит 74 хуулийн этгээд төрийн өөрийн өмчийн 15,366.88 м.кв байр талбайг нийт 336 түрээсийн гэрээгээр иргэн, хуулийн этгээдэд шинээр түрээслүүлсэн байна. Харин төрийн өмчит 52 хуулийн этгээд төрийн өөрийн өмчийн 15,733.79 м.кв байр талбайн 426 түрээсийн гэрээг сунгаж ажилласан. Нийт давхардсан тоогоор 126 хуулийн этгээд төрийн өөрийн өмчийн 31,100.67 м.кв байр талбайг 762 түрээсийн гэрээгээр иргэд, хуулийн этгээдэд түрээслүүлж, 2,169.91 сая төгрөгийн түрээсийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлэв.  (Бүрэн хэрэгжсэн – 100%)
<p><b>Арга хэмжээ 3.6.23.</b> “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д үндсэн хөрөнгийн болон бусад холбогдох мэдээлэл, тэдгээрийн хөдлөл өөрчлөлтийг тусган нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Цахим системийг холбогдох мэдээллээр баяжуулах;</li> <li>- Цахим системийн ашиглалтыг сайжруулах арга хэмжээ авах, хяналт тавих;</li> <li>- Сургалт зохион байгуулах;</li> <li>- Жилдээ.</li> </ul>	Төрийн өмчийн мэдээллийн нэгдсэн сан бүрдэж, ашиглалт сайжирсан байна.	ТӨБХХ, Мэдээлэл, технологийн алба (Цаашид “МТА” гэх)	<p>“Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-ийн хэвийн үйл ажиллагааг хангахын тулд тус системд гарч буй нийтлэг алдааны мэдээлэл, системийг сайжруулах талаар 21 аймгийн Орон нутгийн өмчийн газраас санал хүлээн авах ажлыг зохион байгуулсан. Саналыг үндэслэн системийг хөгжүүлэгч байгууллага болох “G Communication” компанитай хамтран системд гарч байгаа нийтлэг алдааг засан, системийн гацалтыг багасгаж хурдыг нэмэгдүүлэн хэвийн үйл ажиллагааг хангав.</p> <p>“Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-ийг компьютерт суулгах болон уг системд ажиллах зааварчилга бүхий гарын авлагыг бэлтгэж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын цахим хуудас <a href="http://www.pcsp.gov.mn">www.pcsp.gov.mn</a> -д байршуулав.</p>



				<p>“Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-ийн дүүргэлтэд 2 удаагийн мониторинг хийж, мэдээллийн дүүргэлтийг сайжруулах асуудлаар 17 аймгийн Засаг даргад албан бичиг хүргүүлсэн.</p> <p>2018 оны 01 дүгээр сарын 18-19 өдрүүдэд уг систем дэх газар, барилга, нийтийн эзэмшлийн байр, талбай, тээврийн хэрэгсэл, дуусаагүй барилга, үнэт зүйлс, худаг, зам, гүүрийн мэдээллийн дүүргэлт, санхүүгийн тайлан зэрэгт хяналт тавьж, мониторинг хийсэн. 2018 оны 3 дугаар сарын 12-18-ны өдрүүдэд 21 аймаг дахь төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн мэдээллийн систем дэх санхүүгийн тайлангийн тулган баталгаажуулалтыг зохион байгуулах замаар мониторингийн ажлын чанар, үр нөлөөг нэмэгдүүлсэн. Үүний үр дүнд мэдээллийн баазын дүүргэлтийг сайжруулав. (Бүрэн хэрэгжсэн – 100%)</p>
<p><b>Арга хэмжээ 3.7.24.</b> Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийг бүртгэлд тусгах, акталж, данснаас хасах, балансаас балансад шилжүүлэх, худалдан авах, худалдах зөвшөөрөл олгох санал боловсруулж, шийдвэрлүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Тухай бүр асуудлыг судлан санал боловсруулах;</li> <li>- ТӨБЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэх;</li> <li>- Шийдвэр гаргуулах;</li> <li>- Холбогдох төрийн өмчит хуулийн этгээдэд ТӨБЗГ-ын шийдвэрийг хүргүүлэн, хэрэгжүүлэх арга хэмжээ авах;</li> <li>- Жилийн туршид, тухай бүр.</li> </ul>	<p>Хууль тогтоомжийн дагуу хөрөнгийн асуудал шийдвэрлэгдсэн байна.</p>	<p>ТӨБХХ</p> <p>2018 онд төрийн өмчит 762 хуулийн этгээдээс ирүүлсэн хөрөнгийн зохицуулалттай холбоотой асуудал бүхий саналыг судлан, боловсруулж, ТӨБЗГ-ын 31 удаагийн хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлсэн. Мөн ТӨБЗГ-ын 2017 оны “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам батлах тухай” 86 дугаар тогтоолын 2.1, 2.2-т заасны дагуу Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтсийн даргын албан бичгээр зохих хөрөнгийн зохицуулалтыг шийдвэрлэсэн. ТӨБЗГ-ын 453 тогтоол, холбогдох хэлтсийн даргын албан бичгээр 2018 онд давхардсан тоогоор 762 байгууллагын 55493 нэр төрлийн 443,482.9 сая төгрөгийн хөрөнгийн бүртгэл, шилжилт хөдөлгөөний зохицуулалтын асуудлыг шийдвэрлэн хэрэгжилтийг хангуулсан байна:</p> <ul style="list-style-type: none"> <li>- 288 байгууллагын 33968 нэр төрлийн 66,699.6 сая төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хассан;</li> <li>- 299 байгууллагын 15121 нэр төрлийн 260,050.5 сая төгрөгийн эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлсэн;</li> <li>- 67 байгууллагын 253 автомашиныг нээлттэй дуудлага худалдаагаар худалдан борлуулж, 618.3 сая төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн;</li> <li>- 30 байгууллагад 97 нэр төрлийн нийт 5,875.8 сая төгрөгийн эд хөрөнгийг шинээр худалдаж авах зөвшөөрөл олгосон;</li> <li>- 78 байгууллагын 6307 нэр төрлийн 110,238.7 сая төгрөгийн эд хөрөнгийг шинээр бүртгэж авах зөвшөөрөл олгосон.</li> </ul>	

				(Бүрэн хэрэгжсэн – 100%)
<p><b>Арга хэмжээ 3.8.25.</b> Төрийн өмчийн эд хөрөнгийг нээлттэй дуудлага худалдаагаар худалдах ажлыг зохион байгуулах</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Засгийн газрын 2018 оны 08 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхэд чиглэсэн хөрөнгийн судалгаа гаргах;</li> <li>- Хөрөнгө худалдах санал боловсруулж, Засгийн газар болон ТӨБЗГ-ын шийдвэр гаргуулах;</li> <li>- Дуудлага худалдааны зар, товыг ил тод зарлан мэдээлэх;</li> <li>- Худалдах, худалдан авах гэрээ байгуулах;</li> <li>- Дуудлага худалдааны орлогыг улсын төсөвт төвлөрүүлэх;</li> <li>- Дуудлага худалдааг цахим хэлбэрт шилжүүлэх;</li> <li>- Тухай бүр, жилийн турш.</li> </ul>	<p>Дуудлага худалдааг зохих журмын дагуу зохион байгуулж, төрийн өмчийн дуудлага худалдаанаас улсын төсөвт 90.0 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлнэ.</p>	ТӨБХХ	<p>2018 онд 67 байгууллагын 253 автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдан борлуулж, нийт 618.3 сая төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн. (Бүрэн хэрэгжсэн – 100%)</p>
<p><b>ХӨТӨЛБӨР IV</b> “Төрийн өмчийн эзэмшилт, ашиглалтын үр өгөөжид мониторинг хийх, өмчийн болон санхүүгийн хяналт шалгалтын үр нөлөөг сайжруулах” хөтөлбөрийн хүрээнд:</p>				
<p><b>Арга хэмжээ 4.1.26.</b> Төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд баримтын шалгалт, эдийн засгийн дүн шинжилгээ хийх</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Хугацаа, хуваарийг тусгасан төлөвлөгөө боловсруулан батлуулах, олон нийтэд мэдээлэх, I сард;</li> <li>- Төлөвлөгөөнд тусгагдсан хяналт шалгалтыг тусгайлсан удирдамжаар гүйцэтгэх;</li> <li>- Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд эдийн засгийн дүн шинжилгээ хийх;</li> <li>- Хяналт шалгалтын дүн, эдийн засгийн дүн шинжилгээний</li> </ul>	<p>Төрийн өмчийн эзэмшилт, ашиглалт, захиран зарцуулалтыг холбогдох хууль тогтоомж, заавар журмын дагуу хэрэгжүүлсэн байна. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 33 хуулийн этгээдэд баримтын</p>	ТӨБХХ	<p>2018 онд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 33 хуулийн этгээдийн 2016-2017 оны үйлдвэрлэл, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд баримтын шалгалт хийхээр төлөвлөсөн. Удирдлагын шийдвэрээр 3 хуулийн этгээдийн шалгалтыг хойшлуулсан. Тайлант хугацаанд, төрийн өмчит 30 хуулийн этгээдэд удирдамжийн дагуу хяналт шалгалт хийв. Мөн төлөвлөгөөнд тусгагдаагүй боловч иргэд, байгууллагын өргөдөл, гомдол, мэдээлэл, хүсэлтийн мөрөөр 4 хуулийн этгээдийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд төрийн өмчит 8 их дээд сургуулийн төрийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтын үйл ажиллагаанд тус тус хяналт шалгалт хийв.</p> <p>2018 оны жилийн эцсийн байдлаар төрийн өмчит 22 хуулийн этгээдэд хийсэн хяналт шалгалтын дүнг ТӨБЗГ-ын хуралдаанд танилцуулан тогтоолоор баталгаажуулаад байна. Эдгээр 22 байгууллагын нийт дүнгээр 184.8 тэрбум төгрөгийн зөрчил, дутагдлыг илрүүлэв. Шалгалтаар илэрсэн нийт зөрчлийн 90 хувь</p>

	<p>дүгнэлтийн талаар танилцуулга бэлтгэх;</p> <ul style="list-style-type: none"> <li>- Газрын хуралдаанд танилцуулах асуудал, шийдвэрийн төсөл боловсруулах;</li> <li>- Тухайн бүрд, жилийн турш.</li> </ul>	шалгалт хийсэн байна.		<p>буюу 166.3 тэрбум төгрөгийн зөрчил нь худалдан авах ажиллагаатай холбоотой, 10 хувь буюу 18.5 тэрбум төгрөгийн зөрчил нь хууль тогтоомж, холбогдох журмыг зөрчсөн байна. Төрийн өмчит 17 хуулийн этгээдэд хийгдсэн шалгалтын дүнг ТӨБЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэсэн, ТӨБЗГ-ын тогтоолоор дүнг баталгаажуулах ажил хүлээгдэж байгаа бөгөөд үүнтэй холбоотой зөрчлийн тоо, мөнгөн дүнд нэмэгдэнэ.</p> <p>Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авч ажиллах талаар ТӨБЗГ-ын тогтоол, хуралдааны тэмдэглэлээр холбогдох хуулийн этгээдийн удирдлагад үүрэг даалгавар өгч, биелэлтийг хангуулан хяналт тавьж ажиллав.</p> <p>(Бүрэн хэрэгжсэн – 100%)</p>
<p><b>Арга хэмжээ 4.2.27.</b> Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал, түүнийг арилгах талаар гарсан тогтоол шийдвэрийн нэгдсэн судалгаа гаргаж, мониторинг хийх.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Шалгалтад хамрагдсан хуулийн этгээдэд өгсөн зөвлөмж, чиглэлийн талаар судалгаа гаргах;</li> <li>- Шийдвэр, зөвлөмж, чиглэлийн хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг нэгтгэн гаргах;</li> <li>- Дүгнэлт, танилцуулга, мэдээлэл бэлтгэх;</li> <li>- Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх;</li> <li>- IY сард.</li> </ul>	Шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ, зөвлөмж, чиглэл хэрэгжиж, зөрчил, дутагдал арилсан байна.	ТӨБХХ	<p>2017 онд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 33 хуулийн этгээдийн үйлдвэрлэл, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд баримтын шалгалт хийж, нийт 74.8 тэрбум төгрөгийн зөрчил дутагдал илрүүлсэн. Энэхүү зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээг авч ажилласан бөгөөд үүрэг даалгаврын хэрэгжилтийн явцад мониторинг хийж, хяналт тавин ажиллав. Тайлант хугацаанд нийт 12 хуулийн этгээдэд мониторингийн хяналт хийсэн.</p> <p>2018 онд төрийн өмчит 22 хуулийн этгээдийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын дүн тайланг ТӨБЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж, шалгалтаар илэрсэн 184.8 тэрбум төгрөгийн зөрчил, дутагдлыг арилгах, шалгалтын мөрөөр тодорхой арга хэмжээ авч ажиллах асуудлаар ТӨБЗГ-ын тогтоолоор үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг хангуулан ажиллав.</p> <p>(Бүрэн хэрэгжсэн – 100%)</p>
<p><b>Арга хэмжээ 4.3.28.</b> Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2017 оны жилийн эцсийн авлага, өр төлбөр, зээлийн байдалд мониторинг хийх</p>	<ul style="list-style-type: none"> <li>- 2017 оны жилийн эцсийн авлага, өр төлбөр, зээлийн судалгаа гаргах;</li> <li>- Судалгаанд дүн шинжилгээ хийх, үр дүнг судлан дүгнэх;</li> <li>- ТӨБЗГ-ын хуралдаанд танилцуулах;</li> <li>- IY сард.</li> </ul>	30 хуулийн этгээдийг хамруулж мониторинг хийсэн байна.	ТӨБХХ	<p>Засгийн газрын 2018 оны 8 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах үүднээс төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн өр, авлагыг бууруулах чиглэлээр зөвлөмж боловсруулан хүргүүлж, хэрэгжилтийг хангуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч. Тэдгээрийн урт болон богино хугацаатай өр, авлагын судалгаа хийх зорилгоор 3 төрлийн хүснэгтийг боловсруулан төрийн өмчит 30 хуулийн этгээдэд хүргүүлэн судалгаа авч байна. 2016-2018 оны шалгалтад хамрагдсан төрийн өмчит 28 хуулийн этгээдийн өр, авлагын судалгаа, тэдгээрт хийсэн дүгнэлт шинжилгээний дүнг ТӨБЗГ-ын хуралдаанд танилцуулахаар бэлтгэж байна.</p>

				(Бүрэн хэрэгжсэн – 100%)
<b>Гурав. “Худалдан авах ажиллагааг төлөвлөн батлагдсан төсвийн хүрээнд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай байх зарчимд тулгуурлан зохион байгуулах, тайлагнах” гэсэн стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:</b>				
<b>ХӨТӨЛБӨР Ү</b>				
<b>“Худалдан авах ажиллагааны хууль, эрх зүйн орчныг сайжруулж, олон улсын хөгжлийн чиг хандлагыг судлан, худалдан авах ажиллагааны чадавхийг бэхжүүлэн цахим худалдан авах ажиллагааг боловсронгуй болгох” хөтөлбөрийн хүрээнд:</b>				
<b>Арга хэмжээ 5.1.29.</b> Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд тусгах санал боловсруулах	<ul style="list-style-type: none"> <li>- Хуулийн төсөлд тусгах санал боловсруулах;</li> <li>- Холбогдох байгууллага, албан хаагчдаас хуулийн төсөлд тусгах санал авах ажлыг зохион байгуулах;</li> <li>- Саналыг нэгтгэн боловсруулж, Сангийн яаманд хүргүүлэх;</li> <li>- Эхний хагас жилд.</li> </ul>	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль боловсронгуй болсон байна.	ЗХЗХ, Худалдан авах ажиллагааны хэлтэс (Цаашид “ХААХ” гэх), МТА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төлөөлөл ажиллаж, хуулийн төсөлд тодорхой асуудлаар санал тусгасан. Хуулийн төслийн үзэл баримтлал батлагдан УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэх асуудал дэмжигдэж, 2018 оны намрын чуулганаар хэлэлцэх хууль тогтоомжийн жагсаалтад тусгагдан. (Бүрэн хэрэгжсэн - 100%).
<b>Арга хэмжээ 5.2.30.</b> Цахим худалдан авах ажиллагаатай холбоотой журам, заавар, жишиг баримт бичгийг шинэчлэх төсөл боловсруулж, саналаа холбогдох байгууллагад хүргүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>- Шинэчлэх шаардлагатай дүрэм журам, заавар, жишиг баримт бичгийн жагсаалт гаргах, боловсруулах хугацаа, хуваарийг тодотгох;</li> <li>- Журам, заавар, жишиг баримт бичгийн төслийг боловсруулах;</li> <li>- Төслийг саналын хамт холбогдох байгууллагад хүргүүлэх;</li> <li>- Батлуулах арга хэмжээ авах;</li> <li>- Жилдээ.</li> </ul>	Цахим худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх зүйн орчин тодорхой болно.	МТА	“Цахим тендер зохион байгуулах журам”, “Тендерийн жишиг баримт бичиг”-т холбогдох өөрчлөлт оруулах санал боловсруулж, Сангийн яаманд хүргүүлэв.  ШӨХТГ-аас зохион байгуулсан “Зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийн хэлэлцүүлэгт ТӨБЗГ-ын газрын төлөөлөл оролцож, худалдан авах ажиллагаатай холбоотой санал хэлэлцүүлэв. (Бүрэн хэрэгжсэн – 100%)
<b>Арга хэмжээ 5.3.31.</b> 2019 онд зохион байгуулах улсын болон бүс нутгийн чанартай төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа, Ерөнхий гэрээгээр 2019 онд худалдан авах барааны жагсаалт батлуулах	<ul style="list-style-type: none"> <li>- Захиалагчаас санал авч нэгтгэх;</li> <li>- “Ерөнхий гэрээ”-ний худалдан авалтын жагсаалтад санал болгох бараа бүтээгдэхүүний эрэлт нийлүүлэлтийн судалгаа хийх;</li> <li>- Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд тусгуулах;</li> </ul>	Хуулийн хугацаанд багтаан жагсаалтыг батлуулсан байна.	ХААХ	2019 онд ТӨБЗГ-т зохион байгуулах худалдан авах ажиллагааны жагсаалт батлах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар 2018 онд хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд тусгуулан, жагсаалтын төслийг боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Жагсаалтын төслийг 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, 388 дугаар тогтоолоор баталсан. Уг тогтоолын 1 дүгээр хавсралтаар 9 төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 420.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 194 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 2019 онд ТӨБЗГ-т зохион байгуулахаар батлагдсан. Мөн тогтоолын 3 дугаар хавсралтаар ерөнхий гэрээ байгуулах замаар худалдан авах зарим ерөнхий нэршлийн эм, эмнэлгийн хэрэгсэл, чанар, стандартын

	<ul style="list-style-type: none"> <li>- Засгийн газрын шийдвэр, жагсаалтын төсөл боловсруулах;</li> <li>- Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулах;</li> <li>- X-XI сард.</li> </ul>			<p>шаардлага хангасан дотоодод үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүний жагсаалт батлагдсан.</p> <p>21 аймаг, нийслэл, дүүрэг, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой нийт 160 гаруй байгууллагаас “Ерөнхий гэрээ”-гээр худалдан авах бараа, бүтээгдэхүүний мэдээлэл авч, эрэлт нийлүүлэлтийн судалгаа хийсэн. (Бүрэн хэрэгжсэн – 100%)</p>
<p><b>Арга хэмжээ 5.4.32.</b> 2019 онд зохион байгуулах худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж, батлуулах</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Батлагдсан жагсаалтад тусгагдсан төсөл, арга хэмжээ бүрийг тусгасан тухайн Төсвийн ерөнхийлөн захирагч нар, ТӨБЗГ-ын хамтарсан төлөвлөгөө батлах;</li> <li>- 2019 онд ТӨБЗГ-аас зохион байгуулах худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг батлуулах;</li> <li>- Зохион байгуулах төсөл, арга хэмжээний ажлын даалгавар, зураг төслийг захиалагчаас хүлээн авч, худалдан авах ажиллагааны бэлтгэлийг хангах;</li> <li>- XI сард.</li> </ul>	Хуулийн хугацаанд багтаан хэрэгжүүлсэн байна.	ХААХ	<p>2019 онд ТӨБЗГ-т зохион байгуулах худалдан авах ажиллагааны жагсаалт Засгийн газрын 2018 оны 388 дугаар тогтоолоор батлагдсантай холбогдуулан холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нартай худалдан авах ажиллагааны хамтарсан төлөвлөгөө батлуулахаар ТӨБЗГ-ын 2018 оны 12 дугаар сарын 28-ны А-1/4805 тоот албан бичгийг 9 төсвийн захирагчид хүргүүлэв. Уг хамтарсан төлөвлөгөө батлагдсанаар 2019 онд зохион байгуулагдах худалдан авах ажиллагааны ерөнхий зохион байгуулалт хангагдана.</p> <p>(Бүрэн хэрэгжсэн – 100%)</p>
<p><b>Арга хэмжээ 5.5.33.</b> Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк болон гадаадын бусад байгууллагуудтай хамтран ажиллах</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Дэлхийн банк, Азийн хөгжлийн банктай хамтран ажиллах талаар уулзалт, ярилцлага зохион байгуулах;</li> <li>- Гадаадын бусад байгууллагатай хамтран ажиллах боломжийг судлах;</li> <li>- Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Ухаалаг засаг” төслийн хүрээнд хэрэгжих төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах;</li> </ul>	Гадаадын хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл, арга хэмжээний худалдан авалт бүрэн хийгдэж, гэрээ байгуулсан байна.	ХААХ	<p>Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк зэрэг олон улсын байгууллагатай хамтран ажиллах хүрээнд эдгээр байгууллагын зөвлөхүүд худалдан авах ажиллагааны мэргэжилтнүүдийн чадавхийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлж ажилласан. ТӨБЗГ нь эдгээр байгууллагаас санхүүжүүлэн хэрэгжих дор дурдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна.</p> <p>Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлэх Засгийн газрын Ухаалаг засаг төслийн хүрээнд 1.08 сая ам. долларын төсөвт өртөг бүхий “Иргэдийн санал, хүсэлтийн мэдээлэлд бизнес анализ хийх олон улсын зөвлөх сонгох”, “Төрийн энтерпрайз архитектурын зөвлөх үйлчилгээ” төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж байгаа бөгөөд эдгээр 2 төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээ хийж байна.</p> <p>“Мэргэжлийн хяналтын хорио цээрийн барилга байгууламжийн эх загвар зураг болон ажлын зураг төсөв боловсруулах, барилга угсралтын ажилд хяналт тавих” Л3313-МОН төсөл, арга хэмжээний</p>

	- Тухай бүр.			тендерийг дахин зарласан.  Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр боловсролын салбарт хэрэгжих “Баруун бүсийн сургуулийн бага ангийн сурагчдын дотуур байрны нөхцөлийг сайжруулах” төслийн хүрээнд 886.1 мянган ам.долларын төсөвт өртөг бүхий 1 төсөл, арга хэмжээний 4 багц ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан. (Хэрэгжих шатанд – 70%)
<b>Арга хэмжээ 5.6.34.</b> Аймаг, нийслэл, дүүргүүдэд төрийн худалдан авах ажиллагааны чадавхийг сайжруулах сургалт зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> <li>- Сургалтын хэрэгцээг тодорхойлох;</li> <li>- Сургалтын төлөвлөгөө, хуваарийг боловсруулан батлах;</li> <li>- Сангийн яам, сургалтын эрх бүхий ТББ-тай хамтран ажиллах;</li> <li>- Онлайн болон бусад хэлбэрээр шалгалт авч, гэрчилгээ олгох;</li> <li>- Цахим худалдан авах ажиллагааны системийн ашиглалтыг нэмэгдүүлэх гарын авлага, сургалтын материал бэлтгэх;</li> <li>- Эхний хагас жилд, 21 удаа.</li> </ul>	Орон нутагт худалдан авах ажиллагаа зохион байгуулах чадавх дээшилнэ. Улсын хэмжээнд зохион байгуулсан худалдан авах ажиллагааны 80-аас доошгүй хувийг цахим хэлбэрээр зохион байгуулсан байна.	ХААХ, МТА	<p>2018 онд худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх сургалт зохион байгуулах эрх бүхий 8 төрийн бус байгууллагын улсын хэмжээнд зохион байгуулсан сургалтад хамрагдсан нийт 7144 албан хаагч, иргэдээс 411 удаа цахим хэлбэрээр шалгалт авснаас 4161 (58.2 %)-т нь худалдан авах ажиллагааны суурь мэдлэг эзэмшигчийн гэрчилгээ (АЗ)-г олгов.</p> <p>2018 онд худалдан авах ажиллагааны суурь мэдлэг олгох сургалтад хамрагдаж гэрчилгээ эзэмшиж байгаа иргэний мэдээлэл, гэрчилгээний хүчинтэй хугацааг байгууллагын цахим хуудас <a href="http://www.pcsp.gov.mn">www.pcsp.gov.mn</a>, төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>-д хайлт хийх боломжтойгоор байршуулж, мэдээллийн нээлттэй байдлыг хангав.</p> <p>2018 оны жилийн эцсийн дүнгээр, улсын хэмжээнд худалдан авах ажиллагааны суурь мэдлэг эзэмшигчийн гэрчилгээ бүхий нийт 12970 иргэн төрийн худалдан авах ажиллагааны цахим системд бүртгэлтэй байна.</p> <p>Цахим худалдан авах ажиллагааны системийн сургалтыг худалдан авах ажиллагааны захиалагч байгууллага, тендерт оролцогч аж ахуйн нэгжийн төлөөлөлд нийт 89 удаа зохион байгуулж, 2014 албан хаагч, иргэнийг оролцуулан чадавхижуулсан.</p> <p>Архангай аймгийн захиалагч байгууллагуудын 24 албан хаагчид 2018 оны 6 дугаар сарын 8-ны өдөр, Өмнөговь аймагт 2018 оны 08 дугаар сарын 07-09-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “Салбарын албан хаагчдын зүүн бүсийн уулзалт”-д оролцож, худалдан авах ажиллагааны цахим системийн сургалтыг тус тус зохион байгуулсан. (Бүрэн хэрэгжсэн – 100%)</p>
<b>Арга хэмжээ 5.7.35.</b> Төрийн өмчит болон төрийн өмчийн	- Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани,	Төрийн өмчит болон төрийн өмчийн	МТА, ХААХ	1. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулах талаар заавар зөвлөмжийг тогтмол өгөхийн зэрэгцээ

<p>оролцоотой хуулийн этгээдэд худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулах арга хэмжээ авч, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах</p>	<p>ТӨҮГ-ыг албан хаагчдад хуваарилан хариуцуулах зохион байгуулалтын арга хэмжээ авах;</p> <ul style="list-style-type: none"> <li>- Зөвлөгөө, арга зүйгээр хангаж, сургалт, семинар зохион байгуулах;</li> <li>- Худалдан авах ажиллагаанд хяналт тавих;</li> <li>- Жилд.</li> </ul>	<p>оролцоотой компани, ТӨҮГ-ын зохион байгуулж байгаа худалдан авах ажиллагаанд тавих хяналт сайжирна.</p>		<p>нийт 90 төрийн өмчит компани, үйлдвэрийн газрын 190 төлөөллийг худалдан авах ажиллагааны цахим системийн сургалтад хамруулан чадавхижуулсан байна.</p> <ol style="list-style-type: none"> <li>2. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс нийт 5144 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөж, 2619 тендер шалгаруулалтын урилгыг зарлан мэдээлснээс 2289 нь цахим тендер шалгаруулалтын урилга байгаа нь нийт зарласан тендерийн 87.2 хувийг эзэлж байна.</li> <li>3. “Худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны 2017 оны тайлан болон 2018 оны төлөвлөгөөг ирүүлэх тухай ТӨБЗГ-ын А/3672 албан бичгийг төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 85 хуулийн этгээдэд хүргүүлж, энэ талаар чиглэл зөвлөмж өгсөн. Тэдгээрээс ирүүлсэн тайлан, төлөвлөгөөг нэгтгэх ажлыг гүйцэтгэсэн.</li> <li>4. “Төрийн өмчийн менежмент ба нийгмийн хариуцлага-2018” өдөрлөгийн үеэр зохион байгуулагдсан төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн захирлуудад зориулсан сургалт-семинарт “Худалдан авах ажиллагааны өнөөгийн байдал, шийдвэрлэх асуудал” сэдэвт илтгэл тавьж, хэлэлцүүлсэн.</li> <li>5. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйлдвэрлэл, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх явцад худалдан авах ажиллагаанд хяналт тавьж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ аван мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэгээр ханган ажилласан.</li> <li>6. Орон нутгийн худалдан авах ажиллагааны нэгжийн албан хаагчдын нэгдсэн сургалт-семинарын үеэр орон нутаг дахь төрийн болон орон нутгийн өмчит компани, үйлдвэрийн газрын зохион байгуулж буй худалдан авах ажиллагаанд хяналт тавих, дэмжлэг үзүүлэх, арга зүйгээр хангах талаар мэдээлэл, зөвлөгөө, чиглэл өгөв.</li> </ol> <p>(Бүрэн хэрэгжсэн – 100%)</p>
<p><b>Арга хэмжээ 5.8.36.</b> Чанар, стандартын шаардлага хангасан бараа үйлдвэрлэдэг үндэсний үйлдвэрлэгчийг тендер шалгаруулалтад хэрхэн</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Хуулийн давуу эрхийг хэрхэн ашиглаж тендер оролцох талаар үндэсний үйлдвэрлэгч нарт зориулсан сургалт, уулзалт зохион байгуулах, 2 удаа;</li> </ul>	<p>Үндэсний үйлдвэрийн худалдан авалт нэмэгдсэн байна.</p>	<p>ХААХ</p>	<p>2018 онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт зохион байгуулах худалдан авах ажиллагааны жагсаалтад дотоодод үйлдвэрлэсэн, чанар стандартын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүн худалдан авах боломж бүхий төсөл, арга хэмжээ тусгагдаагүй. Тухайлбал, эмнэлгийн тоног төхөөрөмжийн 10 худалдан авах ажиллагаа байсан хэдий ч захиалагчаас ирүүлсэн техникийн тодорхойлолт, барааны жагсаалтад дотоодод</p>

<p>оролцох талаар мэргэжил, арга зүйн удирдлага, чиглэлээр хангах</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Худалдан авах ажиллагааг холбогдох журмын дагуу зохион байгуулж, дотоодын давуу эрхийг тооцож, мэдээлэх;</li> <li>- Тендер шалгаруулалтын ил тод байдлыг хангах;</li> <li>- Жилдээ.</li> </ul>			<p>үйлдвэрлэсэн, чанар стандартын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүн байж болох талаар шаардлага тавиагүй байсан.</p> <p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 2018 онд зарласан нийт 133 тендер шалгаруулалтыг зохион байгуулахдаа дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, дэмжих зорилгоор үндэсний үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэсэн, чанар стандартын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүнийг барилга угсралтын ажилд ашиглах тохиолдолд бараа материал болон ажиллах хүчний хувьд дотоодын давуу эрх тооцохоор тендерийн баримт бичигт тусгасан. 2018 онд гэрээ байгуулсан 121 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтад хүсэлт ирүүлсэн 31 компанид дотоодын давуу эрх тооцож олгосон байна.</p> <p>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас зохион байгуулсан дотоодын үйлдвэрлэгчдэд зориулсан семинарын үеэр дотоодын үйлдвэрлэгчдийн бараа, бүтээгдэхүүнийг худалдан авах ажиллагаагаар дэмжих асуудлаар санал солилцсон.</p> <p>(Бүрэн хэрэгжсэн – 100%)</p>
<p><b>Арга хэмжээ 5.9.37.</b> Үнэлгээний хорооны хурал зохион байгуулах нөхцлийг бүрдүүлж, ил тод нээлттэй байдлыг хангах</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Үнэлгээний хороо хуралдах орчин нөхцлийг бүрдүүлэх;</li> <li>- Холбогдох тоног төхөөрөмжөөр хангаж, техникийн нөхцлийг бүрдүүлэх;</li> <li>- Худалдан авах ажиллагааг холбогдох журмын дагуу зохион байгуулах;</li> <li>- Тендер шалгаруулалтын ил тод байдлыг бий болгох;</li> <li>- Эхний хагас жилд.</li> </ul>	<p>Худалдан авах ажиллагаа хуулийн хугацаанд хууль, журам, зааврын дагуу зохион байгуулагдсан байна.</p>	<p>ХААХ</p>	<p>Үнэлгээний хорооны хуралдааны нөхцлийг сайжруулах хүрээнд техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийж, зөөврийн 8 компьютер, 6 принтер, 10 дуу хураагуур шинээр худалдан авсан. Энэхүү худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороо байгуулан ажиллуулж, нийлүүлэгчийг сонгон шалгаруулах замаар худалдан авсан. Тус худалдан авалт нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны төсвийн урсгал зардлаар худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөнд тусгагдсан болно.</p> <p>Худалдан авах ажиллагааг 100 хувь цахим хэлбэрээр зохион байгуулж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг байгууллагын цахим хуудас <a href="http://pcsp.gov.mn">http://pcsp.gov.mn</a>, төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <a href="https://tender.gov.mn">https://tender.gov.mn</a> -д тухай бүр байршуулан олон нийтэд мэдээлж байна. (Бүрэн хэрэгжсэн – 100%)</p>
<p><b>ХӨТӨЛБӨР ҮІ</b> “Худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай зохион байгуулж, мэдээллийн санг бүрдүүлэн баяжуулах” хөтөлбөрийн хүрээнд:</p>				
<p><b>Арга хэмжээ 6.1.38.</b> Засгийн газрын 2017</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Үнэлгээний хороо байгуулах;</li> </ul>	<p>Худалдан авах ажиллагаа</p>	<p>ХААХ</p>	<p>ТӨБЗГ-т улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 174.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий нийт 133 (эрх шилжиж ирсэн 5</p>



<p>оны 315 дугаар тогтоолын 1, 2 дугаар хавсралтаар батлагдсан төсөл, арга хэмжээ болон захиалагчаас эрх шилжиж ирсэн ажлуудын худалдан авах ажиллагааг зохион байгуулах</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Худалдан авах ажиллагааг холбогдох журмын дагуу зохион байгуулах;</li> <li>- Шаардлагад нийцсэн тендерт оролцогчтой хуулийн хугацаанд гэрээ байгуулах боломж нөхцлийг хангах;</li> <li>- Тендер шалгаруулалтын ил тод байдлыг хангах;</li> <li>- Жилдээ.</li> </ul>	<p>хуулийн хугацаанд хууль, журам, зааврын дагуу зохион байгуулагдсан байна.</p>		<p>төсөл, арга хэмжээг оруулсан) төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий үнэлгээний хороог байгуулж, худалдан авах ажиллагааны талаарх хууль тогтоомжийн хүрээнд тендер шалгаруулалтыг зохион байгуулж ажиллав.</p> <p>2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар, 155.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 121 төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, 123.4 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий гэрээ байгуулсан. Эдгээр 121 гэрээг гүйцэтгэгчтэй байгуулснаар улсын төсөвт 32.2 тэрбум төгрөгийн хэмнэлт бий болгосон. Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн явц 91.0 хувьтай байна.</p> <p>“Зарим ерөнхий нэршлийн эмийг ерөнхий гэрээгээр худалдан авах” төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсны үр дүнд 2018 оны жилийн эцсийн дүнгээр улсын төсөвт 325.4 сая төгрөгийн хэмнэлт гаргасан. (Бүрэн хэрэгжсэн – 100%)</p>
<p><b>Арга хэмжээ 6.2.39.</b> 2018 онд Ерөнхий гэрээгээр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Холбогдох яамнаас тухайн нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний судалгааг авах;</li> <li>- Ерөнхий гэрээгээр худалдан авах барааны тендерийн баримт бичгийг боловсруулан худалдан авалтыг цахим хэлбэрээр зохион байгуулах;</li> <li>- I улиралд худалдан авах ажиллагааг зохион байгуулж эхлэх.</li> </ul>	<p>2018 онд ерөнхий гэрээгээр худалдан авах барааг “Цахим дэлгүүр”-ээс худалдан авсан байна.</p>	<p>ХААХ</p>	<p>Засгийн газрын 2017 оны 315 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 2018 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт”-д “Зарим ерөнхий нэршлийн эмийг ерөнхий гэрээгээр худалдан авах” ажил тусгагдсан. Энэхүү ерөнхий гэрээний худалдан авах ажиллагааг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <a href="https://tender.gov.mn">https://tender.gov.mn</a> -ийн дэд систем болох “Цахим дэлгүүр”-ээр дамжуулан Монгол улсад анх удаа зохион байгуулж байна. Зарим ерөнхий нэршлийн 17 нэр төрлийн эмийг ханган нийлүүлэх 10 аж ахуйн нэгжтэй давхардсан тоогоор 40 ерөнхий гэрээ байгуулсан. 2018 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар ерөнхий гэрээний худалдан авах ажиллагааны үр дүнд нийт 361 удаагийн захиалгаар 814144 ширхэг эм худалдан борлуулагдсан бөгөөд улсын төсөвт 325.4 сая төгрөгийн хэмнэлт гарсан тооцоотой байна.</p> <p>(Бүрэн хэрэгжсэн – 100%)</p>
<p><b>Арга хэмжээ 6.3.40.</b> 2018 онд зохион байгуулах тендерийн урилга, зарыг нийтлүүлэх өдөр тутмын сонинг сонгон шалгаруулах</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Ажлын хэсэг байгуулах;</li> <li>- Нээлттэй сонгон шалгаруулалт зохион байгуулж, ил тод мэдээлэх, I сард;</li> <li>- Зохион байгуулагдаж буй төсөл, арга хэмжээний урилга, зарыг хуулийн</li> </ul>	<p>Тендерийн урилга, зар, мэдээлэл олон нийтэд хүртээмжтэй, ил тод мэдээлэгдэнэ.</p>	<p>ХААХ</p>	<p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2018 онд хэрэгжүүлэх худалдан авах ажиллагааны тендерийн урилга, зар нийтлүүлэх өдөр тутмын сонинг сонгон шалгаруулах дотоодын нээлттэй тендер шалгаруулалтыг зохион байгуулав. Тендерийн нээлтийг 2018 оны 1 дүгээр сарын 09-ний өдөр хийхэд Өдрийн сонин, Өнөөдөр, Засгийн газрын мэдээ, Үндэсний шуудан, Зууны мэдээ сонин тус тус тендер ирүүлсэн. Өдөр тутмын 3 хүртэлх сонинг</p>

	<p>хугацаанд шуурхай мэдээлэх;</p> <ul style="list-style-type: none"> <li>- Урилга нийтлүүлсэн өдөр тутмын сонин хэвлэлээр хадгаламжийн нэгж үүсгэн архивт хүлээлгэн өгөх;</li> <li>- Жилдээ.</li> </ul>			<p>сонгон шалгаруулах шаардлагын дагуу үнэгээний хороо үнэлгээ хийж, Өнөөдөр, Өдрийн сонин, Зууны мэдээ сонинтой 2018 оны 02 дугаар сарын 01-ний өдөр гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.</p> <p>(Бүрэн хэрэгжсэн – 100%)</p>
<p><b>Арга хэмжээ 6.4.41.</b> 2018 онд зохион байгуулах тендер шалгаруулалтын үнэлгээний хороонд ажиллах Төрийн бус байгууллага болон мэргэжлийн холбоодын шинэчилсэн бүртгэл хийх</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын шинэчилсэн бүртгэл хийх зарыг байгууллагын цахим хуудас болон сониноор зарлах;</li> <li>- Үнэлгээний хороонд ажиллах төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодыг зохих журмын дагуу сонгон шалгаруулах;</li> <li>- Шинээр бүртгэгдсэн ТББ-ын төлөөлөлтэй хамтран ажиллах гэрээ байгуулах;</li> <li>- ТББ-ын төлөөллийг чадавхижуулах сургалт зохион байгуулах;</li> <li>- I сард.</li> </ul>	<p>Тендер шалгаруулалтын үнэлгээний хороонд нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр томилогдсон ТББ-ын төлөөллийг томилон ажиллуулж, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.</p>	<p>ХААХ</p>	<p>Төрийн бус байгууллага болон мэргэжлийн холбоодын шинэчилсэн бүртгэл хийх зарыг байгууллагын цахим хуудас <a href="http://www.pcsp.gov.mn">www.pcsp.gov.mn</a> –д 2017 оны 11 дүгээр сарын 15–ны өдрөөс 2018 оны 02 дугаар сарын 05-ны өдрийг хүртэл байршуулан нээлттэй зарлан мэдээлсэн.</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.4-т заасны дагуу худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд ажиллах хүсэлтэй төрийн бус 54 байгууллагын 80 төлөөлөлтэй хамтран ажиллах гэрээг шинэчлэн байгуулсан. Тэдгээрээс сонгон шалгаруулах зарчмаар нэг үнэлгээний хороонд төрийн бус байгууллагын 2 төлөөллийг оролцуулан үнэлгээний хороог байгуулан ажиллуулж байна. Худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд ажиллах төрийн бус байгууллагын гишүүнд худалдан авах ажиллагааны суурь мэдлэг эзэмшсэн байх шалгуурыг тавьж, шаардлага хангасан төлөөллийг сонгон шалгаруулж ажиллуулсан болно.</p> <p>2019 онд хамтран ажиллах Төрийн бус байгууллага болон мэргэжлийн холбоодын шинэчилсэн бүртгэл хийх зарыг байгууллагын цахим хуудас <a href="http://pcsp.gov.mn">http://pcsp.gov.mn</a> –нд байршуулаад байна. (Бүрэн хэрэгжсэн – 100%)</p>
<p><b>Арга хэмжээ 6.5.42.</b> Тендер шалгаруулалтын үр дүнг олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлэх</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Гэрээ байгуулсан ажлын үр дүнг тухай бүр цахим хуудсанд нийтлэх;</li> <li>- Захиалагчтай гэрээ байгуулсан ААН-ийн бүртгэлийг байгууллагын цахим хуудсанд ил тод байршуулах;</li> <li>- Худалдан авах ажиллагааны явц, үр дүнг олон нийтэд мэдээлэх;</li> </ul>	<p>Худалдан авах ажиллагааны нээлттэй байдал хангагдсан байна.</p>	<p>ХААХ, МТА</p>	<p>Тайлант хугацаанд, 2018 онд ТӨБЗГ-т улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 133 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 155.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 121 төсөл, арга хэмжээнд 136 аж ахуй нэгжтэй 123,04 тэрбум төгрөгийн гэрээ байгуулж, 32.2 тэрбум төгрөгийн төсвийн хэмнэлт гаргав. Эдгээр худалдан авах ажиллагааны үр дүнг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> –д нийтэлж, олон нийтэд нээлттэй мэдээлэв.</p> <p>ТӨБЗГ нь төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> –ийг хариуцан эрхэлж, хэвийн ажиллагааг ханган ажиллав. Уг системийг улсын хэмжээний худалдан авах</p>

	- Жилдээ.			ажиллагаанд ашиглаж байгаа бөгөөд систем дэх тендер шалгаруулалтын үр дүнг танилцуулбал (2018.12.31-ний өдрийн байдлаар):  1. Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> -ээр нийт 10202 үр дүн мэдээлэгдсэнээс 1955 нь нээлтийн, 8021 нь тендер шалгаруулалтын, 226 нь хянан үзсэн болон явц үр дүн байна. 2. Нийт 1511 гэрээ бүртгэгдсэн ба хамгийн олон бөгөөд өндөр дүнтэй гэрээг ТӨБЗГ-ын төлөөлөл хэрэгжүүлдэг төрийн өмчит хуулийн этгээдэд байгуулсан байна (31.6 тэрбум төгрөгийн 141 гэрээ).  Худалдан авах ажиллагааны үр дүнгийн мэдээллийг цахим системд хэрхэн бүртгэх талаарх зааварчилга, зөвлөмжийг захиалагч байгууллагад тухай бүр өгч, мэдээлэл, арга зүйгээр тогтмол хангав.  (Бүрэн хэрэгжсэн – 100%)
<b>Арга хэмжээ 6.6.43.</b> 2017 онд зохион байгуулсан худалдан авах ажиллагааны тайланг нэгтгэн боловсруулах	- Зохион байгуулсан худалдан авах ажиллагааны нэгдсэн тайланг нэгтгэх; - Дүгнэлт, дүн шинжилгээ бүхий тайланг боловсруулах; - Тайланг Сангийн яаманд хүргүүлэх; - Байгууллагын цахим хуудсанд байршуулж, олон нийтэд ил тод мэдээлэх; - I/15-ны дотор.	Худалдан авах ажиллагааны тайлан мэдээг хуулийн хугацаанд дээд шатны байгууллагад тайлагнасан байна.	ХААХ	2017 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны тайланг 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн А-1/111 дүгээр албан бичгээр, 2018 оны эхний хагас жилийн худалдан авах ажиллагааны тайланг 2018 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн А-2/2128 дугаар албан бичгээр Сангийн яаманд тус тус хүргүүлсэн. Худалдан авах ажиллагааны 2018 оны жилийн эцсийн тайланг хуулийн хугацаанд буюу 2019 оны 01 дүгээр сарын 15-ны дотор хүргүүлэхээр бэлтгэж байна. (Бүрэн хэрэгжсэн – 100%)
<b>Арга хэмжээ 6.7.44.</b> Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан худалдан авах ажиллагаатай холбоотой зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх	- Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ”-ний төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг тодорхой төлөвлөх, хэрэгжүүлэх; - Холбогдох тайлан мэдээллийг гаргаж, тайлагнах;	Худалдан авах ажиллагаан дахь авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөө сайжирсан байна.	ХААХ, МТА	Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ”-ний төлөвлөгөөнд тусгагдсан худалдан авах ажиллагаатай холбоотой заалтын 2017 оны хэрэгжилтийг гаргаж, байгууллагын нэгдсэн тайланд тусган Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн 2017 оны тайланг 2018 оны А-1/298 дугаар албан бичгээр, 2018 оны эхний хагас жилийн тайланг цахим хэлбэрээр тус тус Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан 4 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх холбогдох 17 арга хэмжээний хэрэгжилт 2018 оны эхний хагас жилийн байдлаар 70 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” үнэлгээтэй байна. Жилийн эцсийн

	- Жилдээ.			тайланг гаргахаар бэлтгэж байна. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардалд зориулж 157,832.8 мянган төгрөгийг байгууллагын төсөвт тусган батлуулсан. Мэдээллийн ил тод байдлыг хангах, цахим худалдан авах ажиллагааг зохион байгуулах, албан хаагчдыг соён гэгээрүүлэх, худалдан авах ажиллагааны чадавхийг дээшлүүлэхэд чиглэсэн ажилд нийт 157,519.4 мянган төгрөгийг зарцуулсан байна. (Бүрэн хэрэгжсэн – 100%)
<b>Арга хэмжээ 6.8.45.</b> Орон нутгийн нэгжүүдийн худалдан авах ажиллагааны 2018 оны төлөвлөгөөг газрын цахим хуудсанд байршуулан ил тод мэдээлж, өрсөлдөх тэгш боломж нөхцлийг бүрдүүлэх	- Худалдан авах ажиллагааны нэгжүүдэд зохион байгуулах худалдан авах ажиллагааны мэдээллийн нэгдсэн сан бий болгох; - Газрын цахим хуудсанд байршуулан мэдээллийн ил тод байдлыг хангах; - I сард.	Худалдан авах ажиллагааны мэдээллийн ил тод, нээлттэй байдал хангагдсан байна.	ЗХЗХ	2018 онд 21 аймгийн ОНӨГ, нийслэлийн ХААГ, 9 дүүргийн ХААА-нд нийт 763.3 тэрбум төгрөгийн 4273 (100 хувь) төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулагдахаар төлөвлөгдсөн. Орон нутгийн нэгжид зохион байгуулах төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг санхүүжилтийн эх үүсвэрээр нь харуулбал: - Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 268.5 тэрбум төгрөгийн 851 (20 хувь) төсөл, арга хэмжээ; - Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 257.4 тэрбум төгрөгийн 1262 (29 хувь) төсөл, арга хэмжээ; - Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 44.6 тэрбум төгрөгийн 604 (14 хувь) төсөл, арга хэмжээ; - Сангийн хөрөнгө оруулалтаар 58.9 тэрбум төгрөгийн 303 (7 хувь) төсөл, арга хэмжээ; - Зээл тусламжийн хөрөнгө оруулалтаар 46.1 тэрбум төгрөгийн 12 (2 хувь) төсөл арга хэмжээ; - Урсгал зардлаар 21.3 тэрбум төгрөгийн 956 (22 хувь) төсөл, арга хэмжээ; - Нийслэл, аймгийн өөрийн хөрөнгө оруулалтаар 23.9 тэрбум төгрөгийн 179 (4 хувь) төсөл, арга хэмжээ; - Бусад хөрөнгө оруулалтаар 42.6 тэрбум төгрөгийн 106 (2 хувь) төсөл, арга хэмжээ байна. Орон нутгийн худалдан авах ажиллагааны нэгжийн 2018 оны худалдан авалтын төлөвлөгөөг ТӨБЗГ-ын <a href="http://www.pcsp.gov.mn">www.pcsp.gov.mn</a> цахим хуудсанд байршуулж, мэдээллийн ил тод байдлыг ханган ажилласан. (Бүрэн хэрэгжсэн – 100%)
<b>Арга хэмжээ 6.9.46.</b> Орон нутгийн худалдан авах ажиллагааны нэгжийн 2018 онд	- Орон нутгийн худалдан авах ажиллагааны нэгжийн зохион байгуулсан төсөл, арга	Орон нутгийн худалдан авах ажиллагааны нэгж тендер	ЗХЗХ	21 аймгийн Орон нутгийн өмчийн газар, Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар, 9 дүүргийн Худалдан авах ажиллагааны албаны 2018 оны худалдан авах ажиллагааны 1, 2, 3 дугаар улирлын худалдан авалтын мэдээг батлагдсан маягтын дагуу хүлээн авч

<p>зохион байгуулсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавих</p>	<p>хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, үр дүнг нэгтгэх;</p> <ul style="list-style-type: none"> <li>- Холбогдох байгууллага болон олон нийтэд мэдээлэх;</li> <li>- Улирал бүр.</li> </ul>	<p>шалгаруулалтыг үр дүнтэй зохион байгуулсан байна.</p>	<p>нэгтгэн хяналт тавьж ажиллав.</p> <p>2018 оны 3 дугаар улирлын тайлангийн дүнгээр (өссөн дүн), орон нутгийн худалдан авах ажиллагааны 31 нэгжид 977.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 3006 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөсөн.</p> <p>Нийт төсөл, арга хэмжээний 88.6 хувь буюу 872.0 тэрбум төгрөгийн 2665 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулагдсан, 0.7 хувь буюу 1.4 тэрбум төгрөгийн 19 төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийг боловсруулж байгаа, 10.7 хувь буюу 103.6 тэрбум төгрөгийн 322 төсөл, арга хэмжээ нь тодотголоор хасагдсан, зураг төсөв, ажлын даалгаваргүй гэсэн шалтгаанаар зохион байгуулагдаагүй.</p> <p>Зохион байгуулагдсан худалдан авах ажиллагааны явц, үр дүн:</p> <ul style="list-style-type: none"> <li>- 738.5 тэрбум төгрөгийн 2534 (84.2%) төсөл, арга хэмжээний гүйцэтгэчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулсны дүнд 41.1 тэрбум төгрөгийн хэмнэлт гарсан;</li> <li>- 119.3 тэрбум төгрөгийн 80 (2.7%) төсөл, арга хэмжээний үнэлгээ хийгдэж байгаа;</li> <li>- 14.2 тэрбум төгрөгийн 51 (1.7%) төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийг олгох, тендер хүлээн авах шатанд байна.</li> </ul> <p>Орон нутгийн худалдан авах ажиллагааны нэгжид зохион байгуулагдсан худалдан авах ажиллагааны 95.0 хувийг цахим хэлбэрээр зохион байгуулсан байна.</p> <p>2018 оны 3 дугаар улирлын байдлаар, зохион байгуулагдсан 2665 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны 3.7 хувь буюу 99 төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтад Сангийн яам, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт гомдол гарсан.</p> <p>2018 оны жилийн эцсийн тайланг орон нутгийн нэгжүүдээс хүлээн авч байгаа бөгөөд нэгтгэл, дүн гарч дуусаагүй байна.</p> <p>Үнэлгээнд өгөх тайлбар: 2018 оны дүн мэдээ 2019 оны 1 сард гарах тул хэрэгжилт хангагдсан гэж үзэв. (Бүрэн хэрэгжсэн – 100%)</p>
<p><b>Дөрөв. “Захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, хууль, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, мэдээлэл, технологийн хөгжлийг хангах” гэсэн стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:</b></p>			

<b>ХӨТӨЛБӨР ҮИ</b> <b>“Төрийн болон орон нутгийн өмчийн харилцаа, худалдан авах ажиллагаанд хууль, эрх зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, бүтцийн нэгжүүдийн уялдаа холбоог хангаж, захиргааны удирдлагыг хэрэгжүүлэх” хөтөлбөрийн хүрээнд:</b>				
<p><b>Арга хэмжээ 7.1.47.</b> Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчид үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээний биелэлтийн дагуу урамшуулал олгох харилцааг зохицуулсан журам боловсруулах, батлах</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Судалгаа хийх;</li> <li>- Журмын төсөл боловсруулах;</li> <li>- Журмын төсөлд албан хаагчдаас санал авах;</li> <li>- Журмын төслийг Даргын зөвлөлөөр хэлэлцүүлэн, батлах, II улиралд;</li> <li>- Хэрэгжилтийг ханган ажиллах, жилдээ.</li> </ul>	<p>Газрын албан хаагчдын ажлын үр дүнг харгалзан урамшуулах асуудал тодорхой болно.</p>	<p>ЗХЗХ, Ажлын хэсэг</p>	<p>“Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчид үр дүнгийн гэрээний биелэлтийн урамшуулал олгох журам”-ын төсөлд албан хаагчдын саналыг тусган боловсруулав.</p> <p>2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх Төрийн албаны хууль (шинэчилсэн найруулга)-ийн 55 дугаар зүйлийн 55.2-т төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх, тэдгээртэй холбогдуулан төрийн албан хаагчийг албан тушаал дэвшүүлэх, цалин хөлсийг өөрчлөх, урамшуулал олгох, хариуцлага хүлээлгэх журмыг Засгийн газар батлахаар хуульчлагдсан тул уг журмыг батлагдан, дагаж мөрдөгдөх хүртэлх хугацаагаар хойшлуулсан.</p> <p>(Хэрэгжих шатанд – 70%)</p>
<p><b>Арга хэмжээ 7.2.48.</b> Нууцын журам боловсруулах, батлах</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Журмын төслийг хууль тогтоомж, эрх зүйн актад нийцүүлэн боловсруулах;</li> <li>- Журмын төсөлд Тагнуулын байгууллагаас санал авах;</li> <li>- Төслийг хянаж, Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлах;</li> <li>- I-II улиралд.</li> </ul>	<p>Байгууллагын нууцын асуудал хууль, эрх зүйн хүрээнд зохион байгуулагдана.</p>	<p>ЗХЗХ, Ажлын хэсэг</p>	<p>“Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төрийн болон албаны нууцыг хамгаалах журам”-ын төслийг боловсруулж, Тагнуулын ерөнхий газарт 2018 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн А-1/4200 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>Тагнуулын ерөнхий газраас 2018 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 01/1855 тоот албан бичгээр “Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам”-ыг мөрдөж ажиллах тухай хариу ирүүлсэн тул уг журам батлах шаардлагагүй болсон.</p> <p>(Бүрэн хэрэгжсэн -100%)</p>
<p><b>Арга хэмжээ 7.3.49.</b> Тогтоол шийдвэрийн биелэлт, гүйцэтгэл, үр дүнг тайлагнах журам боловсруулах, батлах</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Журмын төслийг Засгийн газрын 2017 онд 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д нийцүүлэн боловсруулах;</li> <li>- Журмын төсөлд албан хаагчдаас санал авах;</li> <li>- Даргын зөвлөлийн хурлаар</li> </ul>	<p>Байгууллагын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнг тайлагнах ажлын зохион байгуулалт сайжирна.</p>	<p>ЗХЗХ, Ажлын хэсэг</p>	<p>Мэдээ, тайлангийн хугацаа, хуваарийг албан хаагчдад мэдээлэн тухай бүр графикт хугацааны дагуу тайлан мэдээг гаргаж, дээд шатны байгууллагад хүргүүлсэн. Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан хугацаа хуваарийг байгууллагын үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж байна. Гүйцэтгэл, тайлагналтын зохион байгуулалт, үр дүнг сайжруулах зорилгоор байгууллагын хэмжээнд мөрдөх журам боловсруулж байгаа, эцэслэн батлагдаагүй байна. 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөгдөх Төрийн албаны хуулийн шинэчилсэн найруулгад тусгагдсан байгууллага, албан хаагчийн гүйцэтгэлийн</p>



	<ul style="list-style-type: none"> <li>- хэлэлцүүлж, батлах;</li> <li>- Хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;</li> <li>- I улиралд.</li> </ul>			<p>төлөвлөгөө, тайлан, үнэлгээтэй холбоотой Засгийн газраас батлах журамтай нийцүүлэх шаардлага үүсч байгаа.</p> <p>(Хэрэгжих шатанд - 70%)</p>
<p><b>Арга хэмжээ 7.4.50.</b> Байгууллагын “Гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөө” боловсруулах, батлах</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Ажлын хэсэг байгуулах;</li> <li>- Байгууллагын гамшгаас хамгаалах бэлэн байдлын нөхцөл байдалд үнэлгээ, судалгаа хийх;</li> <li>- “Гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөө”-ний төслийг Гамшгаас хамгаалах тухай хуульд нийцүүлэн боловсруулах;</li> <li>- Төслийг Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх;</li> <li>- Төслийг хуульд заасны дагуу холбогдох мэргэжлийн байгууллагаар хянуулах, батлах, I улиралд;</li> <li>- Төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах, жилдээ.</li> </ul>	<p>Гамшгаас хамгаалах бэлэн байдал хангагдаж, гамшиг, ослын үеийн менежмент боловсронгуй болно.</p>	<p>ЗХЗХ, Ажлын хэсэг</p>	<p>“Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөө”-г боловсруулан, Төрийн ордны Онцгой байдлын албаны гал түймрийн улсын хяналтын байцаагч, онцгой байдлын ахмад Н.Мөнгөнхөлөгт хянуулан мэргэжил, арга зүйн зөвлөгөө авсан. Холбогдох өөрчлөлт, засварыг хийж, Баянзүрх дүүргийн Онцгой байдлын албаар батлуулахаар хүргүүлсэн боловч байгууллагын гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийгээгүй шалтгаанаар батлагдаагүй.</p> <p>Мөн ТӨБЗГ-ын 2018 оны төсөвт байгууллагын гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх зардлыг суулгах санал хүргүүлсэн боловч төсөвт тусгагдаагүйн улмаас төлөвлөгөө батлагдаагүй.</p> <p>(Хэрэгжих шатанд – 70 %)</p>
<p><b>Арга хэмжээ 7.5.51.</b> Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөлд тусгах санал боловсруулах</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Ажлын хэсэг байгуулах;</li> <li>- Хэлтсүүдээс санал авч, нэгтгэн боловсруулах;</li> <li>- Саналыг ажлын хэсгийн хурлаар хэлэлцэх;</li> <li>- Саналын төслийг Даргын зөвлөлд танилцуулж, Сангийн яаманд хүргүүлэх;</li> <li>- I улиралд.</li> </ul>	<p>МУ-ын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тодорхой санал тусгагдсан байна.</p>	<p>ЗХЗХ, Ажлын хэсэг</p>	<p>Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөлд тусгах санал боловсруулах ажлыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс хариуцан зохион байгуулж, саналыг Сангийн яаманд хүргүүлсэн. (Бүрэн хэрэгжсэн – 100%)</p>
<p><b>Арга хэмжээ 7.6.52.</b> Газрын дотоод аудитын үйл ажиллагааны 2018 оны төлөвлөгөө боловсруулах, батлах</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Төлөвлөгөөний төслийг боловсруулах;</li> <li>- Батлах, I сард;</li> <li>- Албан хаагчдад танилцуулан, ил тод мэдээлэх;</li> <li>- Дотоод аудитын үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах,</li> </ul>	<p>Байгууллагын үйл ажиллагаа, эрсдэлийн удирдлага сайжирна.</p>	<p>ЗХЗХ</p>	<p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дотоод аудитын 2018 оны төлөвлөгөөнд нийт 9 ажил тусган боловсруулж, газрын даргын 2018 оны А/14 дүгээр тушаалаар баталсан. Төлөвлөгөөнд төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Шилэн дансны хуулийн хэрэгжилт, ТУЗ-д өгсөн удирдамжийн биелэлт, ТӨБЗГ-ын төсвийн зарцуулалт, архив, албан хэрэг хөтлөлт, худалдан авах ажиллагаа, түрээсийн гэрээ, дуудлага худалдаа, үндсэн хөрөнгө актлах шийдвэр, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан гэрээний хэрэгжилтэд аудит хийхээр</p>

	жилдээ.			<p>тусгасан. Уг төлөвлөгөөг байгууллагын дотоод сүлжээ <a href="http://www.able.mn">www.able.mn</a> –д байршуулан нийт албан хаагчид мэдээлсэн.</p> <p>Тус төлөвлөгөөнд тусгагдсан төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Шилэн дансны хуулийн хэрэгжилт, ТУЗ-д өгсөн удирдамжийн биелэлт, дуудлага худалдаа, үндсэн хөрөнгө актлах шийдвэрийн биелэлтэд аудит хийсэн боловч дүгнэлт, зөвлөмж эцэслэн гараагүй байна. 2018 онд “Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хийсэн гэрээ”-ний хэрэгжилтэд 12 дугаар сард аудит хийсэн бөгөөд тус аудитын дүгнэлт, зөвлөмжийг ТӨБЗГ-ын Даргын зөвлөлд танилцуулахаар бэлтгэв.</p> <p>(Хэрэгжих шатанд – 70%)</p>
<p><b>Арга хэмжээ 7.7.53.</b> Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах, хэрэгжүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2018 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулах;</li> <li>- Төлөвлөгөөнд АТГ-аас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг тусгах;</li> <li>- Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, батлах, II сард;</li> <li>- Цахим хуудсанд байршуулж, олон нийтэд ил тод мэдээлэх;</li> <li>- Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах;</li> <li>- 2017 оны төлөвлөгөөний биелэлтийг гаргаж, Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх;</li> <li>- Жилдээ.</li> </ul>	Авлигын эсрэг хууль тогтоомжид заасан үүрэг биелсэн байна.	ЗХЗХ	<p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг нийт 33 заалттайгаар боловсруулж, газрын даргын 2018 оны А/85 дугаар тушаалаар батлан хэрэгжүүлж байна. Төлөвлөгөөнд авлигын эсрэг хууль тогтоомж, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн холбогдох заалт, Авлигатай тэмцэх газраас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг тусгасан. Уг төлөвлөгөөг байгууллагын дотоод сүлжээ <a href="http://www.able.mn">www.able.mn</a>, байгууллагын цахим хуудас <a href="http://www.pcsp.gov.mn">www.pcsp.gov.mn</a> –д байршуулан нийт албан хаагчид болон олон нийтэд мэдээлэн сурталчилсан. Төлөвлөгөөний хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар тайлагнахаар бэлтгэж байна, хугацаа болоогүй.</p> <p>Тайлант хугацаанд, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн 2017 оны тайланг 2018 оны А-1/298 дугаар албан бичгээр, 2018 оны эхний хагас жилийн тайланг цахим хэлбэрээр Авлигатай тэмцэх газарт тус тус хүргүүлсэн. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан 4 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх холбогдох 17 арга хэмжээний хэрэгжилт 2018 оны эхний хагас жилийн байдлаар 70 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” үнэлгээтэй байна. (Бүрэн хэрэгжсэн – 100%)</p>
<p><b>Арга хэмжээ 7.8.54.</b> Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хүрээнд мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааг зохион байгуулах</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг цахимаар мэдүүлэх боломж нөхцлөөр хангах;</li> <li>- Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг гаргуулан холбогдох журмын дагуу “Баталгааны маягт”-аар</li> </ul>	Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангасан байна. Зөрчил доголдол гаргаагүй	ЗХЗХ	<p>1. Тайлант хугацаанд, мэдүүлгийн бүрдүүлэлтийн 2017 оны мэдээ тайланг нэгтгэн 2018 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А-2/557 дугаар албан бичгээр Авлигатай тэмцэх газарт хуулийн хугацаанд хүргүүлсэн. Мэдүүлгийн бүрдүүлэлтийн 2017 оны тайланд ТӨБЗГ, харьяа төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 76 хуулийн этгээдийн тайлан мэдээ нэгтгэгдсэн. Тоон үзүүлэлтийг дурдвал,</p> <ul style="list-style-type: none"> <li>- Албан тушаалд нэр дэвшигчийн 291 ХАСУМ-ийг бүртгэж, АТГ-т</li> </ul>



	<p>хүлээн авах, бүртгэл хөтлөх;</p> <ul style="list-style-type: none"> <li>- Өөрийн байгууллага болон харьяа төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийг хамруулан мэдүүлгийн бүрдүүлэлтийн ажлыг зохион байгуулах, жилдээ;</li> <li>- Мэдүүлгийн бүрдүүлэлтийн 2017 оны тайлан, мэдээ, ЭБАТ-ын тайланг нэгтгэн боловсруулж, III/01-ний дотор АТГ-т хүргүүлэх.</li> </ul>	<p>байна.</p>	<p>хүргүүлэн хянуулсан;</p> <ul style="list-style-type: none"> <li>- хөрөнгө, орлогод орсон их хэмжээний өөрчлөлтийг мэдүүлсэн 66 ХАСХОМ (2016+)-ийг хүлээн авч, баталгаажуулсан;</li> <li>- Шинээр томилогдсон 136 албан хаагч томилогдсоноос хойш 30 хоногийн дотор ХАСХОМ (2016*)-ээ мэдүүлсэн;</li> <li>- Нийт 1195 мэдүүлэг гаргагч ХАСХОМ (2017)-г шинэчлэн мэдүүлсэн;</li> <li>- Ашиг сонирхлын зөрчилтэй эсэх тухай 2987 мэдэгдлийг хүлээн авч бүртгэлд хамруулснаас 3 албан хаагч ашиг сонирхлын зөрчил үүсч байгааг мэдэгдсэн байна. Уг мэдэгдлийн дагуу удирдлагаас хуульд заасан хязгаарлалтыг хэрэгжүүлж ажилласан дүн гарсан.</li> </ul> <p>2. Мэдүүлгийн бүрдүүлэлтийн 2018 оны үйл ажиллагааны явцын мэдээ:</p> <p>2018 онд албан тушаалд нэр дэвшигчдээс гаргасан 201 ХАСУМ-ийг хүлээн авч бүртгэн АТГ-т хүргүүлж хянуулсан. Тэдгээрээс 10 нэр дэвшигч ТӨБЗГ-ын ажлын байрны сул орон тоонд, 14 нэр дэвшигч төрийн өмчит хуулийн этгээдийн захирлаар томилогдохоор, ТӨБЗГ-ын 30, төрийн бусад байгууллагын 99, нийт 129 албан хаагч ТУЗ-д төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүнээр, 48 иргэн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр тус тус нэр дэвшиж, ХАСУМ мэдүүлсэн.</p> <p>Нийт 171 мэдүүлэг гаргагч (ТӨБЗГ - 78, захирал - 93)-ийн ХАСХОМ-ийг дараах төрлөөр хүлээн авч, холбогдох журмын дагуу цаасаар болон цахим системд бүртгэн баталгаажуулсан байна:</p> <ul style="list-style-type: none"> <li>- ХАСХОМ (2017) шинэчлэн гаргасан – 139 (ТӨБЗГ - 65, захирал - 74);</li> <li>- албан тушаалд томилогдож, ХАСХОМ (2017*)-ийг шинээр гаргасан – 25 (ТӨБЗГ - 11, захирал - 14);</li> <li>- хөрөнгө орлогод нь их хэмжээний өөрчлөлт орж, ХАСХОМ (2017+)-ийг мэдүүлсэн – 7 (ТӨБЗГ - 2, захирал - 5).</li> </ul> <p>2018 онд үнэлгээний хороо, ажлын хэсгийн бүрэлдэхүүнээр томилогдон ажиллах, төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, захиргааны акт гаргах үедээ ашиг сонирхлын зөрчилтэй эсэх тухай нийт 698 мэдэгдэл, тайлбар гаргасныг бүртгэв. Тэдгээрээс 11 тохиолдолд ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай, 687 нь ашиг сонирхлын зөрчилгүй гэж мэдэгджээ. Ашиг сонирхлын зөрчилтэй эсэх тухай 698 мэдэгдлээс</p>
--	---	---------------	--

				<p>620-ыг худалдан авах ажиллагааны үнэлгээний хороонд ажиллахдаа, 54-ийг хяналт шалгалт хийхэд, 24-ийг нь захиргааны шийдвэр гаргахдаа тус тус мэдэгдсэн байна.</p> <p>Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар шаардлагатай үед хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллах, ашиг сонирхлын зөрчилтэй эсэх тухай мэдэгдэл, тайлбар гаргах талаар чиглэл, зөвлөмж боловсруулан 2018 оны А-1/2869 дугаар албан бичгээр харьяа төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад хүргүүлсэн.(Бүрэн хэрэгжсэн – 100%)</p>
<p><b>Арга хэмжээ 7.9.55.</b> Дээд шатны байгууллагаас батлан гаргасан холбогдох бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж, тайлагнан мэдээлэх</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Тогтоол, шийдвэрийн хяналтад авсан заалтын судалгааг нарийвчлан гаргах;</li> <li>- Шинээр ирсэн шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулалтаар хангах;</li> <li>- Хэлтсүүдээс холбогдох шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнах;</li> <li>- Газрын хэмжээний тайланг нэгтгэн боловсруулж, Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх;</li> <li>- Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан журмыг хэрэгжүүлж, тогтоосон хугацаа, хуваарийн дагуу дээд шатны байгууллагад тайлагнах, хагас, бүтэн жилд;</li> <li>- Цахим систем, дотоод сүлжээгээр олон нийт, албан хаагчдад нэгдсэн дүнг мэдээлэх, тухай бүр.</li> </ul>	<p>Байгууллагын үйл ажиллагаанд хамааралтай холбогдох бодлого, шийдвэрийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл дээд шатны байгууллагад тогтоосон хугацаанд хүргэгдсэн байна. Олон нийтэд мэдээлэгдсэн байна.</p>	<p>ЗХЗХ, бусад хэлтэс, алба</p>	<p>Тайлант хугацаанд, ТӨБЗГ-ын хяналтад авч хэрэгжүүлсэн бодлогын баримт бичиг, дээд шатны байгууллагаас гаргасан тогтоол шийдвэрийн 2017 оны болон 2018 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн тайланг холбогдох журмын дагуу нэгтгэн боловсруулж, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан гарган дүнг Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. 2017 оны болон 2018 оны эхний хагас жилийн тайланг ХШҮ-ний тайлан, ТӨБЗГ-ын Даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлийн хамт 2018 оны А-1/267, А-1/259, А-1/453, А-1/2403, А-1/2480, А-1/2481 тоот албан бичгээр ЗГХЭГ, СЯ-нд тус тус хүргүүлсэн. Тайлан бүрийг төрийн мэдээллийн сүлжээ <a href="http://new.unelgee.gov.mn">http://new.unelgee.gov.mn</a> цахим системд заалт бүрээр оруулж, Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамруулав.</p> <p>1.Бодлогын баримт бичиг, тогтоол шийдвэрийн 2017 оны хэрэгжилтийн дүн:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2017 оны зорилтот түвшингийн хэрэгжилт 88.8 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” үнэлгээтэй;</li> <li>- Монгол Улсын эдийн засаг нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт 85.0 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” үнэлгээтэй;</li> <li>- Дээд шатны байгууллагын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт дунджаар 86.1 хувь буюу “Хэрэгжих шатанд” үнэлгээтэй байна.</li> </ul> <p>2.Бодлогын баримт бичиг, тогтоол шийдвэрийн 2018 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн дүн:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2018 оны зорилтот түвшингийн хэрэгжилт 78.8 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн”</li> </ul>

				<p>үнэлгээтэй;</p> <ul style="list-style-type: none"> <li>- Монгол Улсын эдийн засаг нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт 85.0 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” үнэлгээтэй;</li> <li>- Дээд шатны байгууллагын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт дунджаар 84.14 хувь буюу “Хэрэгжих шатанд” үнэлгээтэй байна.</li> </ul> <p>Тайлан тус бүрийг хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, Даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлээр өгсөн үүргийн хамтаар байгууллагын дотоод сүлжээ <a href="http://www.able.mn">www.able.mn</a>, газрын цахим хуудас <a href="http://www.pcsp.gov.mn">www.pcsp.gov.mn</a> -д байршуулж, нийт албан хаагчид болон олон нийтэд нээлттэй мэдээлсэн.</p> <p>2018 оны жилийн эцсийн тайлан мэдээг гаргахад бэлтгэж, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, холбогдох журамд заасан хугацаа, хуваарийн дагуу дүнг ЗГХЭГ, холбогдох байгууллагад хүргүүлэхээр бэлтгэж байна. (Бүрэн хэрэгжсэн – 100%)</p>
<p><b>Арга хэмжээ 7.10.56.</b> Хууль, шүүхийн байгууллагад үүссэн хэрэг, маргаанд нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцох, тайлбар мэдүүлэг, нотлох баримт гаргаж өгөх</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Тухайн хэрэг, маргаантай холбоотой асуудлаар холбогдох байгууллага, албан хаагчтай хамтран ажиллах;</li> <li>- Хуулийн хүрээнд хэрэг, маргааныг шийдвэрлүүлсэн байх;</li> <li>- Шийдвэрлэлтийн байдлын талаар Даргын зөвлөл, газрын хуралдаанд танилцуулах;</li> <li>- Жилдээ.</li> </ul>	Хэрэг, маргааны шийдвэрлэлт ахисан байна.	3Х3Х	<p>Тайлант хугацаанд, шүүхэд худалдан авах ажиллагаатай холбоотой 9, өмчтэй холбоотой 24, нийт 33 хэрэг, маргаан хянагдаж байгаагаас захиргааны 18, иргэний 14, арбитрын 1 хэрэг байна.</p> <p>Дээрх 33 хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тайлбар мэдүүлэг, нотлох баримт гаргаж оролцсон. Тайлант хугацаанд нэхэмжлэлээ татан авсан 2, нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосон 13, нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн 1, нийт 16 хэрэг эцэслэн шийдвэрлэгдсэн.</p> <p>Одоогоор арбитр 1, анхан шатны шүүхэд 10, давж заалдах шатны шүүхэд 4, дээд шүүхэд 2, нийт 17 хэрэг шүүхэд хянагдаж байна. ТӨБЗГ нь хянагдаж байгаа нийт 15 хэргийн 2-т нэхэмжлэгчээр, 14-т хариуцагчаар, 1-д гуравдагч этгээдээр тус тус оролцож байна.</p> <p>(Бүрэн хэрэгжсэн -100%)</p>
<p><b>Арга хэмжээ 7.11.57.</b> Албан бичиг, эрх зүйн болон захиргааны акт, хурлаар хэлэлцүүлэх асуудлын төслийн хууль, эрх зүйн үндэслэлийг хянах</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Төслийг хянаж, хуульд нийцүүлэх арга хэмжээ авах;</li> <li>- Хянасан бичиг, эрх зүйн актын бүртгэл хөтлөх;</li> <li>- Өдөр тутам.</li> </ul>	Хуульд нийцсэн албан бичиг, эрх зүйн акт албажиж, хууль тогтоомж зөрчигдөхөөс урьдчилан сэргийлсэн байна.	3Х3Х	<p>ТӨБЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэх 656 асуудлын төсөл, 585 тогтоол, 25 тэмдэглэл, газрын даргын 411 тушаал, 3951 албан бичиг, тендерийн баримт бичиг, урилга, мэдэгдэл, тайлан зэрэг баримт материалын төслийн хууль зүйн үндэслэлийг хянаж, хуульд нийцүүлэн боловсруулах, албажуулахад дэмжлэг үзүүлсэн.</p> <p>(Бүрэн хэрэгжсэн – 100%)</p>

<p><b>Арга хэмжээ 7.12.58.</b> Газрын албан хаагчдын нийгмийн баталгаа, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Хөтөлбөрийг 2018 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах, батлах, I сард;</li> <li>- Төлөвлөгөөнд “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хөдөлмөрийн дотоод журам”, бусад эрх зүйн актад тусгагдсан нийгмийн хамгааллын асуудлыг тусгах;</li> <li>- Төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах, жилдээ.</li> </ul>	<p>Газрын албан хаагчдын чадавх дээшилж, нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэсэн байна.</p>	<p>3X3X</p>	<p>1. “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчийн сургалтын хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд газрын 2018 оны сургалтын төлөвлөгөөг холбогдох хэлтэс, албаны саналыг тусган боловсруулж, газрын даргын 2018 оны А/38 дугаар тушаалаар баталсан. Тус тушаалын 1 дүгээр хавсралтаар ТӨБЗГ-ын албан хаагчдын, 2 дугаар хавсралтаар төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага, ажилтны, 3 дугаар хавсралтаар Орон нутгийн өмчийн газрын албан хаагчдын сургалтын төлөвлөгөөг тус тус батлан, хэрэгжилтийг хангаж ажиллав.</p> <p><u>1.1. ТӨБЗГ-ын албан хаагчдын сургалт:</u> Газрын даргын 2018 оны А/38 дугаар тушаалаар батлагдсан сургалтын төлөвлөгөөний хүрээнд 35, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 01 дүгээр албан даалгавар, 2018 оны “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 258 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, Төрийн албаны тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах зорилгоор 5, ТӨБЗГ-ын албан хаагчдыг соён гэгээрүүлэх, танин мэдэхүйн шинэ мэдлэг, мэдээлэл олгох сургалтын хүрээнд 4, албан хаагчдад “Хууль тогтоомж, сурталчлах сарын аян”-ны хүрээнд 11, нийт 55 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 1608 албан хаагчийг хамруулсан.</p> <p>Зохион байгуулсан 55 сургалтыг агуулгаар нь ангилвал:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Хууль тогтоомжийн сургалт – 20;</li> <li>- АТГ-ын төлөвлөгөөт сургалт – 23;</li> <li>- Мэргэшүүлэх сургалт – 3;</li> <li>- Соён гэгээрүүлэх, танин мэдэхүйн сургалт - 9.</li> </ul> <p>Түүнчлэн, “КОЙКА” олон улсын байгууллагын 2018 оны сургалтын хөтөлбөрийн хүрээнд БНСУ-д зохион байгуулагдсан “Төрийн өмчийн удирдлагыг чадавхижуулах” сургалтад 2 албан хаагчийг хамруулсан.</p> <p>Засгийн газрын тэтгэлгээр Удирдлагын академийн “Төрийн захиргааны менежмент”-ийн мэргэшүүлэх сургалтад 3 албан хаагчийг, их, дээд сургуульд сурч байгаа 4 албан хаагчийг мэргэжил дээшлүүлэх боломж, нөхцлөөр хангаж, суралцах хугацаанд нь цалинтай чөлөө олгон дэмжлэг үзүүлэв.</p>
---	---	---	-------------	---

				<p>1.2.Харьяа төрийн өмчит хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтны сургалт: Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн захирал, тэргүүн дэд захирал, ерөнхий инженер, тамгын газрын дарга, хуулийн мэргэжилтэн, нууцын асуудал хариуцсан ажилтан, санхүүгийн асуудал хариуцсан нэгжийн дарга, ерөнхий нягтлан бодогч, төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдэд зориулсан нийт 4 удаагийн зорилтот сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 100 хуулийн этгээдийн 454 эрх бүхий албан тушаалтныг хамруулсан.</p> <p>1.3.Орон нутгийн өмчийн газрын албан хаагчдын сургалт: Хууль, эрх зүй, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийн дахин үнэлгээ сэдвийн хүрээнд 3 удаа сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 228 албан хаагчийг хамруулсан.</p> <p>2.“Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн хүрээнд 10 албан хаагчид 116.0 сая төгрөгийн орон сууцны дэмжлэг, 8 албан хаагчид 1.3 сая төгрөгийн тусламж, 3 албан хаагчид 0.9 сая төгрөгийн тэтгэмж олгосон. 2018 оны үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээний биелэлтийг хагас, бүтэн жилээр 2 удаа дүгнэн албан хаагчдыг үр дүнгээр урамшуулан ажиллалаа.</p> <p>2018 оны 05 дугаар сарын 29-30-ны өдрүүдэд 10 албан хаагчийг “Эрдэнэт үйлдвэр” ХХК-тай хамтран эрүүл мэндийн үзлэгт хамруулсан. Мөн нийт албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамааруулах тухай хүсэлтийг Эрүүл мэндийн яаманд хүргүүлж, Улсын II эмнэлгийн үзлэгт хамруулахаар шийдвэрлүүлсэн.</p> <p>Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 97 жилийн ой, Шинэ жилийн баяраар ТӨБЗГ-т үр бүтээлтэй ажиллаж, эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан 1 албан хаагчийг “Алтан гадас” одонгоор, 6 албан хаагчийг ТӨБЗГ-ын “Жуух бичиг”-ээр, 4 албан хаагчийг “Салбарын тэргүүн”, 2 албан хаагчийг салбарын “Хүндэт жуух” бичгээр, 7 албан хаагчийг Залуучуудын холбооны шагнал, 5 албан хаагчийг ТӨБЗГ-ын “Тусгай мөнгөн шагнал”-аар тус тус шагнасан.</p> <p>(Бүрэн хэрэгжсэн – 100%)</p>
<p><b>Арга хэмжээ 7.13.59.</b> Гадаад хамтын</p>	<p>- Санал боловсруулан, хэрэгжүүлэх арга хэмжээ</p>	<p>Гадаад хамтын ажиллагаа</p>	<p>ЗХЗХ</p>	<p>ОХУ-ын Төрийн өмчийн менежментийн агентлаг, БНХАУ-ын Төрийн өмчийн хяналт, удирдлагын зөвлөл, БНСУ-ын олон улсын хамтын</p>

<p>ажиллагааг өргөжүүлэх талаар санал боловсруулж, хэрэгжүүлэх арга хэмжээ авах</p>	<p>авах; - Олон улсын байгууллага, холбогдох бусад байгууллагатай хамтарч ажиллах; - I улиралд.</p>	<p>өргөжин, ижил төстэй байгууллагын туршлагыг нэвтрүүлсэн байна.</p>		<p>ажиллагааны агентлаг, БНСингапур улсын “Темасек Холдинг” төрийн өмчит корпораци зэрэг гадаадын ижил төстэй байгууллагатай хамтран ажиллах, гадаад харилцааг өргөжүүлэх зорилгоор санал боловсруулан, хүсэлтийг Гадаад харилцааны яаманд хүргүүлсэн. БНЭУ-д суугаа Монгол Улсын Элчин сайдын яаманд болон тус улсын Чиннай хот дахь Монгол Улсын Өргөмжит консул С.Н.Гангадаранд хамтран ажиллах санал хүргүүлсэн.</p> <p>БНСУ-ын “КОЙКА” хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр 4 албан хаагчийг БНСУ-д туршлага судлах чиглэлээр олон улсын үзэсгэлэн, арга хэмжээнд оролцуулж, Capacity Building for Efficient Management, Disposal and Development of State Properties сургалтад 2 албан хаагчийг хамруулсан. (Хэрэгжих шатанд – 70%)</p>
<p><b>Арга хэмжээ 7.14.60.</b> Орон нутгийн нэгжийн өмчийн харилцааны болон худалдан авах ажиллагааны мэргэжилтнүүдэд нэгдсэн сургалт, семинар зохион байгуулж, мэргэжил, арга зүйгээр хангах</p>	<p>- Сургалт, семинарын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан, батлах; - 21 аймгийн Орон нутгийн өмчийн газар, Нийслэлийн Өмчийн харилцааны газар, Худалдан авах ажиллагааны газар, 9 дүүргийн худалдан авах ажиллагааны албаны хаагчдыг хамруулах; - Мэдээ тайлан хүлээж авах; - Гарын авлагаар хангах; - I улиралд.</p>	<p>Орон нутгийн нэгжийн чадавх бэхжиж, албан хаагчдын мэдлэг, мэргэшил дээшилсэн байна. Мэдээ тайлангийн чанар сайжирсан байна.</p>	<p>ЗХЗХ, БТУХ, ТӨБХХ, ХААХ, МТА</p>	<p>Орон нутгийн нэгжийн холбогдох албан хаагчдад зориулсан 2 удаагийн сургалт, семинарыг ТӨБЗГ-т батлагдсан хөтөлбөрийн дагуу зохион байгуулж, нийт 228 албан хаагчийг хамруулан мэргэжил, арга зүйгээр хангав:</p> <p>1.2018 оны 01 дүгээр сарын 18-19-ний өдөр зохион байгуулсан сургалтад Нийслэлийн Өмчийн харилцааны газрын 15, 17 аймгийн Орон нутгийн өмчийн газрын 26, нийт 41 албан хаагч хамрагдсан.</p> <p>2.2018 оны 03 дугаар сарын 12-16-ны өдрүүдэд зохион байгуулсан сургалт-семинарт Нийслэлийн өмчийн харилцааны газрын 7, 21 аймгийн Орон нутгийн өмчийн газрын 76, нийт 83 албан хаагчийг хамруулж, мэргэжил, арга зүйн мэдээлэл, зөвлөгөөгөөр хангав. Энэ үеэр Нийслэлийн өмчийн харилцааны газар, аймгуудын Орон нутгийн өмчийн газартай орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайлангийн тулган баталгаажуулалтыг хийсэн. Сургалтад хамрагдагсдыг нийслэлийн Өмчийн харилцааны газрын үйл ажиллагаатай танилцуулж, туршлага судлах уулзалтыг зохион байгуулав.</p> <p>3.2018 оны 09 дүгээр сарын 06-08-ны өдрүүдэд нийслэл, 21 аймгийн Засаг даргын захирамжаар байгуулсан ерөнхий ажлын хэсгийн гишүүд, Орон нутгийн өмчийн газар болон Нийслэлийн өмчийн харилцааны газрын нийт 100 гаруй албан хаагчдыг хамруулж, “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний ажлыг зохион байгуулах сургалт”-ыг “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн байранд зохион байгуулсан.</p>

				ТӨБЗГ-ын даргын тушаалаар батлагдсан ажлын хэсэг Орон нутгийн өмчийн газрын үйл ажиллагааг шалган зааварчлах, төрийн болон орон нутгийн өмчит зарим компанийн үйл ажиллагаатай танилцах, мэргэжил, аргагүйн туслалцаа үзүүлэх, төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний бэлтгэл хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор нийт 15 аймаг буюу Архангай, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Завхан, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл аймагт ажиллав. Энэ үеэр төрийн болон орон нутгийн өмчит 31 компанийн үйл ажиллагаатай танилцаж, арга зүйгээр хангав. (Бүрэн хэрэгжсэн – 100%)
<b>ХӨТӨЛБӨР ҮИИ</b>				
<b>“Хүний нөөцийн чадавхийг сайжруулж, хэлтэс, албан хаагчдын гүйцэтгэл, үр дүнг дээшлүүлэх, сахилга, хариуцлагыг өндөржүүлэх” хөтөлбөрийн хүрээнд:</b>				
<b>Арга хэмжээ 8.1.61.</b> Хэлтэс, албан хаагчдын үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангуулан, тайлагнан мэдээлэх	<ul style="list-style-type: none"> <li>- “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хөдөлмөрийн дотоод журам”-д заасны дагуу хэлтсийн ажлыг улирал, жилээр, албан хаагч сараар төлөвлөн батлуулж, хэрэгжилтийг хангах;</li> <li>- Газрын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөтэй уялдуулах;</li> <li>- Хэлтсийн ажлын гүйцэтгэл, үр дүнг холбогдох сар бүр тайлагнан мэдээлэх;</li> <li>- Байгууллагын цахим хуудас, дотоод сүлжээгээр дамжуулан ажлаа сурталчлан мэдээлэх, тухай бүр.</li> </ul>	Хэлтэс, албан хаагчийн үйл ажиллагааны тайлагналт, үр дүн сайжирч, мэдээллийн ил тод байдал хангагдана.	ЗХЗХ, бусад хэлтэс, алба	<p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Ерөнхий сайдаар батлуулсан бөгөөд 4 стратегийн зорилтыг хэрэгжүүлэх 10 хөтөлбөрийн хүрээнд 84 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.</p> <p>Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд хэлтэс, албан хаагчдад төлөвлөгөөг хүргэн сурталчилж, үйл ажиллагаагаа уялдуулах зохион байгуулалтын арга хэмжээ авсан. Байгууллагын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан хэлтэс, албан хаагчид жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, үр дүнгийн гэрээг нарийвчлан боловсруулж, батлуулав. Хэлтэс бүр төлөвлөгөөний биелэлтийг хангах арга хэмжээ аван хагас, бүтэн жилийн ажлаа тайлагнаж, албан хаагчдын үр дүнгийн гэрээг эхний 2 удаа дүгнэв.</p> <p>ТӨБЗГ-ын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилт 86.3 хувийн гүйцэтгэлтэй, нийт 84 заалтаас 47 заалт “Бүрэн хэрэгжсэн” буюу 100%, 29 заалт “Хэрэгжих шатанд” буюу 70%, 3 заалт “Хэрэгжилт хангалтгүй” буюу 30%-ийн үнэлгээтэй байсан бол “Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй” 5 заалт байв.</p> <p>Хэлтэс бүрийн сарын ажлын тайланд үндэслэн ТӨБЗГ-ын сар бүрийн ажлын тайланг нэгтгэн боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэхийн зэрэгцээ, төрийн мэдээллийн цахим сүлжээнд заалт бүрээр оруулан Засгийн газрын хяналтад бүртгүүлж байна. (Бүрэн хэрэгжсэн – 100%)</p>
<b>Арга хэмжээ 8.2.62.</b>	- Төрийн албаны	Албан	ЗХЗХ,	2018 оны үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээг хэлтэс, албаны

<p>Нийт албан хаагчидтай 2018 оны үр дүнгийн гэрээ, хөдөлмөрийн гэрээ байгуулж, гүйцэтгэл, үр дүнг дүгнэх</p>	<p>зөвлөлийн 2004 оны 34 дүгээр тогтоолоор батлагдсан заавар, 2012 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан журмыг баримтлан үр дүнгийн гэрээг боловсруулах;</p> <ul style="list-style-type: none"> <li>- Ажлын байрны тодорхойлолтыг үндэслэн албан хаагчидтай Үр дүнгийн гэрээ, хөдөлмөрийн гэрээ байгуулах;</li> <li>- Шууд удирдах нэгжийн дарга тухайн албан хаагчийн үр дүнгийн гэрээг батлах, I сард;</li> <li>- Албан хаагчдын үр дүнгийн гэрээг дүгнэх ажлыг зохион байгуулах, YI, XII сард;</li> <li>- Үр дүнгийн гэрээг дүгнэж, түүний мөрөөр авах арга хэмжээг тодорхойлон хэрэгжүүлэх.</li> </ul>	<p>хаагчдын хариуцлагын тогтолцоо сайжирч, гүйцэтгэлийн үр дүнг хянах боломжтой болно. Байгууллагын стратегийн зорилт хангагдана.</p>	<p>бусад хэлтэс, алба</p>	<p>дарга нар албан хаагчидтай хуульд заасан хугацаанд байгуулах арга хэмжээг авч ажилласан. Тайлант онд давхардсан тоогоор 85 албан хаагчтай үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээ байгуулсан байна. ТӨБЗГ-ын албан хаагчдын гэрээг хагас, бүтэн жилээр дүгнэсэн. 2018 оны эхний хагас жилд 73 албан хаагчийн үр дүнгийн гэрээ, хөдөлмөрийн гэрээний биелэлтийг дүгнэхээс 67 албан хаагчийн гэрээний биелэлтийн явцыг дүгнэж, үнэлгээ өгсөн. Үнэлгээний дүн:</p> <ul style="list-style-type: none"> <li>- А буюу маш сайн – 39 (58.0%)</li> <li>- В буюу сайн – 22 (33.%)</li> <li>- С буюу хангалттай – 5 (8.0%)</li> <li>- D буюу дутагдалтай – 1 (1%)</li> <li>- F буюу хангалтгүй – 0 (0%)</li> </ul> <p>Дүгнэх боломжгүй (захиргааны чөлөөтэй байсан, шинээр томилогдсон г.м. – 6 албан хаагч байна.</p> <p>2018 оны үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээний жилийн эцсийн биелэлтийг 74 албан хаагч дүгнүүлэхээс 72 албан хаагч дүгнүүлсэн. Үнэлгээний дүн:</p> <ul style="list-style-type: none"> <li>- А буюу маш сайн – 64 (88.9%)</li> <li>- В буюу сайн – 7 (9.7%)</li> <li>- С буюу хангалттай – 1 (1.4%)</li> <li>- D буюу дутагдалтай – 0 (0%)</li> <li>- F буюу хангалтгүй – 0 (0%)</li> </ul> <p>Дүгнэх боломжгүй (захиргааны чөлөөтэй байсан) - 2 байна. (Бүрэн хэрэгжсэн – 100%)</p>
<p><b>Арга хэмжээ 8.3.63.</b> Монгол Улсын Засгийн газрын 2017 оны “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 01 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэх арга хэмжээ авах</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулах, батлах;</li> <li>- Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, тайлагнах, мэдээлэх;</li> <li>- Зөрчил, дутагдал гаргасан албан хаагчид холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцох;</li> <li>- Холбогдох байгууллага,</li> </ul>	<p>Албан хаагчдын ажлын хариуцлага нэмэгдсэн байна.</p>	<p>ЗХЗХ, Бүх хэлтэс, алба</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын 2017 оны “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангах ажлын төлөвлөгөөг 8 заалттайгаар батлан хэрэгжилтийг 100 % хангасан. Тус төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд ТӨБЗГ-ын албан хаагчдыг соён гэгээрүүлэх, шинэ мэдлэг, мэдээлэл олгох сургалтыг 32 удаа зохион байгуулж, иргэд, олон нийтээс ирсэн 224 өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж, ажлын байрны давхардлын судалгааг хийж, албан хаагчдын цаг ашиглалтыг сайржуулан, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, тайланг сар бүр гарган ЗГХЭГ-т хүргүүлэн ажилласан.</p> <p>2018 оны “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах</p>



	<p>албан тушаалтанд мэдээлэх; - Жилдээ.</p>			<p>тухай” 258 дугаар тогтоолын хэрэгжилт хангах, Төрийн албаны тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах зорилгоор 2018 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн газрын даргын А/240 дугаар тушаалаар Төрийн албаны тухай хууль (шинэчилсэн найруулга) болон төрийн албаны сахилга хариуцлагын талаар өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан, 14 ажил бүхий төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэв. Энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд 6 удаагийн сургалт зохион байгуулж, Төрийн албаны тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн асуудлаар 40 асуулт бүхий, 3 хувилбарт сорилын шалгалт авч, байгууллагын чиг үүргийн шинжилгээ, албан хаагчдын ажлын байрны ачаалал, чиг үүргийн давхардал, хийдлийг арилгах судалгаа хийв. Мөн төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 258 дугаар тогтоолын хэрэгжилт ханган ажиллах үүргийг 2018 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн А-2/3440 дугаар албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>2018 онд ажлын байрны тодорхойлолт, үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн, ажлын цаг ашиглалт сул дүгнэгдсэн 2 албан хаагчид Төрийн албаны тухай хууль болон “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хөдөлмөрийн дотоод журам”-ын дагуу сануулах сахилгын шийтгэл ногдуулж, 1 албан хаагчийн асуудлыг ТӨБЗГ-ын “Ёс зүйн хороо”-оор хэлэлцэн, сануулга өгч, бусад албан хаагчдад зөвлөмж хүргүүлсэн.</p> <p>Авлигын эсрэг хууль тогтоомжид заасан хориглолт, хязгаарлалтыг зөрчиж, албан үүрэг гүйцэтгэхдээ ашиг сонирхлын зөрчил гаргасан нь АТГ-ын дүгнэлтээр тогтоогдсон харьяа төрийн өмчит хуулийн этгээдийн 3 албан тушаалтанд хариуцлага тооцуулах арга хэмжээ авсан. (Бүрэн хэрэгжсэн -100%)</p>
<p><b>Арга хэмжээ 8.4.64.</b> Нийт албан хаагчийг соён гэгээрүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулж, байгууллагын соёлыг тогтоох, хэвшүүлэх арга хэмжээ авах</p>	<p>- Ёс зүй, харилцааны болон байгууллагын соёлтой холбоотой сэдэв, агуулгатай байх; - Мэргэжлийн сургалтын байгууллага, лекторуудтай хамтрах; - Сургалтын товыг гаргаж, нийт албан хаагчдыг</p>	<p>Байгууллагын соёл төлөвшинө. Албан хаагчдын чадавх дээшилнэ.</p>	<p>ЗХЗХ</p>	<p>Газрын даргын 2018 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/38 дугаар тушаалаар батлагдсан “2018 оны сургалтын төлөвлөгөө”-ний хүрээнд 4, ТӨБЗГ-ын албан хаагчдыг соён гэгээрүүлэх, шинэ мэдлэг, мэдээлэл олгох сургалт 5, АТГ-ын төлөвлөгөөт сургалтын хүрээнд 23, нийт 32 удаагийн сургалт зохион байгуулж албан хаагчдыг хамруулсан. Сургалтыг сэдвээр нь ангилан харуулбал:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Төрийн албан хаагчийн ёс зүй - 23;</li> <li>- Эрүүл амьдралын хэв маяг - 3;</li> </ul>

	<ul style="list-style-type: none"> <li>хамруулах;</li> <li>- Зохион байгуулалтад хэлтэс бүрийн оролцоог хангах;</li> <li>- Сар бүр.</li> </ul>			<p>- Танин мэдэхүйн - 6. (Бүрэн хэрэгжсэн -100%)</p>
<p><b>Арга хэмжээ 8.5.65.</b> Байгууллагын албан хаагчдад эрх зүйн туслалцаа үзүүлж, зөвлөгөө, мэдээллээр хангах</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Шаардлагатай үед хууль, эрх зүйн туслалцаа үзүүлэх;</li> <li>- Ажилтнуудад шинээр батлагдсан хууль тогтоомжийн талаар мэдээлэл өгөх;</li> <li>- Дагаж мөрдөх дүрэм, журмыг танилцуулж, тайлбарлах;</li> <li>- Тухай бүр.</li> </ul>	Албан хаагчид хариуцсан ажлын чиглэлээр хууль, эрх зүйн зөрчилгүй ажилласан байна.	ЗХЗХ	<p>ТӨБЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэх 632 асуудлын төсөл, 585 тогтоол, 25 тэмдэглэл, 411 тушаал, 3951 (ТӨБХХ, МТА-аас явсан бичиг ороогүй) албан бичиг, тендерийн баримт бичиг, урилга, мэдэгдэл, тайлан зэрэг баримт материалын төслийн хууль зүйн үндэслэлийг хянаж, хуульд нийцүүлэн албажуулахад дэмжлэг үзүүлсэн. Мөн газрын албан хаагчдаас хууль зүйн туслалцаа хүссэн тухай бүр асуудлыг судалж, зохих зөвлөгөө өгч, хууль, эрх зүйн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>ТӨБЗГ-ын албан хаагчдын дунд “Хууль тогтоомж сурталчлах сарын аян”-ыг 2018 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 01-ний өдрийн хооронд удирдамж, төлөвлөгөөний дагуу зохион байгуулав. Аяны хүрээнд төрийн албан хаагчийн эрх зүйн байдал, төрийн өмчийн бүртгэл, хяналт, төрийн өмчийн удирдлага, менежмент, төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын үйл ажиллагаанд дагаж мөрдөж буй хууль тогтоомжийн хүрээнд 9 удаагийн сургалт, сэдэв бүрийн хүрээнд “АХА” тэмцээн, шилдэг оролцогчдын дунд “Жаран мянган уналт” хөгжөөнт тэмцээн уралдааныг тус тус зохион байгуулав.</p> <p>(Бүрэн хэрэгжсэн -100%)</p>
<p><b>ХӨТӨЛБӨР IX</b> <b>“Мэдээллийн технологийн ололтыг байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх замаар менежментийг сайжруулж, байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах” хөтөлбөрийн хүрээнд:</b></p>				
<p><b>Арга хэмжээ 9.1.66.</b> “Цахим тендер шалгаруулалт”-ын системийн хэвийн үйл ажиллагааг хангаж, цахим худалдан авах ажиллагааны нэгдсэн системийн удирдлагыг хэрэгжүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Худалдан авах ажиллагааны төлөвлөлтийн дагуу урилгыг олон нийтэд мэдээлэх;</li> <li>- Системийн ашиглалтын талаарх мэдээлэл, зөвлөмжөөр хэрэглэгчийг хангах;</li> <li>- Жилдээ.</li> </ul>	Тендер шалгаруулалтын үйл ажиллагаа ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, хариуцлагатай болсон байна.	МТА	<p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <a href="https://tender.gov.mn">https://tender.gov.mn</a> –ийн хэвийн ажиллагааг ханган ажиллав. Улсын хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой тус цахим системийн зарим тоон үзүүлэлтийг дурдвал (2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар):</p> <ul style="list-style-type: none"> <li>– захиалагч 1433 байгууллагын хэрэгжүүлэх 21417 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөө бүртгэгдэж, олон нийтэд мэдээлэгдсэн;</li> <li>– нийт 10817 тендерийн урилга зарлагдсанаас 9574 нь “Цахим тендер шалгаруулалт”-ын урилга байгаа бөгөөд нийт урилгын</li> </ul>

				<p>88.5 хувийг эзэлж байна;</p> <ul style="list-style-type: none"> <li>- тус системээр дамжин нийт 10202 үр дүн олон нийтэд мэдээлэгдсэн байна. Үүнээс нээлтийн 1955, тендер шалгаруулалтын 8021, хянан үзсэн болон явцын 226 үр дүнг тус тус мэдээлсэн;</li> <li>- цахим системд худалдан авах ажиллагааны 1511 гэрээ бүртгэгдсэн;</li> <li>- бараа, ажил, үйлчилгээний ангиллын системд нийт 23857 бараа, ажил, үйлчилгээ бүртгэлтэй байна.</li> </ul> <p>Тус цахим системд хэрхэн мэдээлэл бүртгэх, ажиллах талаарх мэдээлэл, зөвлөмж, зааварчилгыг тендер шалгаруулалтыг зохион байгуулагч, захиалагч байгууллагад тогтмол өгч, систем дэх мэдээллийн баазыг үнэн зөв үүсгэхэд анхаарч ажиллав.</p> <p>(Бүрэн хэрэгжсэн – 100%)</p>
<p><b>Арга хэмжээ 9.2.67.</b> “Цахим дэлгүүр”, “Цахим каталоги”-ийн системийг хэрэглээнд нэвтрүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Цахим каталогийн бараа, ажил, үйлчилгээний тоо, төрлийг нэмэх, ангиллыг боловсронгуй болгох;</li> <li>- Захиалагч, нийлүүлэгч байгууллагуудыг мэргэшил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах;</li> <li>- Нийлүүлэгч байгууллагууд бараа, үйлчилгээгээ цахим дэлгүүрт бүртгүүлж борлуулах;</li> <li>- Жилдээ.</li> </ul>	<p>Төсвийн байгууллагын урсгал зардлаараа худалдан авдаг тодорхой нэр бүхий барааг цахим дэлгүүрээр дамжуулан худалдан авна. Тендерээр худалдан авдаг бараа, ажил, үйлчилгээний мэдээллийн нэгдсэн сан баяжсан.</p>	<p>МТА</p>	<p>“Ерөнхий гэрээ”-ний анхны тендерийг 2017 оны 12 сарын 22-ны өдөр зарлаж, 2018 оны 01 сарын 26-ны өдөр нээлтийг хийсэн, 2 дугаар сард тендерийн үнэлгээ хийгдэж дууссан.</p> <p>Ерөнхий гэрээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах, “Цахим дэлгүүр”-ийн системийг хэрэглээнд нэвтрүүлэх сургалтыг ТӨБЗГ-аас СЯ, ЭМЯ-тай хамтран 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгуулав. Уг сургалтад АХБ-ны “Улсын эмнэлгүүдийн боломжит үнэтэй эмийн хүртээмжийг сайжруулах” техник туслалцааны (8967-МОН) төслийн дэд ажлын хэсгийн гишүүд, ерөнхий гэрээний худалдан авалтыг хэрэгжүүлэх төрөлжсөн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, аймаг, нийслэлийн ЭМГ, Аймгийн нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн нийт 58 ажилтныг хамруулав.</p> <p>2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 361 удаагийн захиалга хийгдэж, 814144 ширхэг эм худалдан борлуулагдсаны дүнд улсын төсвийн урсгал зардалд 325.4 сая төгрөгийн хэмнэлт гаргасан байна. Цаашид “Ерөнхий гэрээ байгуулах журам”-аар худалдан авч болох бараа, бүтээгдэхүүний судалгааг хийж байна.</p> <p>Дотоодын үйлдвэрлэгчдийн бараа, үйлчилгээний каталоги үүсгэх, мэдээллийг “Цахим дэлгүүр”-т нэгтгэх ажлын төлөвлөгөөг гарган хэрэгжүүлж байна. Бараа, ажил, үйлчилгээний ангиллын системд нийт 23857 бараа, ажил, үйлчилгээ бүртгэлтэй байна.</p>

				(Бүрэн хэрэгжсэн – 100%)
<p><b>Арга хэмжээ 9.3.68.</b> “Цахим тайлан”-гийн систем, “Нээлттэй гэрээний олон улсын стандарт”-ыг хэрэгжүүлж, мэдээллийг өгөгдөл хэлбэрт шилжүүлэн нээлттэй түгээх, статистик мэдээллээр хангах боломжийг бүрдүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> <li>- “Цахим тайлан”-ийн системийг Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-д нийцүүлэн кодчилж, программын хөгжүүлэлтийг хийх;</li> <li>- Системийг сурталчлан таниулах, хэрэглэгчдийг мэдээлэл, арга зүйгээр ханган чадавхижуулах арга хэмжээ авах;</li> <li>- Системийн хэрэглээнд дүн шинжилгээ хийж, программын сайжруулалт, хөгжүүлэлтийг тогтмол хийх;</li> <li>- Жилдээ.</li> </ul>	<p>Худалдан авах ажиллагааны тайлан цахим хэлбэрээр гардаг болсон байна. Худалдан авах ажиллагааны талаарх статистик тайлан, мэдээг тухайн өдрийн байдлаар системээс боловсруулан гаргах боломжтой болно.</p>	<p>МТА</p>	<p>Нээлттэй гэрээний олон улсын стандарт (Open Contracting Data Standart)-ыг Монгол улсад нутагшуулах, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийг төхөөрөмж унших боломжтойгоор олон нийтэд нээлттэй мэдээлэх зорилгоор <a href="http://www.opendata.tender.gov.mn">www.opendata.tender.gov.mn</a> системийн хөгжүүлэлтийг хийсэн. Уг цахим хуудасны хэвийн үйл ажиллагааг ханган ажиллахын зэрэгцээ Монгол улсын Нээлттэй өгөгдлийн бэлэн байдлын үнэлгээг хийж буй ажлын хэсэгт худалдан авах ажиллагааны мэдээллийг гарган өгч, дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 363 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2, 3 дугаар хавсралтад заасан тайлагналт, үнэлгээний 8 маягтаар цахим системээс тайлангийн мэдээлэл гаргах бэлтгэл ажлыг хийсэн.</p> <p>(Бүрэн хэрэгжсэн – 100%)</p>
<p><b>Арга хэмжээ 9.4.69.</b> Худалдан авах ажиллагааны “Цахим шалгалт”-ын системийн хэвийн үйл ажиллагааг хангах</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Цахим шалгалтын системийн хэвийн үйл ажиллагааг хангах;</li> <li>- Худалдан авах ажиллагааны суурь мэдлэг эзэмшигчийн гэрчилгээ (АЗ) бүхий иргэдийн цахим мэдээллийн санд баяжилт хийж, ил тод мэдээлэх;</li> <li>- Жилдээ.</li> </ul>	<p>Худалдан авах ажиллагааг зохион байгуулах Үнэлгээний хорооны гишүүдийн чадавх сайжирна.</p>	<p>МТА</p>	<p>“Цахим шалгалт”-ын системийн хэвийн ажиллагааг хангаж, үйл ажиллагааг сайжруулахын тулд нэмэлт тест хийн шийдвэрлэх шаардлагатай асуудлын жагсаалтыг гаргасан.</p> <p>2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар тус цахим системээр нийт 411 удаагийн шалгалт зохион байгуулагдан худалдан авах ажиллагааны суурь мэдлэг олгох сургалтад хамрагдсан 7144 албан хаагч, иргэн шалгалт өгсөнөөс 4161 нь тэнцсэн статистик мэдээ гарч байна. 2018 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд худалдан авах ажиллагааны суурь мэдлэг эзэмшигчийн гэрчилгээ бүхий нийт 12970 иргэн төрийн худалдан авах ажиллагааны цахим системд бүртгэлтэй байна.</p> <p>Цахим системийн хувьд тендер зарлагдахаас өмнө худалдан авах ажиллагааны суурь мэдлэг эзэмшигч (АЗ гэрчилгээтэй)-ийн бүртгэл бүхий иргэд, албан хаагчдаас Үнэлгээний хороог байгуулсан байх ба нарийн бичгийн дарга нь тендерийн нээлтийг хийж, үнэлгээ хийх боломж бүрдсэн. Уг системд гэрчилгээ бүхий зарим хүмүүсийн мэдээлэл бүрэн бус, алдаатай, засвар оруулах шаардлага гарч</p>

<p><b>Арга хэмжээ 9.5.70.</b> “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-ийн хэвийн үйл ажиллагааг хангах</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Системийг хэвийн ажиллуулах техник хангамж, зохион байгуулалтын арга хэмжээ авах;</li> <li>- Системд мэдээлэл, өгөгдөл оруулах, системийн ашиглалтын талаар хэрэглэгчдийг мэдээлэл, зөвлөгөө, арга зүйгээр хангах;</li> <li>- Системийг шинэчлэн боловсронгуй болгох асуудлаар төсөл бичиж, зардлын санхүүжилтийг шийдвэрлүүлэх;</li> <li>- Жилдээ.</li> </ul>	<p>Төрийн өмчид бүртгэлээр тавих хяналт боловсронгуй болсон байна. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгийн бүртгэлийг цахим системд оруулах боломж сайжирсан байна.</p>	<p>байгааг тухай бүр шийдвэрлэн ажиллав. (Бүрэн хэрэгжсэн – 100%)</p> <p>“Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлжүүлэх систем”-ийн хэвийн үйл ажиллагааг хангахын тулд 21 аймгийн Орон нутгийн өмчийн газраас тус системд гарч буй нийтлэг алдааны мэдээлэл, системийг сайжруулах талаар санал авах ажлыг зохион байгуулав. Саналыг үндэслэн системийг хөгжүүлэгч байгууллага болох “G Communication” компанитай хамтран системд гарч байгаа нийтлэг алдааг засан, системийн гацалтыг багасгаж, хурдыг нэмэгдүүлэн хэвийн үйл ажиллагааг хангав.</p> <p>“Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлжүүлэх систем”-ийг компьютерт суулгах болон систем дээр ажиллах арга зүйн гарын авлагыг бэлтгэж, ТӨБЗГ-ын цахим хуудас <a href="http://www.pcsp.gov.mn">www.pcsp.gov.mn</a> -д байршуулав.</p> <p>“Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлжүүлэх систем”-ийн хэвийн үйл ажиллагааг хангах болон хэрэглэгчдэд зөвлөгөө өгөх ажлыг өдөр тутмын үйл ажиллагаагаар хэрэгжүүлж байна. Нийт 1020 байгууллагыг зөвлөгөө, тусламжаар хангаж ажилласан.</p> <p>“Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлжүүлэх систем”-ийн ашиглалт, түүнтэй холбоотой асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар Орон нутгийн өмчийн газрын албан хаагчдад нэгдсэн сургалтын үеэр 2 удаа семинар, арга зүйн мэдээлэл, зааварчилга өгсөн. Мөн МУИС, ШУТИС-ийн хүсэлтээр холбогдох мэргэжилтнүүдэд, Өмнөговь, Өвөрхангай, Баянхонгор аймгийн ОНӨГ-ын хүсэлтээр тус аймгуудын төрийн өмчит байгууллагуудын нягтлан бодогч нарт тус тус системийн сургалтыг газар дээр нь зохион байгуулж, чадавхижуулав.</p> <p>Уг системийн хөгжүүлэлтийн төлөвлөгөө, ажлын даалгавар, зардлын тооцоо судалгааг хийсний үндсэн дээр системийг шинэчлэн боловсронгуй болгох асуудлаар төсөл боловсруулж, санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр ТӨБЗГ-ын 2018 оны А-1/21 тоот албан бичгийг Сангийн яаманд хүргүүлсэн.</p> <p>(Бүрэн хэрэгжсэн – 100%)</p>
--	---	---	--

<p><b>Арга хэмжээ 9.6.71.</b> Цахим хэлбэрээр дуудлага худалдаа зохион байгуулах дэд системийг нэвтрүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> <li>- “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-ийн дэд систем болгон хөгжүүлэлт хийх;</li> <li>- Хэрэглэгчдэд мэдээлэл, арга зүйн зөвлөгөө өгөх;</li> <li>- Дэд системээр дуудлага худалдааг зохион байгуулах;</li> <li>- Жилдээ.</li> </ul>	<p>Цахим дуудлага худалдааны дэд системээр дамжуулан төрийн өмчийн дуудлага худалдааг нээлттэй, ил тод зохион байгуулах нөхцөл бүрдэнэ.</p>	<p>МТА</p>	<p>Цахим хэлбэрээр дуудлага худалдаа зохион байгуулах зорилго бүхий мэдээллийн системийг хөгжүүлэн төвийн сервер дээр тохиргоог хийж, 202.70.44.151 хаяг дээр байршуулсан.</p> <p>(Бүрэн хэрэгжсэн – 100%)</p>
<p><b>Арга хэмжээ 9.7.72.</b> Төрийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгийн бүртгэлийг “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх талаар арга зүйн удирдлага, зөвлөмж, мэдээллээр хангах</p>	<ul style="list-style-type: none"> <li>- “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-ийн ерөнхий заавар, аргачлал, гарын авлага бүхий мэдээллийг бэлтгэх, түгээх;</li> <li>- Системийн ашиглалтыг сайжруулахад чиглэсэн ойлголт, мэдээллийг өгөх арга зүйн сургалт зохион байгуулах;</li> <li>- Арга зүйн зөвлөгөө дэмжлэгийг байнга үзүүлэх;</li> <li>- Жилдээ.</li> </ul>	<p>“Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-ийн хэрэглэгчдийн ойлголт, мэдлэг нэмэгдэж, системийн ашиглалт сайжирна.</p>	<p>МТА</p>	<p>“Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-ийг компьютерт суулгах болон систем дээр ажиллах зааварчилга бүхий гарын авлагыг бэлдэж, ТӨБЗГ-ын цахим хуудас <a href="http://www.pcsp.gov.mn">www.pcsp.gov.mn</a> -д байршуулав.</p> <p>“Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д мэдээллийн бааз үүсгэх чиглэлээр мэдээлэл, арга зүйгээр хангах 2 удаагийн сургалтыг 2018 оны 01 дүгээр сарын 18-19-ний өдөр болон 3 дугаар сарын 12-18-ны өдрүүдэд ТӨБЗГ-т зохион байгуулж, Нийслэлийн өмчийн харилцааны газар, 21 аймгийн Орон нутгийн өмчийн газрын давхардсан тоогоор 124 (41+83) албан хаагчийг хамруулсан.</p> <p>Архангай, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Завхан, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл (15) аймагт ажлын хэсэг зөвлөн туслах ажлаар ажиллах үеэр уг системийн ашиглалтын талаар мэдээлэл, зөвлөмж өгсөн. Өмнөговь, Өвөрхангай, Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын хүсэлтээр цахим системийн сургалтыг орон нутагт тусгайлан зохион байгуулав. Мөн МУИС, ШУТИС-ийн харьяа сургуулийн нягтлан бодогч нарыг хамруулсан сургалтыг зохион байгуулж, уг системийн талаар мэдээлэл, арга зүйгээр хангав.</p> <p>“Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-ийн хэвийн үйл ажиллагааг хангах болон хэрэглэгчдэд зөвлөгөө өгөх ажлыг өдөр тутмын үйл ажиллагаагаар хэрэгжүүлж, нийт 1020 байгууллагыг зөвлөгөө, дэмжлэгээр хангаж ажилласан.</p> <p>(Бүрэн хэрэгжсэн – 100%)</p>
<p><b>Арга хэмжээ 9.8.73.</b> Төрийн худалдан авах ажиллагааг зохион</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Төрийн худалдан авах ажиллагааны цахим системийн ерөнхий</li> </ul>	<p>Цахим худалдан авалтын</p>	<p>МТА</p>	<p>Тайлант хугацаанд, захиалагч 122 байгууллагын 2607 албан хаагчийг 72 удаагийн сургалтаар чадавхижуулсан. Үүнд:</p> <p>Төрийн худалдан авах ажиллагааг зохион байгуулагч, захиалагч</p>

<p>байгуулж байгаа байгууллага, болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн цахим хэлбэрээр зохион байгуулах худалдан авах ажиллагааг арга зүйн удирдлага, зөвлөгөө, дэмжлэгээр хангах</p>	<p>заавар, аргачлал, гарын авлага бүхий мэдээллийг бэлтгэх, түгээх; - Сургалт, арга зүйн ажлын төлөвлөгөө, хуваарь батлан хэрэгжүүлэх; - Жилдээ.</p>	<p>талаар мэдээлэл олон нийтэд хүрч, ойлголт, мэдлэг нэмэгдэж, системийн ашиглалт сайжирна.</p>	<p>байгууллагын төлөөллийг чадавхижуулах зорилгоор 7 хоног бүрийн Мягмар гаригт цахим худалдан авах ажиллагаа, цахим системийн сургалтыг ТӨБЗГ-т зохион байгуулав. Энэхүү танхимын 20 удаагийн сургалтад нийт 110 байгууллагын 888 төлөөллийг хамруулсан. 2018 оны 03 дугаар сарын 12-18-ны өдөр ТӨБЗГ-т зохион байгуулсан орон нутгийн худалдан авах ажиллагааны нэгжийн албан хаагчдын сургалтын үеэр цахим худалдан авах ажиллагааны системийн талаарх мэдээлэл, зөвлөгөөг өгч, арга зүйгээр хангав.</p> <p>Худалдан авах ажиллагааны захиалагч болон зохион байгуулагч байгууллагын хүсэлтээр цахим худалдан авах ажиллагааны системийн сургалтыг тухайн байгууллага, орон нутагт очиж зохион байгуулсан бөгөөд нийт 12 байгууллага, 3 аймагт ажиллаж, 52 удаагийн сургалтаар 1719 албан хаагчийн чадавхийг дээшлүүлсэн:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын 150 албан хаагч;</li> <li>2. Авлигатай тэмцэх газартай хамтарсан тусгай хөтөлбөрөөр 14 удаагийн сургалтыг зохион байгуулж, захиалагч байгууллагын 944 албан хаагчийг чадавхижуулсан;</li> <li>3. Сангийн яамнаас зохион байгуулсан яам, агентлаг болон нийслэл, дүүргийн төрийн байгууллагын дотоод аудитын мэргэжилтний сургалтад хамрагдагсад;</li> <li>4. Эрчим хүчний яам, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Прокурорын Ерөнхий газрын худалдан авах ажиллагааны зохион байгуулалтад дэмжлэг үзүүлж, газар дээр нь арга зүйгээр ханган ажилласан;</li> <li>5. МУИС-ийн 22 оюутан, 39 албан хаагч;</li> <li>6. “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК болон “Дулааны цахилгаан станц -3” ТӨХК-ийн нийт 60 албан хаагч, “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн 30, “Багануур” ХК-ийн 22 албан хаагч;</li> <li>7. Архангай аймгийн ОНӨГ-ын зохион байгуулсан сургалтад хамрагдсан захиалагч байгууллагын 24, Увс аймгийн ОНӨГ-ын зохион байгуулсан сургалтад хамрагдагч захиалагч байгууллагын 64 албан хаагч, Өмнөговь аймгийн ОНӨГ-ын зохион байгуулсан сургалт;</li> <li>8. Батлан хамгаалах яамны харьяа 25 байгууллагын 50 албан хаагч.</li> </ol> <p>Түүнчлэн, Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион</p>
---	--	---	---

				байгуулах талаар заавар, зөвлөмжийг өдөр тутамд хүргэхийн зэрэгцээ төрийн өмчит 90 хуулийн этгээдийн 190 төлөөллийг худалдан авах ажиллагааны цахим системийн сургалтаар чадавхижуулсан байна. (Бүрэн хэрэгжсэн – 100%)
<b>Арга хэмжээ 9.9.74.</b> Худалдан авах ажиллагаанд оролцогч ААН-ийн төлөөлөлд зориулсан цахим системийн сургалт, арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> <li>- Төрийн худалдан авах ажиллагааны цахим системийн ерөнхий заавар, аргачлал, гарын авлага бүхий мэдээллийг бэлтгэх, түгээх;</li> <li>- Сургалт, арга зүйн ажлын төлөвлөгөө, хуваарь батлан хэрэгжүүлэх;</li> <li>- 7 хоног бүр.</li> </ul>	Худалдан авах ажиллагаанд оролцогч ААН-ийн цахим системийн ашиглалтын чадавх нэмэгдэнэ.	МТА	Худалдан авах ажиллагаанд оролцогч аж ахуйн нэгжүүдэд зориулсан цахим системийн сургалтыг 7 хоног бүрийн Пүрэв гаригт 10.00 цагаас зохион байгуулж байна. Тайлант хугацаанд нийт 17 удаагийн сургалт зохион байгуулж, түүнд 207 суралцагч хамрагдсан байна. Мөн өдөр тутмын үйл ажиллагааны хүрээнд цахим худалдан авах ажиллагаатай холбоотой мэдлэг, мэдээлэл, тусламж, зөвлөгөөг нийт 30 нийлүүлэгч байгууллагад утсаар, цахим шуудангаар, онлайн туслах цэсээр болон уулзалтаар тус тус хүргэсэн. (Бүрэн хэрэгжсэн – 100%)
<b>ХӨТӨЛБӨР Х</b>				
<b>“Байгууллагын дотоод зохион байгуулалтыг сайжруулж, өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах” хөтөлбөрийн хүрээнд:</b>				
<b>Арга хэмжээ 10.1.75.</b> Газрын хуралдаан, Даргын зөвлөлийн хурал, бусад хурлыг зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> <li>- Хуралдаан, хурлын бэлтгэл, зохион байгуулалтыг хангаж, хурлын зар, хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээллийг холбогдох хүмүүст хүргэх;</li> <li>- Газрын хуралдаан болон бусад хуралдаанд оруулах асуудал, шийдвэрийн төслийг хянах, албажуулах;</li> <li>- Хурлын тэмдэглэл хөтөлж, албажуулах;</li> <li>- Мэдээллийн ил тод байдлыг хангах;</li> <li>- Газрын тогтоол, хуралдаанаас гарсан шийдвэрийн биелэлт, үр дүнг газрын Даргын зөвлөл, газрын Хуралдаанд танилцуулах;</li> <li>- Жилдээ.</li> </ul>	Газрын хуралдаан, Даргын зөвлөлийн хурал, бусад хурлын зохион байгуулалт шаардлагын түвшинд хүрсэн байна.	ЗХЗХ	<p><u>ТӨБЗГ-ын хуралдааны тухай:</u></p> <p>2018 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар, ТӨБЗГ-ын ээлжит хуралдааныг танхимд 17, санал авах хуудсаар 16, нийт 33 удаа хуралдааны дэгийн дагуу зохион байгуулан төрийн өмчийн талаарх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, удирдлага, зохицуулалтаар ханган ажиллав. Хуралдаанаар 656 асуудал хэлэлцүүлсний дүнд 585 тогтоол, 25 тэмдэглэл албажуулж, хэрэгжилтийг зохион байгуулав.</p> <p>ТӨБЗГ-ын 2018 оны 585 тогтоолыг агуулгаар нь ангилвал:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Эрх зүйн акт 5;</li> <li>2. Хуулийн этгээдийн дүрэм, зохион байгуулалтын бүтэц батлах 18;</li> <li>3. Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин 97;</li> <li>4. Хуулийн этгээдийн удирдлагыг томилох, чөлөөлөх 12;</li> <li>5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг томилох, чөлөөлөх 25;</li> <li>6. Хуулийн этгээдийн бусад асуудлаар 13;</li> <li>7. Өмч, хувьчлал 7;</li> <li>8. Хөрөнгийн шилжилт хөдөлгөөн 374;</li> <li>9. Хяналт шалгалт 21.</li> </ol> <p>Мэдээллийн ил тод байдлыг хангаж, олон нийтэд мэдээлэх зорилгоор албажсан тогтоол, тэмдэглэлийг газрын цахим хуудас <a href="http://www.pcsp.gov.mn">www.pcsp.gov.mn</a> -д төрөлжүүлэн байршуулж, эд хөрөнгө актлах, устгах, дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох</p>



			<p>чиглэлээр гарсан 2018 оны 190 тогтоол, тэмдэглэл, 2017 оны 23 удаагийн хуралдаанаар шийдвэрлэгдсэн энэ төрлийн 215 тогтоолыг тус тус шилэн дансны цахим систем <a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a>-д байршуулсан.</p> <p>Газрын даргаас өгсөн үүргийн дагуу “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдааны дэг”-ийг баримтлан ажиллах тухай санамж боловсруулж, дэд дарга, хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн нарт танилцуулан гарын үсэг зуруулсан бөгөөд дотоод сүлжээний <a href="http://www.able.mn">www.able.mn</a> цахим системээр дамжуулан нийт албан хаагчид танилцуулав.</p> <p>2017 онд ТӨБЗГ-ын 28 удаагийн хуралдаанаас гарсан 684 тогтоол, 24 тэмдэглэлийн биелэлтийг нэгтгэн, дүнг Газрын хуралдаанд танилцуулсан. 2017 оны газрын тогтоолын хэрэгжилт 95.3 хувь, тэмдэглэлийн хэрэгжилт 66.2 хувийн гүйцэтгэлтэй байв. Тэдгээрээс 448 (65%) тогтоол, 14 (42%) тэмдэглэлийг хяналтаас хасч, 236 (35%) тогтоол, 14 (58%) тэмдэглэлийг хяналтад хэвээр үлдээсэн.</p> <p>Газрын хуралдааны шийдвэрийн 2018 оны жилийн эцсийн хэрэгжилтийн дүнг 2019 оны 01 дүгээр сард гаргахаар бэлтгэж байна.</p> <p><u>ТӨБЗГ-ын Даргын зөвлөлийн хурлын тухай:</u></p> <p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Даргын зөвлөлийн хурлыг 2018 оны эхний хагас жилд 3 удаа хуралдуулж, дараах асуудлыг тус тус хэлэлцүүлсэн:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. 2018 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаар Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2017 оны хэрэгжилтийн тайлангийн тухай, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тайлангийн тухай;</li> <li>2. 2018 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2017 оны хэрэгжилтийн тайлангийн тухай;</li> <li>3. 2018 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2018 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн тайлангийн тухай, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн эхний хагас жилийн хэрэгжилтийн тайлангийн тухай, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн 2018 оны</li> </ol>
--	--	--	---

				<p>эхний хагас жилийн хэрэгжилтийн тайлангийн тухай.</p> <p>Бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар Даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлээр өгсөн үүрэг чиглэлийг хэлтэс, албан хаагчдад тухай бүр дотоод сүлжээгээр дамжуулан хүргэж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>Тайлант хугацаанд, нийт албан хаагчийн хурлыг 5 удаа зохион байгуулж, ажил эрчимжүүлэх талаар удирдлагаас чиглэл өгч, ажиллав. (Бүрэн хэрэгжсэн – 100%)</p>
<p><b>Арга хэмжээ 10.2.76.</b> Газрын тогтоол, хуралдаанаас гарсан шийдвэр, түүний биелэлтийн цахим мэдээллийн сан бий болгох</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Программ хангамж боловсруулах, хөгжүүлэх;</li> <li>- Албан хаагчдад танилцуулах, сургалт зохион байгуулах;</li> <li>- Хэрэглээнд нэвтрүүлэх;</li> <li>- I улиралд.</li> </ul>	<p>Газрын хуралдааны шийдвэр, түүний биелэлтийн мэдээлэл боловсронгуй болсон байна.</p>	<p>ЗХЗХ, МТА</p>	<p>Газрын тогтоол, хуралдаанаас гарсан шийдвэр, түүний биелэлтийн цахим мэдээллийн сан бий болгох зорилгоор программ хангамжийг боловсруулан хөгжүүлж, удирдлага, албан хаагчдад танилцуулсан бөгөөд хэрэглээнд нэвтрүүлж эхлэв. (Бүрэн хэрэгжсэн – 100%)</p>
<p><b>Арга хэмжээ 10.3.77.</b> Нэг цэгийн үйлчилгээний үйл ажиллагааны хэвийн байдлыг хангаж ажиллах</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Газрын чиг үүрэгтэй холбоотой мэдээ, мэдээлэл, зөвлөгөө дэмжлэгийг иргэн, аж ахуйн нэгжид шуурхай хүргэх;</li> <li>- Нэг цэгийн үйлчилгээний мэдээлэлд дүн шинжилгээ хийж, холбогдох хэлтэс, албан тушаалтанд мэдээлэх;</li> <li>- Сар бүр.</li> </ul>	<p>Иргэд, аж ахуйн нэгжид чирэгдэлгүй, шуурхай үйлчлсэн байна.</p>	<p>ЗХЗХ</p>	<p>Тайлант хугацаанд, ТӨБЗГ-ын “Нэг цэгийн үйлчилгээ”-ээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад давхардсан тоогоор нийт 23312 үйлчилгээг үзүүлсэн байна:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Зөвлөгөө өгсөн - 15299 (утсаар 8663, биечилж 6636);</li> <li>- Тендертэй холбоотой мэдэгдэл, тодруулга, саналын урилга хүргэсэн 1203;</li> <li>- Цахим гарын үсгийн Е-Токен төхөөрөмж олгосон – 55;</li> <li>- АЗ сертификат олгосон – 2269;</li> <li>- Онлайн асуултад хариулсан – 603;</li> <li>- <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> цахим системд бүртгэн, баталгаажуулсан гүйцэтгэгч, нийлүүлэгч аж ахуйн нэгж - 3883 байна.</li> </ul> <p>Газрын цахим хуудас <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>-д нийтлэг асуулт, хариултын булан (online chat) нээж аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд хүргэх мэдээллийн шуурхай хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлсэн. (Бүрэн хэрэгжсэн – 100%)</p>
<p><b>Арга хэмжээ 10.4.78.</b> Газрын үйл ажиллагааг хэвлэл, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд мэдээлэх, сурталчлах</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Хэвлэл, мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах,</li> <li>- Газрын үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл бэлтгэх, фото зураг авах,</li> </ul>	<p>Газрын үйл ажиллагааны талаарх мэдээлэл иргэд, олон нийтэд</p>	<p>ЗХЗХ</p>	<p>Тайлант хугацаанд, Монгол Улсын Засгийн газрын шийдвэр, үйл ажиллагаа болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үйл ажиллагааны талаар 110 мэдээ, мэдээлэл, 16 дуудлагын худалдаа болон сонгон шалгаруулалт, зөвлөх үйлчилгээний зарыг байгууллагын цахим хуудас, олон нийтийн цахим сүлжээнд</p>

	<p>архивлах,</p> <ul style="list-style-type: none"> <li>- Олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд нийтлэх,</li> <li>- Газрын цахим хуудас, нүүр номын хуудсанд байршуулах,</li> <li>- Хэвлэлийн хурал улирал бүр хийх,</li> <li>- Жилдээ</li> </ul>	<p>шуурхай хүрсэн байна.</p>		<p>байршуулан нийтийн хүрээл болгов.</p> <p>Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр 111 мэдээ мэдээллийг бэлтгэн цахим хуудсаар 160, телевизээр 180, өдөр тутмын сониноор 31, радиогоор 5 удаа олон нийтэд хүргэж, 23 тодруулга ярилцлага, 7 нэвтрүүлэгт холбогдох албан хаагчийг оролцуулсан.</p> <p>Мөн “Төрийн өмчийн менежмент ба нийгмийн хариуцлага - 2018” өдөрлөгийн реклам сурталчилгааг бэлтгэж, телевиз болон <a href="http://www.youtube.com">www.youtube.com</a> сувгаар олон нийтэд хүргэсэн.</p> <p>Байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хангах ажлыг зохион байгуулах хүрээнд байгууллагын цахим хуудас <a href="http://www.pfsp.gov.mn">www.pfsp.gov.mn</a> –т мониторинг хийж, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Засгийн газрын 2013 оны 411 дүгээр тогтоолоор батлагдсан “Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам”, Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2017 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн байгууллагын цахим хуудаст тавих шаардлага MNS 6285:2017” стандартыг хангаж байгаа эсэхэд үнэлгээ өгч, сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэв.</p> <p>ТӨБЗГ-ын болон “Нэг цэгийн үйлчилгээ”, Худалдан авах ажиллагааны хэлтсийн мэдээллийн самбарыг тус тус ажиллуулж, албан хаагчид болон олон нийтэд шаардлагатай мэдээ мэдээллийг дамжуулах сувгийн тоог нэмэгдүүлэн үйл ажиллагааны нээлттэй байдлыг хангав. (Бүрэн хэрэгжсэн – 100%)</p>
<p><b>Арга хэмжээ 10.5.79.</b> Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалт (ХХНЖ), байгууллагын архивын зааврыг батлан, мөрдүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Баримт бичиг нягтлан шалгах комиссын хурлаар хэлэлцүүлэх;</li> <li>- Батлах, мөрдүүлэх;</li> <li>- 2017 оны архивын материалыг албан хаагчдаас хүлээн авч, заавар, журмын дагуу архивын хадгаламжийн нэгж үүсгэх;</li> <li>- Татан буугдсан байгууллага (ХААГ)-ын архивыг Архивын ерөнхий газарт хүлээлгэж</li> </ul>	<p>Газрын үйл ажиллагаанд өдөр тутам үүсч хөтлөгдөж буй баримт бичгийг ангилан бүлэглэх, хадгалах хугацаа нь оновчтой тодорхой болсон байна.</p>	<p>ЗХЗХ</p>	<p>Баримт бичиг нягтлан шалгах комиссын 2018 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн хурлаар дараах баримт бичгийг хэлэлцэн баталсан:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Баримт бичиг нягтлан шалгах комиссын дүрмийг 4 бүлэг 15 зүйлтэйгээр;</li> <li>2. Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг байнга хадгалах 28, түр хадгалах 25, 70 жил хадгалах 2, нийт 55 хэрэг хөтлөгдөхөөр.</li> </ol> <p>Тус хурлаар баримт бичгийн хадгалах хугацаанд өөрчлөлт оруулж, төрийн өмчийн эд хөрөнгийн тооллогын баримтыг байнга хадгалах дансанд бүртгэхээр, ирсэн бичгийн хариу өгөх хяналтын хугацаанд өөрчлөлт оруулж бусад байгууллагаас хамааралтай болон хөрөнгийн хөдөлгөөний шийдвэрлэлттэй холбоотой албан бичгийн хугацааг байгууллагын дотоод сүлжээ <a href="http://www.able.mn">www.able.mn</a> -д 30 хоногоор</p>

	<p>өгөх; - I улиралд.</p>			<p>бүртгэхээр шийдвэрлэсэн.</p> <p>Мөн онцгой байдлын үед архивын баримтыг нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөг боловсруулан 2018 оны 6 дугаар сарын 19-ний өдөр Захиргаа хууль, зүйн хэлтсийн дарга баталж, хэрэгжилтийг хангав.</p> <p>Тайлант хугацаанд,</p> <ul style="list-style-type: none"> <li>- ирсэн, явсан бичгийн 32, тендерийн 77, санхүүгийн 18, ТӨБЗГ-ын тогтоолын 17, нууц баримтын 28, ТӨБХХ-ийн чиг үүрэгт хамаарах 52, нийт 224 хадгамжийн нэгжийг архивт хүлээн авсан;</li> <li>- 168 иргэн, байгууллагад архивын лавлагаа гарган өгсөн;</li> <li>- 85 хадгаламжийн нэгжийг албан хаагчдад түр ашиглуулж, Үндэсний төв архивын газраас 8 хадгаламжийн нэгж авч Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн.</li> </ul> <p>(Бүрэн хэрэгжсэн – 100%)</p>
<p><b>Арга хэмжээ 10.6.80.</b> Байгууллагын албан хэрэг хөтлөлтийг заавар журмын дагуу зохион байгуулж, хариутай бичгийн шийдвэрлэлтэд бүртгэлээр хяналт тавьж, байгууллага болон “Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах төв”-д иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг судлан шийдвэрлэх</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд <a href="https://www.able.mn">https://www.able.mn</a> дотоод сүлжээгээр дамжуулан хяналт тавих;</li> <li>- Хугацаатай албан бичиг, иргэдийн өргөдөл, гомдлыг хугацаанд нь шийдвэрлэх арга хэмжээг зохион байгуулах, тухай бүр;</li> <li>- Шийдвэрлэгдээгүй албан бичиг, өргөдөл, гомдлыг удирдлагад танилцуулах;</li> <li>- Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээг нэгтгэж, цахим хуудсаар олон нийтэд мэдээлэх;</li> <li>- Өргөдөл, гомдлын тайлан, мэдээг Даргын зөвлөлд танилцуулах;</li> <li>- “Засгийн газрын иргэд,</li> </ul>	<p>Байгууллагын албан хэрэг хөтлөлт бичиг хэргийн стандартад нийцсэн байна. Холбогдох хууль тогтоомж, заавар, журмын хэрэгжилт хангагдсан байна.</p>	<p>ЗХЗХ</p>	<p>Тайлант хугацаанд, тус байгууллагад 6972 (газрын удирдлага-8, ЗХЗХ-891, БТУХ-1986, ТӨБХХ-2579, ХААХ-822, МТА-686) албан бичиг ирснийг дотоод сүлжээний систем <a href="http://www.able.mn">www.able.mn</a> -д бүртгэж, удирдлагын заалтын дагуу хариуцсан албан хаагчид шилжүүлэн шийдвэрлэлтэд хяналт тавьж байна. Нийт 6972 албан бичгээс хариутай 4288 албан бичиг ирснээс 3846 нь шийдвэрлэгдэж, 198 нь хяналтад, 244 албан бичиг шийдвэрлэгдээгүй хүлээгдэж байна. Хариутай бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавьж, шийдвэрлэх хугацааны сануулгыг албан хаагчдад өгч ажиллав.</p> <p>ТӨБЗГ-аас 4733 албан бичгийг албажуулж, бусад байгууллагад хүргүүлсэн. ТӨБЗГ-ын даргын 411 тушаал гарснаас байгууллагын үндсэн үйл ажиллагааны чиглэлээр 290, хүний нөөцтэй холбоотой 121 тушаал албажсан.</p> <p>ТӨБЗГ-т 2018 онд иргэдийн 240 өргөдөл, гомдлыг бүртгэн хүлээн авснаас шийдвэрлэсэн 224, хяналтад байгаа буюу хүлээгдэж байгаа 5, хугацаа хэтэрсэн, шийдвэрлэгдээгүй 11 өргөдөл, гомдол байгаа дүнтэй байна.</p> <p>Засгийн газрын "Иргэд, олон нийттэй харилцах төв"-өөр дамжуулан 2018 онд нийт 20 санал, хүсэлт, гомдол ирүүлснийг бүртгэлд хамруулан шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллав. Тэдгээрээс орон нутагт зохион байгуулагдаж буй худалдан авах ажиллагаатай холбоотой 9, худалдан авах ажиллагааны системтэй холбоотой 3, худалдан авах ажиллагааны талаар сургалт явуулах тухай 1, төрийн</p>

	<p>олон нийттэй харилцах төв"-д ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг уг төвд эргэж мэдээлэх;</p> <ul style="list-style-type: none"> <li>- Улиралд.</li> </ul>			<p>өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаатай холбоотой 1, газрын албан хаагчтай холбоотой 2, газар эзэмших эрхтэй холбоотой 1, өмчтэй холбоотой 2, лавлагаатай холбоотой 1 санал, хүсэлт, гомдол байна. Иргэдээс ирүүлсэн санал, хүсэлт, гомдлыг удирдлагын заалтын дагуу холбогдох албан хаагчдад шилжүүлэн, шийдвэрлэлтэд нь бүртгэлээр хяналт тавин ажиллав. Засгийн газрын "Иргэд, олон нийттэй харилцах төв"-өөр дамжин ирсэн санал, хүсэлт гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэн хариу өгсөн.</p> <p>(Бүрэн хэрэгжсэн – 100%)</p>
<p><b>Арга хэмжээ 10.7.81.</b> Байгууллагын нягтлан бодох бүртгэлийг хууль тогтоомж, стандартад нийцүүлэн хөтөлж, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Санхүүгийн анхан шатны баримтын бүрдлийг хангах;</li> <li>- Албан хаагчдын цалинг цагийн бүртгэлд тулгуурлан тооцож олгох;</li> <li>- Үндсэн хөрөнгийн тооллогыг хагас, бүтэн жилд хийж, үр дүнг тайлагнах;</li> <li>- Санхүүгийн тайланг улирал, хагас, бүтэн жилээр гарган аудитын байгууллагаар баталгаажуулж, холбогдох байгууллагад хүргүүлэх;</li> <li>- Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг боловсруулах, батлах;</li> <li>- Шилэн дансны хууль тогтоомжийн дагуу төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын мэдээллийг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулж, ил тод мэдээлэх;</li> <li>- Хуульд заасан хугацаанд.</li> </ul>	<p>Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа хууль тогтоомж, дүрэм, заавар, стандартын дагуу хөтлөгдсөн байна. Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангасан байна.</p>	<p>ЗХЗХ</p>	<p>Байгууллагын нягтлан бодох бүртгэлийг хууль тогтоомж, стандартад нийцүүлэн хөтөлж байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбар, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, хөрөнгө оруулалтын мэдээлэл, өмч хөрөнгө захиран зарцуулах тогтоолыг Шилэн дансны хууль тогтоомжийн дагуу <a href="http://shilendans.gov.mn">http://shilendans.gov.mn</a> цахим системд сар бүрийн 08-ны өдрийн дотор байршуулан, санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангасан. Мөн байгууллагын мэдээллийн самбарт сар бүрийн 5-ны өдрийн дотор төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг шинэчлэн байршуулж, олон нийтэд мэдээлж байна. (Бүрэн хэрэгжсэн – 100%)</p>
<p><b>Арга хэмжээ 10.8.82.</b> Байгууллагын 2018 оны төсвийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлж, нийгмийн даатгал, төсвийн гүйцэтгэлийн тайлан, мэдээг гаргаж, холбогдох байгууллагад</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Холбогдох тайланг Нийгмийн даатгалын байгууллага, Ерөнхий сайдын Ажлын албанд сар бүр хүргүүлэх;</li> <li>- Албан хаагчдын НДД, ЭМД-т сар бүр бичилт хийж, баталгаажуулах;</li> </ul>	<p>Холбогдох хууль, журмын дагуу стандартад нийцсэн тайлан, тэнцлийг гаргасан байна.</p>	<p>ЗХЗХ</p>	<p>ТӨБЗГ-ын 2018 оны үйл ажиллагааны зардалд нийт 1,945.8 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 12 дугаар сарын 14-ний өдрийн байдлаар 1.882.7 тэрбум төгрөгийн санхүүжилт гарсан. 2018 оны төсвийн гүйцэтгэл 96.8%-тай, 63.2 сая төгрөгийн хэмнэлттэй байна.</p> <p>Төсвийн зардлын санхүүжилт:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Цалин хөлс болон НДШ-д - 883.1 сая төгрөг;</li> <li>- Урсгал зардалд – 3.9 сая төгрөг;</li> </ul>

<p>хүргүүлэх. 2019 оны төсвийн төсөөллийг Сангийн яаманд хянуулах</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Төсвийн төсөөлөлтэй холбоотой баримт материалыг бэлтгэх;</li> <li>- 2019 оны төсвийн төслийг тооцоо, судалгаанд үндэслэн боловсруулж, Сангийн яам, Ерөнхий сайдын ажлын албанд хүргүүлэх, III-ҮI сард.</li> </ul>	<p>2018 оны батлагдсан төсвийг үр ашигтай зарцуулж, төсвийн хэтрэлтгүй, өр, авлагагүй дүн гарсан байна. 2019 оны төсвийн төлөвлөлт хийгдэж, хянагдсан байна.</p>		<ul style="list-style-type: none"> <li>- Хангамж, материалын зардалд – 103.0 сая төгрөг;</li> <li>- Томилолтын зардалд – 232.3 сая төгрөг;</li> <li>- Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд – 428.6 сая төгрөг;</li> <li>- Бараа, үйлчилгээний бусад зардалд – 224.9 сая төгрөг;</li> <li>- Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулалд 6.8 сая төгрөг.</li> </ul> <p>Сар бүрийн 10, 25 -ны өдрүүдэд цагийн бүртгэлийг үндэслэн цалинг бодож, цалин хөлс болон нийгмийн даатгалын шимтгэлд 883.1 сая төгрөгийн гүйлгээ хийсэн.</p> <p>Газрын даргын А-181 дүгээр тушаалаар 7, А-286 дугаар тушаалаар 6 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй үндсэн хөрөнгийн тооллогын комиссыг байгуулж, байгууллагын эд хөрөнгийг 2 удаа тоолсон.</p> <p>2018 оны 01 дүгээр сарын 01-ны өдрийн байдлаар 22,253.5 сая төгрөгийн үнийн дүнтэй 1483 үндсэн хөрөнгө бүртгэлтэй байсан бол 2018 онд 674.6 төгрөгийн үнийн дүнтэй 6 автомашин, 1 тээврийн хэрэгсэл, 1 тавилга, аж ахуйн хэрэгсэл балансаас балансад шилжин ирсэн, 15,031.7 сая төгрөгийн 5 барилга байгууламж, 3 автомашиныг бусад байгууллагад балансаас балансад шилжүүлсэн, 104.4 сая төгрөгийн үнийн дүнтэй 156 тавилга, аж ахуйн хэрэгслийг акталж, данснаас хассан. Үүний дүнд, 2018 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар, 1328 ширхэг 7,791.9 сая төгрөгийн үнийн дүнтэй эд хөрөнгө ТӨБЗГ-ын балансад бүртгэлтэй байна.</p> <p>2017 оны жилийн эцэс, 2018 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг хууль, журмын дагуу цаг хугацаанд нь төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэн, тайланг хамгаалж баталгаажуулсан.</p> <p>Төсвийн тухай хуулийн 8.3.4 дүгээр зүйлд зааснаар 2019 оны төсвийн хүрээний мэдэгдлийн саналыг 1.7 тэрбум төгрөгөөр тооцож, төсвийн ерөнхийлөн захирагчид 2018 оны 07 дугаар сарын 05-ны өдөр хүргүүлсэн бөгөөд энэ нь Сангийн яаманд 1.4 тэрбум төгрөгөөр хянагдаж, Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулиар 1.5 тэрбум төгрөгөөр батлагдсан. (Бүрэн хэрэгжсэн -100%)</p>
<p><b>Арга хэмжээ 10.9.83.</b> Байгууллагын үйл ажиллагааны хэвийн байдлыг хангахад шаардлагатай бараа, материалыг татан авч,</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Хууль, журмын дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэгчтэй гэрээ байгуулах;</li> <li>- Гэрээний дагуу бичиг хэргийн хэрэгсэл,</li> </ul>	<p>Байгууллагын хэвийн үйл ажиллагаа хангагдана.</p>	<p>ЗХЗХ</p>	<p>Байгууллагын үйл ажиллагааны хэвийн байдлыг хангахад шаардлагатай албан хэрэгцээний бараа, материалын хангалтыг хийж, анхан шатны баримтын бүрдлийг ханган, удирдлагын хяналт, зөвшөөрлийн дагуу албан хаагчдад олгосон. 2018 онд бараа, материал, шатахууны зардалд 2017 оны үлдэгдэл 7,592.5 сая төгрөг, 2018 онд 66,449.4 сая төгрөг, нийт 74,041.9 сая төгрөгийг</p>

хуваарилах	материалыг захиалан авч, албан хаагчид олгох; - Төсөв, тооцоог нягтлан бодогчоор хянуулан хэлтсийн даргад сар бүр танилцуулах; - Жилдээ.			зарцуулсан. 2018 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар бараа, материалын үлдэгдэлгүй байна. (Бүрэн хэрэгжсэн -100%)
<b>Арга хэмжээ 10.10.84.</b> Олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах	- Олон нийтийн ажил зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах; - Ажлын төлөвлөгөө боловсруулах, батлах; - Төлөвлөгөөний дагуу олон талт ажлыг зохион байгуулах; - Жилдээ.	Албан хаагчдын дунд эвсэг, найрсаг, хамтач уур амьсгал бүрдсэн байна.	ЗХЗХ, Олон нийтийн ажил зохион байгуулах комисс	Байгууллагын олон нийтийн ажлыг зохион байгуулах үүрэг бүхий комиссыг ТӨБЗГ-ын даргын 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн А/47 дугаар тушаалаар шинэчлэн байгуулсан. Олон нийтийн ажлын чиглэлээр 2018 онд 14 ажил, арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөж, газрын даргын тушаалаар батлан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулав.  Олон нийтийн ажлын төлөвлөгөөний дагуу 2018 онд дор дурдсан ажлыг зохион байгуулсан байна:  Цагаан сарын баярыг тохиолдуулан ахмад настныг хүлээн авч хүндэтгэл үзүүлэх; - 02 дугаар сарын 19-ний өдөр албан хаагчдын золголт; - 03 дугаар сарын 03-ны өдөр “Цасны баяр”; - 03 дугаар сарын 07-ны өдөр “Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр”; - 03 дугаар сарын 18-ны өдөр “Монгол цэргийн өдөр”; - 05 дугаар сарын 30-ны өдөр “Хүүхдийн баяр”-ын арга хэмжээ; - 07 дугаар сарын 09-ний өдөр Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 97 жилийн ойн баярын арга хэмжээ; - 09 дүгээр сарын 28-ны өдөр Олон улсын ахмадын өдөр; - 10 дугаар сарын 13-ны өдөр мод тарих; - 10 дугаар сарын 10-12-ны өдрүүдэд албан хаагчдыг витаминжуулах арга хэмжээ; - 10 дугаар сарын 24-ны өдөр цус хандивлах, ажлын байр цэцэгжүүлэх арга хэмжээ; - 12 дугаар сарын 19-ний өдөр “Шинэ жил 2018-2019” арга хэмжээ.  (Бүрэн хэрэгжсэн – 100%)
<b>Нийт: 4 стратегийн зорилт, 10 хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх 84 арга хэмжээ</b>				<b>Батлагдсан нийт төсөв: 1,945,892.0 мян. төгрөг</b>

## ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦЫН ТАНИЛЦУУЛГА

(Газрын даргын Үр дүнгийн гэрээ буюу байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан нийт ажлаар)

Төсвийн шууд захирагчийн Үр дүнгийн гэрээ буюу байгууллагын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан **84 арга хэмжээний** хэрэгжилтийг 2018 жилийн эцсийн дүнгээр гарган дүгнэв. Хэрэгжилтийн явцын дүнгээс дүгнэхэд, 2018 онд төлөвлөсөн нийт 84 зорилт (арга хэмжээ)-ын хэрэгжилтийн явц дунджаар **96.4 хувийн** гүйцэтгэлтэй байна. Хэрэгжилтийн дүнг тооцохдоо Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан үнэлгээний аргачлалыг баримтлан дүгнэв.

## Хэрэгжилтийн явцын дүн

Д/д	Хэрэгжилтийн явц (үнэлгээний хувь)	Заалтын тоо
1	<b>Нийт хэрэгжүүлэх арга хэмжээ</b>	<b>84</b>
2	Үүнээс: “Бүрэн хэрэгжсэн” – 100 %	73
3	“Хэрэгжих шатанд” – 70 %	10
4	“Хэрэгжилт хангалтгүй” – 30 %	0
5	“Хэрэгжээгүй” – 0 %	0
6	“Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй”	1
<b>7</b>	<b>Хэрэгжилтийн дундаж хувь (дундаж үнэлгээ) - 96.4 хувь.</b>	

Танилцсан:

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ГАНБАТ

Хянасан:

ДЭД ДАРГА

А.ДАГВАДОРЖ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Б. ГАВАА

Нэгтгэн боловсруулсан:

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Х.ЭНХЧИМЭГ